



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ  
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

# ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Улаанбаатар хот

2024 он

**Судалгааны тайлан боловсруулсан:**

Монгол Улсын Их Сургуулийн Хууль  
зүйн сургуулийн Эдийн засаг бизнесийн  
эрх зүйн судалгааны төв, профессорын  
баг

<b>Судалгааны багийн зөвлөх:</b>	Хууль зүйн доктор, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, профессор Б.Амарсанаа
<b>Судалгааны багийн ахлагч:</b>	Хууль зүйн доктор, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш Б.Оюунжаргал
<b>Судалгааны багийн гишүүд:</b>	Хууль зүйн доктор, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш Г.Давааням Хууль зүйн доктор, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш Б.Нинжин Хууль зүйн магистр, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Б.Баялагмаа Хууль зүйн магистр, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Р.Пүрэвбаатар Хууль зүйн магистр, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Д.Ганхүрэл МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Б.Анирмаа

## ГАРЧИГ

Судалгааны үндэслэл .....	4
Судалгааны хамрах хүрээ .....	5
Судалгааны арга.....	5
Судалгаагаар хүлээгдэж буй үр дүн .....	5
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих зохицуулалтын олон улсын чиг хандлага.....</b>	<b>6</b>
1.1 Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг зохицуулж буй олон улсын чиг хандлага .....	6
1.2 Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгааг явуулахад үүсэж буй сөрөг нөлөө, түүнийг зохицуулалт.....	10
1.3 Цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой олон улсад гарсан кейс (case-study).....	12
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. Бусад улс орнуудын цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалт.....</b>	<b>18</b>
2.1 Бүгд Найрамдах Солонгос Улсын цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын онцлог .....	18
2.2. Европын Холбоо, Канад Улс болон Ирланд Улсад цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын онцлог .....	25
2.3 ХБНГУ-ын цахим орчин дахь сонгуулийн зар сурталчилгаанд холбогдох зохицуулалт .....	28
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. Монгол Улс дахь сонгуулийн сурталчилгааг цахим орчин ашиглан явуулах зохицуулалт .....</b>	<b>30</b>
3.1 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн сонгуулийн сурталчилгаанд хамаарах нийтлэг зохицуулалт .....	30
3.2 Сонгуулийн сурталчилгааг цахим орчин ашиглаж явуулах зохицуулалтад хамаарах эрх зүйн хийдэл .....	32
3.3 Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын төслийн зохицуулалт.....	39
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах болон “deep fake”-тэй холбоотой зохицуулалтын онцлог .....</b>	<b>43</b>
4.1 Монгол Улсын Эрүүгийн хуулиар тодорхойлсон гэмт хэрэг, түүний онцлог .....	43
4.2 Европын Холбооноос гаргасан “deep fake”-д хамаарах бодлого, зохицуулалт .....	43
4.3 БНСУ-ын “deep fake video”-д хамаарах эрх зүйн зохицуулалт .....	44

4.4 АНУ-ын deep fake-д хамаарах эрх зүйн зохицуулалт.....	45
4.5 Франц Улсын “худал мэдээлэл тараах”-тай холбоотой эрх зүйн зохицуулалт .....	47
4.6 Худал мэдээлэл болон deep fake-ийг илрүүлж, сонгогчдод үнэн зөв мэдээлэл хүргэх чиглэлээр хөндлөнгийн мониторингийн хараат бус байгууллагыг дэмжиж ажиллах .....	49
ТАВДУГААР БҮЛЭГ. Олон нийтийн сүлжээний платформын сонгуулийн үеийн тусгай зохицуулалт .....	52
5.1 МЕТА (Facebook, Instagram болон бусад) хүсэлт, гомдлыг шийдвэрлэх процесс .....	52
5.2 X буюу Twitter-т илгээсэн хүсэлт, гомдлыг шийдвэрлэх процесс .....	54
5.3 Youtube хүсэлт, гомдлыг шийдвэрлэх процесс .....	55
Дүгнэлт.....	57
Зөвлөмж .....	59
Хавсралт 1. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтын судалгааг үндэслэж боловсруулсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын төсөл. ....	1
Хавсралт 2. Сонгуулийн сурталчилгааг цахим орчин ашиглаж явуулахтай холбоотой .....	11
гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага.....	11
Хавсралт 3. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журамд орсон нэмэлт өөрчлөлт болон тэдгээрийн үндэслэл. ....	14
Хавсралт 4. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журамд тагнуулын байгууллагаас ирүүлсэн саналыг тусгасан байдал. ....	48
Хавсралт 5. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журамд цагдаагийн байгууллагаас ирүүлсэн саналыг тусгасан байдал. ....	52

## ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

### Судалгааны үндэслэл

Монгол Улсад 2023 оны 01 дүгээр сарын байдлаар интернэтийн ашиглалт 84.3%-д хүрч, нийт 2,890,000 интернэт хэрэглэгчтэй байгаа нь 2022 онтой харьцуулахад тоон үзүүлэлт 1,5 дахин өсжээ.<sup>1</sup> Харин олон нийтийн сүлжээний платформ хэрэглэгчдийн тоо 2,6 сая байгаа нь нийт хүн амын 73% эзлэх<sup>2</sup> ба зөвхөн Facebook хэрэглэгчдийн тоо 2,3 саяд хүрээд<sup>3</sup> байна. Хүн хоорондын бодит харилцаанаас гадна мэдээлэл технологид суурилсан цахим орчин дахь харилцаа нь нийгмийн харилцааны салшгүй хэсэг нэгэнт болжээ. Цахим орчин дахь харилцаа өргөжихийн хэрээр тухайн харилцааг зохицуулах хууль эрх зүйн зохицуулалтыг шинээр батлах, эсхүл одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актыг цахим орчинд нэгэн адил дагаж мөрдөх зэргээр тухайн харилцааг зохицуулах шаардлага үүссээр байна. Үүний нэгэн адилаар, сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулахтай холбоотой зохицуулалтыг тодорхойлох шаардлага зүй ёсоор үүсэж байгаа бөгөөд үүнд сонгуулийн суурь зарчмын хэрэгжилт, нэр дэвшигч болон сонгогчийн эрхийг хамгаалах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон сонгуулийг шударга явуулах зарчмын тэнцвэрийг хангах, хүний хувийн мэдээллийг ашиглаж, түүн рүү чиглэсэн зорилтот зар сурталчилгааг явуулах замаар сонгуулийн үр дүнд нөлөөлөхөөс сэргийлэх, хувийн халдашгүй байдлыг хангах зэрэг багтана. Иймд дээрх асуудлуудыг зохицуулах боломжийг эрэлхийлж, зохицуулалтын хувилбарыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтад Захиргааны Ерөнхий хуулийн 60.1-т заасан хууль зүйн шаардлагыг хангаж, дотоодын хууль тогтоомжид нийцсэн байх шаардлага тавигддаг. Үүнээс гадна бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг судлах замаар цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг хэрэгжүүлэхэд үүсэж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох ба ингэснээр дотоодын болон гадаадын эрх зүйн зохицуулалтын судалгаанд үндэслэн журмын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл бүхий саналуудыг дэвшүүлэх нөхцөл бүрдэнэ.

Тиймээс цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих эрх зүйн орчны судалгааг хийж гүйцэтгэсний үндсэн дээр холбогдох харилцааг зохицуулж буй журмын зохицуулалтыг боловсронгуй болгох юм.

---

<sup>1</sup> Digital 2023: Mongolia, Data Reportal, <https://datareportal.com/reports/digital-2023-mongolia>

<sup>2</sup> *Ibid.*

<sup>3</sup> *Ibid.*

## **Судалгааны хамрах хүрээ**

Захиалагчийн ажлын даалгаварт дурдсан гүйцэтгэвэл зохих ажлын хүрээнд цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны олон улсын чиг хандлага, дотоодын хууль тогтоомж хоорондын нийцэл, олон нийтийн сүлжээний платформын бодлого болон бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтын судална.

## **Судалгааны арга**

Энэхүү судалгаа нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны зохицуулах зүйл болон түүний бүртгэл, хяналтын журмыг судална. Ингэхдээ одоо мөрдөгдөж буй олон улсын зохицуулалтын чиг хандлагыг харьцуулсан судалгааны арга зүй ашиглан судлах бөгөөд цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг зохицуулах оролдлогыг хийгээд буй олон улсын байгууллагуудын зөвлөмж болон Монгол Улстай төсөөтэй сонгуулийн тогтолцоотой орнуудын дотоодын эрх зүйн зохицуулалтыг түлхүү авч үзсэн. Цаашлаад, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа явуулах тухай журмыг тодорхой болгох үүднээс Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд эрх бүхий байгууллагуудын хоорондын уялдаа, чиг үүргийн хуваарилалт зэргийг эмперик арга зүй ашиглан судалсан. Мөн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаанд олон нийтийн сүлжээний платформ дахь сурталчилгаа зүй ёсоор орох тул тэдгээр платформуудын баримталдаг бодлого болон бусад улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд гомдол, саналыг хэрхэн шийдвэрлэдгийг судлан тусгасан.

## **Судалгаагаар хүлээгдэж буй үр дүн**

Энэхүү судалгааны үр дүнд олон улсад мөрдөгдөж буй цахим орчин дахь сонгуулийн болон бусад улс төрийн сурталчилгаа явуулах журмыг тодорхойлон, түүний үндсэн дээр дотоодын эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгож цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой тусгай зохицуулалтын журмыг боловсронгуй болгоно.

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих зохицуулалтын олон улсын чиг хандлага**

### **1.1 Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг зохицуулж буй олон улсын чиг хандлага**

Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа, эсхүл улс төрийн сурталчилгаа гэсэн нэр томъёог ашиглан сонгуулийн хугацаанд цахим орчин ашиглан сурталчилгаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Цахим орчин дахь улс төрийн сурталчилгаа (Online Political Advertising) нэмэгдэж буйтай холбоотойгоор эрх бүхий байгууллагаас тухайн харилцааг зохицуулах, хяналт тавих хүрээнд (1) сонгуулийн кампанит ажлын ил тод бус байдал болон хуурамч мэдээлэл, (2) кампанит ажлын сурталчилгааны санхүүжилтийг онлайнгаар хянах, (3) хувь хүний мэдээллийг ашиглаж, түүнд чиглэсэн сурталчилгаа явуулахаас сэргийлж мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлуудыг зохицуулах шаардлага үүсэж байна.<sup>4</sup> Мөн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг тусгайлан зохицуулах нь түгээмэл биш байгаа бөгөөд энэ нь тухайн улсын технологийн туршлага болон чадамжийн хязгаарлагдмал байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зайлсхийх нөхцөлүүд нөлөөлсөөр байна.<sup>5</sup> Үүнээс гадна нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй цахим орчинд үйл ажиллагаа явуулж буй платформын үйл ажиллагааг нэг улс дангаар зохицуулах боломжгүй, зохицуулалтын олон хувилбаруудыг дэвшүүлжээ. Тухайлбал, Оксфордын Их Сургуулийн багш Мишель Финкийн (Michèle Finck) тодорхойлсон платформын эдийн засгийг зохицуулах үндсэн гурван загварыг авч үзвэл,<sup>6</sup>

1. Уламжлалт буюу эрх бүхий байгууллагын хууль зүйн зохицуулалт (Traditional command-and-control approach).
2. Өөртөө удирдах хүрээнд дагаж мөрдөх зохицуулалт үүсгэх буюу хувийн хэвшлийн стандартууд тогтоож, сайн дурын үндсэн дээр дагаж мөрдөх буй зохицуулалт (Self-regulation).
3. Нийтийн болон хувийн хэвшлийн оролцогчдын хамтын зохицуулалт (Co-regulation) зэрэг багтаж байна.

Цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах харилцаанд сонгуулийн үйл ажиллагааны оролцогчдоос гадна, платформ оролцогч болох тул уламжлалт байдлаар буюу зөвхөн нэг улсын эрх зүйн актаар энэхүү харилцааг зохицуулах боломжгүй юм. Тиймээс

---

<sup>4</sup> International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA) “Winning elections the right way: Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally”, 2023.

<https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

<sup>5</sup> *Ibid.*

<sup>6</sup> Michèle Finck, Digital Co-Regulation: Designing a Supranational Legal Framework for the Platform Economy, LSE Legal Studies Working Paper No. 15/2017. [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=2990043](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2990043) дам ишлэв.



тухайн платформын баталж, дагаж мөрдөж буй зохицуулалт болон цаашлаад тэдгээрийн харьяалагдаж буй улсын хууль тогтоомжийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнээс гадна, цахим орчинд худал мэдээлэл тараахтай холбоотой мониторинг хяналт явуулдаг хувийн хэвшилтэй хамтран ажиллах зохицуулалтыг тохируулан хэрэглэх шаардлага үүсэж байна.

Улс орнуудын цахим орчин дахь улс төрийн сурталчилгаатай холбоотой харилцааг зохицуулсаныг харвал, дараах хувилбаруудад хуваагдаж байна: (1) Цахим болон цахим бус орчинд зохицуулалтгүй (2) Цахим орчин бус зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой зохицуулалттай (3) Цахим бус орчны зохицуулалтыг онлайн орчинд нэгэн адил дагаж мөрддөг (4) цахим орчны тусгайлсан зохицуулалттай.<sup>7</sup> Дэлгэрүүлбэл:

*Хүснэгт 1. Улс төрийн зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын хувилбарууд*<sup>8</sup>

**1. Улс төрийн сурталчилгаатай холбоотой зохицуулалт байхгүй**

Исланд – сонгуулийн сурталчилгаа, хугацааны хязгаарлалтын талаар зохицуулаагүй.

Люксембург – албан ёсны сонгуулийн кампанит ажил явуулах хугацаа, түүний хязгаарлалт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах талаарх зохицуулалт байхгүй. Улс төрийн нам болон хувийн хэвшилтэй гэрээ байгуулах замаар өөрсдөө зохицуулалт хийх механизмыг хэрэгжүүлдэг.

Швед – сонгуулийн кампанит ажил явуулах тодорхой хугацаа, хязгаарлалт байхгүй.

**2. Улс төрийн сурталчилгаатай холбоотой зохицуулалт нь зөвхөн тодорхой хэвлэл мэдээллийн хэрэгсэл рүү чиглэсэн зохицуулалттай (цахим орчин хамаарахгүй)**

Дани – Сонгуулийн кампанит ажлын хугацаанд телевизээр улс төрийн зар сурталчилгаа явуулахыг хориглох зохицуулалт үйлчилдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (цахим орчин дахь мөн хамаарна) болон онлайн платформыг зохицуулаагүй, хугацааны хязгаарлалт байхгүй.

Грек – Телевизээр төлбөртэй улс төрийн зар сурталчилгаа явуулахыг хориглодог, мөн түүнчлэн нийтийн болон хувийн хэвшлийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын үйл ажиллагааг өргөн хүрээнд зохицуулдаг. Олон нийтийн сүлжээний платформыг зохицуулсан зохицуулалт байхгүй. Онлайн зар сурталчилгаанд зарцуулсан санхүүгийн тайлангийн задаргааг хуульчлах шаардлагатай.

Итали – Үндэсний телевизээр төлбөртэй улс төрийн сурталчилгааг хориглодог. Харин орон нутгийн

<sup>7</sup> International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), “Winning elections the right way: Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally”, 2023. <https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

<sup>8</sup> *Ibid.*

	<p>телевизээр хязгаарлагдмал хэмжээгээр явуулахыг зөвшөөрдөг. Сонгуулийн чимээгүй үед холбогдох зохицуулалттай, гэхдээ цахим орчинд хамаарахгүй. Мөн цахим орчинд сонгуулийн сурталчилгаатай холбоотой харилцааг зохицуулаагүй, цахим платформууд ёс зүйн дүрэм дагаж мөрддөг.</p> <p>Норвеги – Улс төрийн сурталчилгаа хийх зорилгоор өргөн нэвтрүүлгийг худалдаж авахыг хориглодог. Сонгуулийн сурталчилгаанд холбогдох харилцааг зохицуулаагүй, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд тавигдах шаардлага, хугацааны хязгаарлалт байхгүй. Сонгуулийн хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрөө удирдах ёсны зохицуулалттай.</p> <p>Словени – Бүх төрлийн улс төрийн мэдээлэл, сурталчилгааг байрлуулсан этгээдийн мэдээлэл хаяглаж буюу тодорхой дурдсан байх шаардлагатай. Сонгуулийн сурталчилгаа дуусгавар болох чимээгүй хугацааг зохицуулсан. Гэвч дээрх зохицуулалтууд нь цахим орчинд хэрэгжихэд хүндрэлтэй. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тавих тогтолцоо байхгүй, гомдол гарвал ердийн журмаар хянана. Цахим орчин дахь зар сурталчилгаатай холбоотой гаргасан зардлыг намууд болон нэр дэвшигчид гаргаж болох хэдий ч нарийвчилсан задаргаа шаарддаггүй.</p> <p>Швейцарь – Сонин болон олон нийтийн сүлжээнээс бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн зар сурталчилгаа явуулахыг хориглодог. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрөө удирдах ёсны зохицуулалттай. Улс төрийн нам, нэр дэвшигчид хамаарах сурталчилгаанд хугацааны хязгаарлалт байхгүй.</p>
<p><b>3. Цахим бус орчны нийтлэг зохицуулалтыг цахим орчинд дагаж мөрддөг</b></p>	<p>Бельги – Сонгуулийн зар сурталчилгааны санхүүгийн тайлан олон нийтэд тайлагнадаг жишиг зохицуулалттай, гэхдээ цахим орчны сурталчилгааг нарийвчлан тайлагнахыг шаарддаггүй.</p> <p>Хорват – Цахим хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх хууль зүйн тодорхойлолт “олон нийтийн сүлжээний платформ” багтаагаагүй тул уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй нэгэн адил хяналт хэрэгжүүлэх боломжгүй.</p> <p>Чех – Улс төрийн зар сурталчилгааны хууль зүйн тодорхойлолтод цахим орчин дахь зар сурталчилгаа явуулах хэлбэр нэгэн адил хамаардаг. Санхүүжилтийн журмын зохицуулалтыг цахим</p>

	<p>болон цахим бус орчинд зар сурталчилгаа явуулахад дагаж аль алинд нь дагаж мөрддөг.</p> <p>Эстони – Өргөн нэвтрүүлгээр сонгуулийн сурталчилгаа явуулахыг хуулиар хориглосон хэдий ч хувийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио, болон цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой зохицуулалт байхгүй. Интернэт-сурталчилгаанд гаргасан зардлаар санхүүжилтийн тайлан хязгаарлагддаг.</p> <p>Португали – Сонгуулийн тов гарснаас хойш телевизээр төлбөртэй зар сурталчилгаа явуулахыг хориглодог. Чимээгүй үеийн зохицуулалттай. 2022 оны Парламентын сонгуулийг тов гарснаас хойш цахим орчинд төлбөртэй зар сурталчилгааг хориглосон. Гэсэн хэдий ч төлбөргүй контентыг зохион байгуулалттайгаар цахим орчинд байршуулах асуудал үүсэж болзошгүй болохыг тус тайланд дурджээ.</p>
<p><b>4. Цахим орчин дахь улс төрийн сурталчилгааны тусгайлсан зохицуулалттай</b></p>	<p>Канад - Сонгуулийн шинэчлэлийн тухай хууль (Canada's Elections Modernization Act)-д нь сонгуулийн хугацаанд цахим платформ дахь сурталчилгааны ил тод байдлыг хангах шалгуурыг зохицуулсан бөгөөд уг зохицуулалтад зар сурталчилгааг санд хадгалах, зар сурталчилгаанд төлсөн төлбөрийн мэдээлэл хамаарна.<sup>9</sup></p> <p>Ирланд - Сонгуулийн шинэтгэлийн тухай хууль (The Electoral Reform Act)-иар цахим орчин дахь улс төрийн сурталчилгаанд хяналт тавих үйл ажиллагааг Сонгуулийн хороонд хариуцуулж, цахим орчин дахь сонгуулийн мэдээлэл, хуурамч/шударга бус үйлдлүүдийг тодорхойлсон. Шинэ зохицуулалтын хүрээнд ил тод байдлыг хангах зорилгоор Үйлчилгээ үзүүлэгч платформ нь сурталчилгаа, мэдээлэл байршуулах захиалагчийг тодорхойлсон байх шаардлагыг тодорхойлсон.</p>

Дээрх хүснэгтээс харвал, эрх зүйн актаар цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг зохицуулаагүй улсад soft-law<sup>10</sup> механизмаар зохицуулах чиг хандлага давамгайлж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, Дани Улсад “Цахим орчин дахь улс төрийн сурталчилгааны ил тод байдлын ёс зүйн дүрэм”-ийг сонгуулийн оролцогчид буюу нэр дэвшигч, нам, цахим платформуос дагаж мөрддөг байна.<sup>11</sup>

<sup>9</sup> Elections Modernization Act, S.C. 2018, c. 31, Assented to 2018-12-13.

<sup>10</sup> Үүнд зарчим, зөвлөмжийн шинжтэй, зайлшгүй дагаж мөрдөх шаардлагагүй баримт бичиг хамаарна.

<sup>11</sup> International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), “Winning elections the right way: Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally”, 2023.

## 1.2 Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгааг явуулахад үүсэж буй сөрөг нөлөө, түүнийг зохицуулалт

Интернэт, олон нийтийн сүлжээний платформ болон хиймэл оюун ухаан зэрэг мэдээллийн технологийн хурдацтай хөгжил нь дэлхийн улс орнуудын сонгуулийн болон бусад ардчиллын үйл явцад эергээр болон сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, сонгуулийн удирдлагын байгууллагууд санал асуулгын явцад хяналт тавих, улс төрийн намууд сонгогчидтой шууд, ил тод харилцах боломжтой зэрэг эерэг нөлөөтэй боловч ардчиллын найдвартай, шударга байдалд шинэ төрлийн эрсдэлийг бий болгож байгаагаараа сөрөг нөлөөтэй.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас 2019 онд гаргасан судалгааны үр дүнд цахим орчин дахь сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гурван сөрөг үр дагаврыг тодорхойлсон. Үүнд:

- (1) Худал, ташаа болон үзэн ядсан өнгө аястай мэдээлэл түгээн дэлгэрүүлэх;
- (2) Сэтгүүл зүйн хараат бус байдал бий болох, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг айлган сүрдүүлэх, дарамт шахалт өгөх; болон
- (3) сонгуулийн сурталчилгаа, түүнд хамаарах харилцаа холбоог санаатайгаар таслан зогсоох зэрэг багтана.<sup>12</sup>

Уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой зохицуулалт нь цахим орчныг зохицуулахад хангалтгүй байх сул талтай.<sup>13</sup> Нөгөөтээгүүр цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны зохицуулалт нь үүсэж болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хязгаарласан, хориглосон хэм хэмжээг агуулсан байх тул мэдээлэл авах, түгээх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхтэй зөрчилдөх асуудал үүсэх тул үүнийг зохистойгоор шийдвэрлэх шаардлага үүсдэг. Улмаар “сонгуулийн сурталчилгаа”, “улс төрийн зорилготой сурталчилгаа” гэдэгт юуг ойлгох талаар үзэл баримтлал нь харилцан адилгүй, нэгдмэл бус байгаагаас үүдэж зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд асуудал үүсдэг ба хэт явцуу тодорхойлолт нь зохицуулалтын үр нөлөөг хязгаарлаж, хэт өргөн хүрээтэй тодорхойлолт нь үг хэлэх эрх чөлөөг хязгаарлахад хүргэдэг.<sup>14</sup>

Үүнээс үүдэн улс орнуудад цахим орчны онцлог шинжийг агуулсан тусгай зохицуулалтын шаардлага бий болсон бөгөөд сүүлийн жилүүдэд цахим орчин дахь сонгуулийн болон бусад улс төрийн сурталчилгааг зохицуулах оролдлогууд хийгдсээр

---

<https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

<sup>12</sup> UNESCO, Elections and Media in Digital Times, World Trends in Freedom of Expression and Media Development series, 2019.

<sup>13</sup> International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), “Winning elections the right way: Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally”, 2023.

<https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

<sup>14</sup> UNESCO, Elections and Media in Digital Times, World Trends in Freedom of Expression and Media Development series, 2019.

байна. Иймд, өөрсдийн дотоодын зохицуулалтыг хөгжингүй болгох зорилгоор олон улсын дараах зохицуулалтыг харгалзан үзэх нь зүйтэй.

**Нэн тэргүүнд**, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны тусгай зохицуулалтын хамрах хүрээг тодорхойлох шаардлагатай бөгөөд энэ нь дотоодын эрх бүхий байгууллагын эрх мэдлийн хүрээтэй шууд холбоотой. Учир нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны томоохон хэсгийг олон нийтийн сүлжээний платформ эзэлдэг ба тэдгээрийн үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгж нь ихэвчлэн гадаад улсын харьяалалтай байдаг. Иймээс өөрийн харьяаллын бус улсын хууль, эрх зүйн орчны зохицуулалтын хүрээнд багтахгүй юм. Харин олон нийтийн сүлжээний платформоос бусад цахим хуудас, вэбсайт зэргийн зохицуулалт, хяналт зэрэг нь тухайн улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд бүрэн багтах боломжтой.

*Хүснэгт 2. Цахим орчин дах улс төрийн сурталчилгааны зохицуулалтын агуулга*

Цахим орчин дахь улс төрийн зар сурталчилгааны тусгайлсан эрх зүйн зохицуулалтад дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:<sup>15</sup>

1. Улс төрийн сурталчилгаанд ямар төрлийн сурталчилгааг хамааруулах талаар, мөн тус зохицуулалтын дагаж мөрдөх харилцааны хамрах хүрээ;
2. Улс төрийн сурталчилгааны стандарт, түүнийг худалдан авч буй этгээдийг таньж тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд;
3. Зар сурталчилгааны мэдээлэл, даалгавар, санхүүжилтийн ил тод байдлыг бий болгох зорилгоор тавигдах шаардлагыг тодорхойлох;
4. Хууль ёсны төлөөлөгчийг томилох, сонгуулийн оролцогч талуудад тодорхой төрлийн мэдээллийг дамжуулах болон гомдлыг шийдвэрлэх, үүсэх эрсдэлийг үнэлэхтэй холбоотой харилцааг зохицуулах бодлогыг нийтэд мэдээлэх зэрэг үүргийг платформ (үйлчилгээ үзүүлэгч)-д үүсгэх;
5. Зар сурталчилгааны агуулгыг өөрөө ямар хэмжээнд зохицуулахыг тодорхой болгох, жишээлбэл: хориглогдсон зар сурталчилгааны агуулгыг тодорхойлох, зар сурталчилгагчдад хариуцлага хүлээлгэх, эсхүл хараат бус мониторингийн сүлжээний үйл ажиллагаа болон иргэний боловсролын кампанит ажлыг дэмжих зэрэг орно.

**Хоёрдугаарт**, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны зохицуулалт сайн боловсруулагдсан хэдий ч хяналтын байгууллагаас дэмжиж хэрэгжүүлэхгүй тохиолдолд үр дүнд хүрэхгүй.<sup>16</sup> Тухайлбал, улс төрийн нам болон нэр дэвшигчид нь цахим орчинд сурталчилгаа байршуулсантай холбоотой гарсан зардлаа тайлагнах үүргийг болон олон

<sup>15</sup> International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), “Winning elections the right way: Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally”, 2023. <https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

<sup>16</sup> *Ibid.*

нийтийн сүлжээний платформоор дамжуулан сонгуулийн сурталчилгаа явуулахад гарсан зардлыг тайлагнах задаргааны төрлийг бий болгох шаардлага үүсдэг.<sup>17</sup>

### **1.3 Цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой олон улсад гарсан кейс (case-study)**

Сонгогчид өдөр тутмын амьдралдаа олон нийтийн сүлжээний платформ түлхүү ашигладаг нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны ач холбогдлыг нэмэгдүүлж байна. Олон нийтийн сүлжээний платформ нь нэр дэвшигчдэд илүү өргөн хүрээний сонгогчдод хүрэх боломжийг, нөгөө талаас сонгогчид тэгш байдлаар мэдэх эрхээ хэрэгжүүлэх боломжтой тогтолцоог үүсгэдэг. Мөн томоохон өргөн нэвтрүүлэг болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг улс төрийн зорилготой цөөн хэдэн нөлөө бүхий этгээдүүд эзэмшдэг улс орнуудад, олон нийтийн сүлжээний платформ нь ижил үзэл бодолтой хувь хүмүүс нэгдэн өөрсдийн үзэл санааг хэлэлцүүлэх боломжийг олгодог. Үүний сацуу цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа нь харьцангуй өртөг багатай байна.

Гэсэн хэдий ч дэлхийн улс орнуудын сүүлийн үеийн сонгуулийн үйл явц нь олон нийтийн сүлжээний платформыг худал мэдээлэл тараах, хүний алдар хүндэд халдах зэрэг санаатайгаар хохирол учруулах зорилгоор ашиглаж болохыг харуулсан. Үүний дотор хиймэл оюун ухааны тусламжтайгаар бүтээсэн, сонгогчийн сэтгэл хөдлөлд шууд нөлөөлж болзошгүй хэтрүүлэгтэй эсвэл хуурамч мэдээллийг түгээн дэлгэрүүлэх оролдлогууд томоохон орон зайг эзэлж байна.<sup>18</sup> Эдгээр үйл ажиллагаа нь сонгуулийн сурталчилгааны зөрчилд тоцогдох ба сонгуулийн шударга байдлын зарчмыг алдагдуулах бүрэн боломжтой юм.

Олон нийтийн сүлжээний платформыг сонгуулийн сурталчилгааны үеэр дараах зорилгоор илүү ашиглаж байна. Үүнд:

- Ардчилсан институцид итгэх олон нийтийн итгэлийг сулруулж улс төрийн тогтворгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлэх зорилгоор хүчирхийллийг өөгшүүлсэн, үзэн ядсан үг хэллэгийг түгээн дэлгэрүүлэх;
- Нэр дэвшигчид, сэтгүүлчид болон бусад холбогдох этгээдүүдийг олон нийтийн сүлжээний платформоор нийтэд ил тодоор болон хувийн чатаар заналхийлэх, дарамтлах, дагаж мөшгөх;
- Нэр дэвшигчдийг заналхийлэх, гутаан доромжлох болон сонгогчдын үзэл бодолд нөлөөлөх зорилгоор хаяг, утасны дугаар, банкны картын мэдээлэл, эрүүл мэндийн мэдээлэл, цахим шуудангийн хаяг гэх зэрэг хувийн мэдээллийг олон нийтэд ил болгох (doxing);

---

<sup>17</sup> *Ibid.*

<sup>18</sup> UNESCO, Elections in Digital times: a Guide for electoral practitioners, 2022.

- Аливаа этгээдэд, эсвэл үйл ажиллагаанд хохирол учруулах зорилгоор худал, төөрөгдүүлсэн мэдээлэл түгээх;
- Троллинг буюу цахим орчинд сөрөг контентоор дамжуулан олон нийтийн дунд үймээн, маргаан, сөргөлцөөн үүсгэх зорилготой бүлэг хүмүүсийн өдөөн хатгалаг бүхий үйл ажиллагаа. Ингэхдээ хуурамч хаягаас сөрөг контент цацах ба ихэвчлэн тухайн хэлэлцүүлгийн сэдвээс гадуурх чиглэлтэй байна. Жишээ нь, өрсөлдөгчөө гутаан доромжлох, нэр төрийг нь унагаах зорилгоор троллыг ашигладаг;
- Эмэгтэйчүүд, сэтгүүлчид болон бусад улс төрийн цөөнхийн эсрэг цахим халдлага хийх. Үүнд интернэт болон бусад харилцаа холбооны хэрэгслийн үйл ажиллагааг санаатайгаар зогсоох, сонгууль, программ, вэбсайттай холбоотой агуулгыг шүүж, хязгаарлах, хууль бус тандалт хийх, мөрдөх, хакердах, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах зэрэг багтана.

Мөн сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалтад цахим сонгуулийн сурталчилгааны зохицуулалт багтаагүйн дээр тэдгээрийн ил тод байдал нь бүртгэлийн эсвэл хяналтын тогтолцоогоор баталгаажуулаагүй байна.<sup>19</sup> Бусад улс орнуудын сүүлийн үеийн сонгуулийн туршлагаас үзэхэд, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа нь бүртгэгдээгүй зарцуулалтын үндсэн дээр сурталчилгааны зардлыг хэтрүүлэх эрсдэлийг бий болгож байна. Өөр нэг эрсдэл нь сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой хөндөгдөж болохуйц хувь хүний нууцтай холбоотой асуудлууд юм.

Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, түүний дотор санхүүжилтийн эх үүсвэр, зорилтот бүлгийг сонгоход ашиглагдаж буй арга зүй, санхүүжилтийн түвшин, технологийн компаниудын харьяалагдаж буй улсын дотоодын хууль тогтоох болон бусад захиргааны байгууллагуудын өмнө хариуцлага хүлээх чадварыг нэмэгдүүлэх шаардлага тулгараад байна.

Үүнээс гадна, цахим орчин дахь сонгуулийн болон бусад улс төрийн сурталчилгааг зохицуулах талаар олон улсын түвшний хамтын ажиллагаа чухал бөгөөд энэ нь одоогоор дутагдалтай байгаа эрх зүйн зохицуулалтын салбарыг хөгжүүлэх ач холбогдолтой юм. Мөн одоогийн үйлчилж буй сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалтууд оффлайн буюу уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд зориулагдсан бөгөөд цахим орчин дахь сурталчилгааны онцлогийг төдийлөн харалзаж үзээгүй байна. Бусад оронд шийдвэрлэгдсэн тохиолдлоос харвал, дараах бэрхшээлүүдийг онцолж болохоор байна.

Кейс 1. Мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсыг ялгахтай холбоотой маргаан.

<sup>19</sup> B. Martin-Rozumilowicz and R. Kužel, Social Media, Disinformation and Electoral Integrity, IFES working paper, 2019.

2010 оны Бразил болон 2012 оны Мексик улсуудын сонгуулийн үеэр хоёр төсөөтэй маргаан үүссэн байна. Мексик улсын маргаан дээр, ерөнхийлөгчийн сонгуулийн нэр дэвшигч өөрийн твиттер хуудсанд ютуб дээр тавигдсан ярилцлагыг сонгуулийн сурталчилгаа эхлээгүй байхад байршуулсныг Мексик улсын сонгуулийн шүүх байгууллага сонгуулийн сурталчилгаа гэж үзээгүй ба хувь хүн өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн үйлдэл хэмээн шийдвэрлэжээ.<sup>20</sup> Харин Бразил улсын сонгуулийн дээд шүүх нь нэр дэвшигч сонгуульд өрсөлдөж байгаагаа өөрийн твиттер хуудсанд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлэхээс өмнө зарласныг хууль бус сонгуулийн сурталчилгаа гэж үзсэн байна.<sup>21</sup>

Эдгээр маргаанууд нь шүүхийн шатанд хүрч шийдэгдсэн бөгөөд аль аль нь сонгуулийн сурталчилгаа явуулахад ашиглагддаг уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон цахим хуудасны ялгааг өөр өөрөөр тодорхойлон ямар төрлийн үйлдэл нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны зөрчил гэж тооцогдох талаар тайлбар хийсэн байна. Дээрх улсуудын дотоод хууль тогтоомжийн зохицуулалт болон хэргийн үйл баримт ч ялгаатайг дурдах нь зүйтэй бөгөөд Мексик улсын нэр дэвшигч нийгмийн тулгамдаж буй асуудлуудаар өөрийн үзэл санааг илэрхийлэн ярилцлага өгсөн бол Бразил улсын нэр дэвшигч өөрийн бичвэртээ өөрт нь санал өгөхийг илт уриалсан байна.

Бразил улсын шүүхийн шийдвэрт, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа болон бусад уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан явуулж буй сурталчилгааны онцлог ялгааг тайлбарласан ба ингэхдээ өргөн нэвтрүүлгийн мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа нь олон нийтийн саналыг харгалзахгүй цацагддаг бол цахим орчин дахь сурталчилгааг тухайн хэрэглэгч өөрийн сонирхлын үндсэн дээр хайж олдгийг тусгайлан тодотгосон байна. Бразил улсын шүүх өөрийн тайлбартаа, хэдий цахим орчны хэрэглэгчид өөрсдийн сонирхлын дагуу мэдээллээ хайж олдог ч тухайн цахим платформын бүх хэрэглэгч тухайн сурталчилгааг харах бүрэн боломжтой хэмээн дүгнэжээ.

Кейс 2. Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой эрх зүйн зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох

<sup>20</sup> Institutional Revolutionary Party v. Andrés Manuel López Obrador (SUP RAP 0268 2012) (May 24, 2012) (Mexico), available at <https://electionjudgments.org/en/entity/4xu3lhyt9su>.

<sup>21</sup> Antonio Pedro de Siqueira Indio da Costa v. Public Electoral Ministry (No. 1825-24.2010.6.00.0000) (June 4, 2020) (Brazil), available at <https://electionjudgments.org/en/entity/93tllk9zpb6>.



Франц Улсын 2017 оны орон нутгийн сонгуулийн нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаа дуусах хугацаа өнгөрсний дараагаар өөрийн Facebook хуудсанд мөрийн хөтөлбөрөө танилцуулж буй зургаа нийтэлсэн байна. Тус улсын сонгуулийн төв хороо тухайн зургийг олон нийтийн үзэл санаанд нөлөөлөх боломжтой сонгуулийн сурталчилгаа гэж үзсэн бөгөөд 2017 оны орон нутгийн сонгуулийг цуцлах хүртэл арга хэмжээ авчээ.<sup>22</sup> Франц улсын сонгуулийн төв хорооны гаргасан үндэслэлээс олон нийтийн үзэл санаанд, цаашлаад сонгуулийн үр дүнд шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжтой байдал багтаж буй юм.

Франц Улсын маргааны дээрх жишээ нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын зөрчил болон тэдгээрт ноогдуулж буй хариуцлагын хэмжээг тодорхойлох шаардлагыг онцолсон байна.

Ижил төсөөтэй маргаан Молдова улсын 2018 оны орон нутгийг сонгуулийн үеэр гарсан бөгөөд мөн сонгуулийн сурталчилгааны хугацаа дууссаны дараагаар нэр дэвшигч өөрийн хувийн цахим хуудас дээр сонгуульд идэвхтэй оролцохыг уриалсан нийтлэлийг оруулсан байна. Молдова улсын анхан шатны шүүх тухайн нийтлэлийг сонгуулийн үр дүнд нөлөөлөх бүрэн боломжтой гэж үзсэн ба сонгуулийн үр дүнг хүчингүй хэмээн шийдвэрлэжээ.<sup>23</sup> Энэхүү шийдвэр нь дараа дараагийн шатны шүүхүүдэд дэмжигдсэн байна.

Франц, Молдова улсын туршлагаас үзвэл цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой маргааны онцлох хэсгүүд нь олон нийтийн сүлжээний платформд байршуулсан ямар нийтлэл сонгуулийн сурталчилгаанд тооцогдох болон тэдгээр нь олон нийтийн үзэл санаа цаашлаад сонгуулийн үр дүнд шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжит байдал зэрэг байна.

Маргаануудыг үзэхэд, улс болгонд цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны олон нийтэд нөлөөлөх байдлыг тогтоосон шалгуур гэхээсээ илүү тухайн нийтлэлийн агуулгаас хамааран бусдад нөлөөлөх боломжийг кейс болгон дээр тусгайлан шийдвэрлэсэн байна. Ингэхдээ тухайн нийтлэл нь (пост, зураг гэх мэт) сонгуульд ялалт байгуулах саналын тооны маржинтай харьцуулан хэчнээн хүнд хүрсэн зэргийг тооцоолон шийдвэр гаргадаг байна. Судлаачид Молдова улсын маргаан дээр гаргасан зөрчил болон түүнд ноогдуулсан

<sup>22</sup> Harle v. France (Décision n° 2017-5092 AN) (Dec. 18, 2017) (France), available at <https://electionjudgments.org/en/entity/k0vzxtsspak?page=1>.

<sup>23</sup> Appeals declared by the Political Party "Dignity and Truth Platform" and the electoral candidate Andrei Năstase, by Political Party "Party of Socialists of the Republic of Moldova" and by the Electoral Council of the Chisinau Municipal Electoral District No. 1, (Nr. 3ra-998/18) (June 25, 2018) (Moldova), available at <https://electionjudgments.org/en/entity/5hmve441cp>.

шийтгэл буюу сонгуулийн үр дүнг хүчингүйд тооцох нь хэт өргөн, тохиромжгүй байсныг дурджээ.<sup>24</sup>

Дээрх улсуудын шүүхийн практикаас үзэхэд, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг үнэлэх томоохон шалгуур нь түүний **нөлөөлөл** байх бөгөөд харин ямар зарчмаар нөлөөллийг тодорхойлох ойлголт нь нэгдмэл бус байна. Дэлгэрүүлбэл, олон улсын шүүхийн практикт нөлөөллийг харилцан адилгүй тодорхойлсон байх бөгөөд ингэхдээ хэрэг маргааны үйл баримт бүрээр тусгайлан авч үзсэн байна.

Харин онолын үүднээс болон олон нийтийн сүлжээний платформуудын баримтлах зарчмын үүднээс авч үзвэл дараах хувилбаруудыг тодорхойлж болохоор байна.

1. Онолын хувьд сонгуулийн сурталчилгаатай холбоотой нөлөөлөл гэдэг нь аливаа этгээд бусдын бодол, үйлдэлийг өөрчлөх чадварыг хэлнэ.<sup>25</sup> Харин цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны нөлөөллийг тодорхойлоход харгалзах шаардлагатай шалгуурыг Сонгуулийн тогтолцооны олон улсын сан тодорхойлсон.<sup>26</sup> Үүнд, олон нийтийн сүлжээний платформын цахим хуудасны дагагчийн тоо болон тухайн этгээдийн эсвэл цахим хуудас дахь мэдээллийн хандалтын тоог онцолжээ. Улс орон бүрийн хүн ам, эдийн засаг, нийгмийн ялгаатай байдлаас үүдэн дагагчийн тоог ерөнхийлөн тодоройлох боломжгүй бөгөөд гагцхүү зарим өгөгдлийг харгалзах шаардлага үүснэ. Тухайлбал, аливаа улсын нийт хүн ам болон олон нийтийн сүлжээний платформ хэрэглэгчдийн тоог үндэслэн зохимжит байдлаар хэдэн дагагчтай/хэрэглэгчтэй цахим хуудас нь нөлөөлөх чадвартайд тооцогдохыг гаргаж болно. Зарим улсад цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны нөлөөллийг тодорхойлохдоо тухайн сонгуулийн үр дүнд нөлөөлөх боломжийг мөн харгалзан үзсэн байна. Ингэхдээ аливаа цахим орчин дахь сурталчилгааны хандалтын тоог (энэ нь платформын онцлогоос хамаараад сурталчилгааг үзсэн хүний тоо, тухайн хуудасаны нийт дагагчийн тоо зэрэг байж болно) сонгуульд ялалт байгуулах боломжтой саналын тоотой харьцуулан гаргасан бөгөөд хэрэв сонгуульд ялалт

---

<sup>24</sup> Chad Vickery, David Ennis, Katherine Ellena & Alyssa Kaiser, When Are Elections Good Enough? Validating or Annulling Election Results, IFES (October 2018).

<sup>25</sup> Dalton & Anderson, Citizens, Context, and Choice: How context shapes citizens' electoral choices, Oxford University Press, 2010. J.Robinson, Interpersonal influence in Election Campaigns, Public opinion quarterly, 1976.

<sup>26</sup> International Foundation for Electoral Systems, Social media, Disinformation and Electoral Integrity, working paper, 2019.

байгуулахал шаардлагатай саналын тоотой хандалтын тоо тэнцсэн эсвэл илүү гарсан байвал тухайн сурталчилгааны нөлөөллийг өндөр хэмээн тодорхойлсон.<sup>27</sup>

2. Нөгөө талаас олон нийтийн сүлжээний платформууд нөлөөллийг хэрхэн тооцолдгийг авч үзэх нь зүйтэй. Олон нийтийн сүлжээний платформын нэг онцлог нь тухайн платформын хэрэглэгч өөрийн хуудасны хандалтын тоог үндэслэн орлого олох боломжтой байдагт оршино. Үүнээс үүдэн тухайн платформууд нөлөөллийн хүрээг тодорхойлоход орлогын хэмжээг харгалзан үздэг байна. Ингэхдээ, хандалтад ноогдох ашиг (cost per engagement - CPE) болон үйлдэлт ноогдох ашиг (cost per action - CPA) зэргийг түлхүү ашигладаг байна. Энэ нь тухайн мэдээлэлд өгсөн хандалт бүрт ноогдох ашгийг тодорхойлон улмаар хандалт, дагагчийн тоо зэргээр нөлөөллийн хэмжээг тооцоолоход ашиглагддаг байна.

#### **Товч дүгнэлт**

Олон улсын туршлагыг харахад, хэдий улс орнууд өргөн нэвтрүүлэг тэргүүтэй уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгддэг сонгуулийн сурталчилгааг зохицуулдаг боловч цахим орчин дахь сурталчилгааг төдийлөн үр дүнтэй зохицуулж чадахгүй байна. Мөн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа нь ардчилсан нийгмийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, ил тод байдал, эрх тэгш байдал, мэдэх эрх зэрэг суурь эрхтэй хэрхэн уялдаж байгааг тодруулах шаардлага үүсэж байна.

Мөн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаанд ямар төрлийн мэдээлэл ордгийг тусгайлан тодорхойлох шаардлагатай бөгөөд ингэхдээ сонгуулийн сурталчилгаа болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хоёрын зааг ялгааг мөн тодорхойлох ёстой.

Түүнчлэн, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг үнэлэх үндсэн нэг шалгуур нь түүний нөлөөлөл байх бөгөөд нөлөөллийг тодорхойлоход цахим орчин дахь мэдээллийн хамрах хүрээ буюу хандалтыг харгалзах шаардлагатай. Ингэхдээ, нийтлэг байдлаар бус өөрийн улс орны нийт хүн ам, тэр дундаа цахим орчин хэрэглэгчийн тоог харгалзан үзэх нь зүйтэй бөгөөд үүнийг үндэслэн хандалтын шалгуурын гаргах боломжтой юм.

---

<sup>27</sup> Франц улсын орон нутгийн сонгуулийн үеийн хууль бус цахим сурталчилгааны хандалт нь тус сонгуульд ялахад хангалттай саналын тоотой тэнцүү байсан улмаас тус сурталчилгааг сонгогчдийн үзэл бодолд нөлөөлсөн хэмээн үзэж сонгуулийн үр дүнг цуцласан шийдвэр гаргасан.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. Бусад улс орнуудын цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалт**

### **2.1 Бүгд Найрамдах Солонгос Улсын цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын онцлог**

БНСУ-ын 1994 онд батлагдсан Сонгуулийн тухай хууль 58 дугаар зүйлд зааснаар “Аливаа этгээд нь энэ хууль болон бусад хуульд хориглосон, хязгаарласан зохицуулалтад хамаарахаас бусад тохиолдолд сонгуулийн сурталчилгааг чөлөөтэй хийх боломжтой”. Өөрөөр хэлбэл, аль нэг нам, нэр дэвшигчийг дэмжих эсхүл эсэргүүцэх зэргээр цахим орчинд иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх боломжийг нээлтэй үлдээсэн.

Харин сонгуулийн сурталчилгааг явуулахыг хориглох, хязгаарлахтай холбоотой зохицуулалтын тухайд “сонгуулийн сурталчилгаа явуулах эрхгүй этгээд”<sup>28</sup>-ийг тодорхойлох замаар субъектээр нь хязгаарлалт бий болгосон бөгөөд энэ нь цахим орчинд явуулах сонгуулийн сурталчилгааны хувьд ч мөн хамааралтай юм. Түүнээс гадна ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон шударга сонгуулийн зарчмын хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл шударга, тэгш, үнэн бодит мэдээллийг нийтлэх үүрэгтэй байдаг бөгөөд энэ утгаараа цахим орчинд хэвлэл, мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгчдэд мэдээний шалгуурыг тавьдаг. Мөн БНСУ-ын Сонгуулийн тухай хуулийн 98 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгаанд өргөн нэвтрүүлэг ашиглахыг хориглодог. Улмаар интернэт (“цахим орчин”) хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгч нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч байх тохиолдолд үүнийг ашиглан сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг явуулах боломжгүй.

Сонгуулийн санал хураалтын өдрөөс бусад тохиолдолд аливаа этгээд нь цахим хуудас, хэлэлцүүлгийн самбар, чат өрөө гэх мэт бичгэн мэдээлэл болон дүрс бичлэг нийтлэх, цахим шуудангаар илгээх зэрэг аргаар сонгуулийн сурталчилгаа явуулах боломжтой бөгөөд интернэт хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нь сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглодог.<sup>29</sup>

### **Цахим орчинд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг.**

Интернэт хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нь шударга, тэгш сонгуулийн мэдээллийг нийтлэх зарчмын хүрээнд дараах үүргийг хүлээдэг.

1. Интернэт хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нь сонгуультай холбоотой мэдээллийг дамжуулахдаа агуулгын хувьд аль нэг нам, нэр дэвшигчид давуу болон сул талыг бий болгохоос зайлсхийж, шударга байх үүрэгтэй.

<sup>28</sup> Гадаадын иргэн, насанд хүрээгүй этгээд, сонгуулийн санал өгөх эрхгүй этгээд гэх мэт.

<sup>29</sup> БНСУ-ын Сонгуулийн тухай хууль 82 дугаар зүйлийн 6 дахь хэсэг.

2. Интернэт хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нь агуулгын бүтэц болон харьцааны хувьд нам, нэр дэвшигч тус бүрд зохимжит харьцаатай байлгах үүрэгтэй.
3. Интернэт хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нь нь бодит байдлыг мэдээлэхдээ объектив байдлаар хандах үүрэгтэй бөгөөд бодит байдал болон өөрийн үзэл бодол нь ялгагдаж байх ёстой.

### **Интернэт хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээлэлд тавих хяналт.**

Сонгуулийн тухай хуулийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Сонгуулийн төв хороо нь интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгчийн цахим хуудсанд тавигдсан сонгуулийн сурталчилгаа /нийтлэл, шүүмж, зураг, нэвтрүүлэг, дүрст бичлэг гэх мэт сонгуулийн агуулга бүхий мэдээлэл/-ны шударга байдлыг хангахын тулд байнгын үйл ажиллагаатай Интернэт дэх сонгуулийн мэдээллийн маргаан таслах комисс (цаашид “маргаан таслах комисс” гэх) байгуулан ажиллуулдаг. Маргаан таслах хорооны бүтэц, үйл ажиллагааг Сонгуулийн төв хорооноос баталсан “Интернэт дэх сонгуулийн мэдээллийн маргаан таслах комиссын бүтэц, үйл ажиллагааны дүрэм”-ээр зохицуулдаг.

### **Интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны хамрах хүрээ.**

Сонгуулийн тухай хуулийн 8.5 дугаар зүйлийг 1 дэх хэсэгт заасан интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа гэдэгт дараах цахим хуудсыг удирдаж, үйл ажиллагааг нь явуулдаг этгээдийг ойлгоно:

1. Хараат бус байдлаар мэдээ бэлтгэж, тогтмол нийтэлдэг “Сонингийн тухай хууль”-ийн 2 дугаар зүйлийн 2-р хэсэгт заасан интернэт сонингийн аж ахуй эрхлэгч<sup>30</sup>, “Интернэт мультимедиа өргөн нэвтрүүлгийн тухай хууль”-ийн 2 дугаар зүйлийн 5-р хэсэгт заасан интернэт мультимедиа өргөн нэвтрүүлгийн чиглэлээр арилжаа эрхлэгчийн эрхэлдэг цахим хуудас;
2. Сонин болон өргөн нэвтрүүлгийн аж ахуй эрхлэгч нь шууд удирддаг эсвэл тусдаа хуулийн этгээдээр удирдуулдаг дараах цахим хуудас:
  - a. Сонины тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3-д заасан<sup>31</sup> сонины арилжаа эрхлэгч эрхэлдэг цахим хуудас;
  - b. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3-т заасан;<sup>32</sup>
  - c. Түүнээс гадна дээрхтэй төстэй үйл ажиллагаа явуулж, хэвлэл мэдээллийн чиг үүрэг гүйцэтгэдэг цахим хуудсыг удирдаж, үйл ажиллагааны чиглэлээр арилжаа эрхлэгч;

<sup>30</sup> Цахим хэлбэрээр сонин тогтмол хэвлэл эрхлэгч.

<sup>31</sup> Сонин хэвлэлийн үйл ажиллагаа эрхлэгч.

<sup>32</sup> Ground wave broadcaster, кабелийн сүлжээний оператор, сансарын кабелийн сүлжээ, program provider, community radio broadcasting-ийн үйл ажиллагаа эрхлэгч.

- d. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3-т зааснаар өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэгчийн удирддаг цахим хуудас;
- e. Сэтгүүлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2-т зааснаар тогтмол хэвлэлийн удирддаг цахим хуудас;
- f. Мэдээлэл харилцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3-т мэдээлэл харилцааны үйл ажиллагааны талаар арилжаа эрхлэгчийн удирддаг цахим хуудас;
- g. 1, 2-т заасан интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгчээс хүлээн авсан мэдээллийг интернэтээр дамжуулан тогтмол нийтлэх, дамжуулах интернэт мэдээний үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч<sup>33</sup>-ийн удирддаг цахим хуудас;
- h. Дээрхээс гадна дээрхтэй төстэй хэвлэл мэдээллийн чиг үүргийг гүйцэтгэдэг цахим хуудас байна гэж маргаан таслах комисс үзсэн цахим хуудас.

Интернэт орчинд үйл ажиллагаа явуулж байгаа цахим хуудас мөн боловч дараах цахим хуудас нь интернэт хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчийн цахим хуудаст хамаарахгүй.

- 1. Нам болон нэр дэвшигч (нэр дэвшигч болох гэж байгаа этгээд) нь үүсгэж, үйл ажиллагааг нь явуулж байгаа цахим хуудас;
- 2. Сонгуулийн компани ажлыг гүйцэтгэж байгаа байгууллага, ажлын хэсгийн үүсгэж, үйл ажиллагааг нь явуулж байгаа цахим хуудас;
- 3. Дээрхээс бусад маргаан таслах комиссоос цахим хуудаст нийтэлсэн мэдээллийн агуулга болон үйл ажиллагаа явуулж байгаа байдлыг анхаарч үзсэний үндсэн дээр хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч гэж үзээгүй цахим хуудас;<sup>34</sup>

Тус маргаан таслах хорооны 2023.11.10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан “Интернэт дэх сонгуулийн мэдээллийг хянан шалгах шалгуурын тухай журам”-аар сонгуультай холбоотой мэдээлэл хянан шийдвэрлэхэд шаардлагатай харилцааг зохицуулдаг. Энэхүү журмаар цахим орчинд нийтлэгдсэн сонгуультай холбоотой шударга бус мэдээллийг хянан шийдвэрлэхэд маргаан таслах комиссоос баримтлах зарчим болон шалгуурыг ерөнхий, тусгай шалгуурыг тогтоосон. Ингэснээр нэг талаас сонгуулийн шударга бус мэдээлэлд юуг хамааруулж үзэх нь тодорхой болохоос гадна нөгөө талаас иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэхэд хязгаарлалт болохуйц нөхцөл байдал багасах юм.

**Маргаан хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал.**

<sup>33</sup> Цахим хэвлэлийн үйл ажиллагаа эрхлэгч.

<sup>34</sup> Үүнээс үзэхэд үүрэг хүлээсэн цахим хуудас мөн эсэхийг маргаан таслах комисс шийдэх боломжтой байна.

Интернэт дэх сонгуулийн мэдээллийн маргаан таслах комисс /Цаашид маргаан таслах комисс гэх/ нь сонгуулийн кампанит ажилтай холбоотой аливаа мэдээллийг хянан шийдвэрлэхдээ дараах нөхцөл байдлыг анхаарч үзнэ. Үүнд:

- Мэдээлэл нийтлэгдсэн хугацаа;
- Хэрэглэгчийн тооноос үүдэлтэй интернэт хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөөлөх байдал;
- Маргаан хянан шалгах шалгуурыг удаа дараа зөрчсөн эсэх зэрэг багтана.

Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаанд холбогдох маргааныг хянан шийдвэрлэхэд хуулиар “ерөнхий” болон “тусгай” шалгуурыг зохицуулсан. Үүнд:

*Хүснэгт 3. Маргаан хянан шалгах шалгуур үзүүлэлт*

Ерөнхий шалгуур	Тусгай шалгуур
1. Шударга, тэгш байдалтай холбоотой - Маргаан таслах комиссын бүтэц, үйл ажиллагааны дүрмийн 2-ын 2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу сонгуультай холбоотой аливаа мэдээлэл нь нэгдүгээрт, аль нэг нам эвсэл, нэр дэвшигчид давуу тал эсхүл сул талыг бий болгохгүй	1. Санал агуулгатай холбоотой- Сонгуулийн тухай хуулийн тухай хуульд заасан санал асуулгатай холбоотой шударга бус мэдээлэл. <sup>37</sup> 2. Ярилцлага болон эш татахтай холбоотой мэдээлэл; <sup>38</sup> 3. Зураг, дүрс бичлэгийн мэдээлэл <sup>39</sup>

<sup>37</sup> - Санал асуулгын үр дүнг хэтрүүлсэн, дарсан тайлбар хийх эсвэл мушгисан мэдээлэл;  
- Санал асуулгын үр дүнг тайлбарлахдаа аль нэг нам эсвэл нэр дэвшигчийн ялгаатай байдал нь итгэлцүүрийн хэмжээнд байсан ч хэт дээш эсвэл доошоо эрэмбэлэх гэх мэтээр хатуу тогтоосон мэдээлэл;  
- Санал асуулгын үр дүнг тэрхүү судалгааг явуулах болсон урьдчилсан нөхцөлөөс бүрэн өөр нөхцөл байдал ижил авч үзэж тайлбарласан мэдээлэл;

- Аль нэг нам эсвэл нэр дэвшигч хоорондын санал агуулгын дүнг видео, график, зураг, үзүүлэлт гэх мэтийг ашиглан хэт томруулсан эсвэл хэт багасгасан мэдээлэл;  
- Санал асуулгын үр дүнд хамаарахгүй баримт мэдээллийг шинжилж, санал асуулгын үр дүн мэт буруу ойлголт төрүүлсэн мэдээлэл;  
- Бусад дээрх мэдээллийн аль нэгд хамаарах мэдээлэл;

<sup>38</sup> - Сонгуультай холбоотой тодорхой хувь этгээд болон бүлгийн үзэл бодол эсвэл бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулагдсан мэдээний эх сурвалжийг дурдахгүйгээр бодит агуулгаас өөрөөр дахин нийтлэсэн, эш татсан мэдээлэл;

- Сонгуультай холбоотой ярилцлага хийсэн эсвэл эш татсан тохиолдолд сонгогчийг талцуулах хандлага эсвэл хариу үйлдлийг баланстай анхаараагүй мэдээлэл;

- Ярилцлага хийсэн талуудын илэрхийллийг мушгин гуйвуулж нэвтрүүлсэн, нийтлэсэн мэдээлэл;

<sup>39</sup> - Аль нэг нам эсвэл нэр дэвшигч хооронд зураг, дүрс бичлэг гэх зэргийг агуулсан мэдээнд хэт нэг талыг барьсан мэдээлэл;

- Аль нэг нам эсвэл нэр дэвшигчийн хувийн байдал, стиль эсвэл сонгуулийн кампанит ажлын нөхцөл байдал зэргийг мэдээлэхдээ тодорхой нам, нэр дэвшигчид давуу болон сул талыг бий болгосон мэдээлэл

<p>байх, хоёрдугаарт, мэдээллийн бүтцийн хувьд нам эвсэл, нэр дэвшигч хоорондын харьцаа зохистой байх үүрэг хүлээдэг учраас энэхүү үүргээ зөрчсөн мэдээлэл<sup>35</sup> нь маргаан таслах комиссоор хянан шийдвэрлэгдэх шаардлагатай байдаг.</p> <p>2. Объектив, үнэн бодит байдалтай холбоотой- Маргаан таслах комиссын бүтэц, үйл ажиллагааны дүрмийн 2-ын 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу сонгуультай холбоотой бодит байдлыг мэдээлэхдээ объектив байх ёстой бөгөөд бодит байдал болон өөрийн дүгнэлт нь ялгагдахуйц байх ёстой учраас үүнийг зөрчсөн</p>	<p>4. Цаг хугацааны шалгуур<sup>40</sup></p> <p>5. сурталчилгаа - интернэт хэвлэлийн хэрэгсэл нь хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд тодорхой нам, нэр дэвшигчид давуу болон сул талыг бий болгох боломжтой агууулга бүхий сурталчилгааг хийж болохгүй.</p>
---	---

<sup>35</sup> - Аль нэг нам эсвэл нэр дэвшигч /нэр дэвшигч болох магадлалтай этгээд цаашид мөн хамаарна/-ийг санаатайгаар нэг талыг барьж дэмсэн эсхүл эсэрхгүүцсэн мэдээлэл;

- Аль нэг нам эсвэл нэр дэвшигчийн үзэл бодол, хүсэл зориг, амлалт зэргийг тогтмол, давтамжтайгаар нийтлэж давуу эсхүл сул талыг бий болгосон мэдээлэл;

- Аль нэг нам эсвэл нэр дэвшигчийн сэтгэл хөдлөл, хэт нэг талыг барьсан хандлага тусгагдсан илэрхийллийг ашиглан дэмжих эсхүл эсэргүүцсэн мэдээлэл;

- Аль нэг нам эсвэл нэр дэвшигчтэй холбоотой мэдээллийг тодорхой шалтгаангүйгээр цахим хуудасныхаа аль нэг онцгой хэсэгт тогтмол байршуулж, онцолсон мэдээлэл;

- Тодорхой шалтгаангүйгээр аль нэг нам эсвэл нэр дэвшигчтэй холбоотой сурталчилгааны материал /тайлбар, постер, гарын авлага гэх мэт/-г онцлох эсхүл сурталчилгааны дүрст бичлэгийг шууд дахин нийтлэх эсвэл мэдээний дотор холбож, давуу болон сул талыг бий болгосон мэдээлэл;

- Сонгуультай холбоотой ярилцлага, хэлэлцүүлгийг хийх, дамжуулахад оролцогч тус бүрийн үндэслэлийн балансыг барьж чадаагүй мэдээлэл;

- Аль нэг нам эсвэл нэг дэвшигчид давуу болон сул талыг бий болгож болохуйц сэдвийг давтамжтайгаар нийтэлсэн;

- Түүнээс гадна дээрх агуулгад нийцсэн бусад мэдээлэл;

<sup>40</sup> - Интернэт хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь сонгуулийн хугацаанд тодорхой нам эсвэл нэр дэвшигчид давуу болон сул талыг бий болгох боломжтой тусгай мэдээлэл хийж болохгүй.

- Интернэт хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь сонгуулийн санал хураалт болохоос өмнө 90 хоногоос сонгуулийн өдөр хүртэл тодорхой нам эсвэл нэр дэвшигчид давуу болон сул талыг бий болгох боломжтой нэр дэвшигчийн нэрээр санал, сэтгэгдэл, дүгнэлт зэргийг бичихийг хориглоно.



мэдээллийн <sup>36</sup> хувьд маргаан таслах комиссоор хянан шийдвэрлэгдэх үндэслэл болно.	
---	--

Маргаантай холбоотой асуудлыг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Маргаан таслах комисс шийдвэрлэх бөгөөд цахим орчинд байршуулсан зар сурталчилгааны агуулгыг хянах зохицуулалттай. Интернэт орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах бүртгэлтэй цахим хуудас нь бодит үнэнд нийцсэн мэдээллийг сонгогчдод хүргэх, аль нэг нэр дэвшигчид давуу байдал бий болгохгүй байх, тэнцвэрийг хадгалах үүргийг хуулиар хүлээлгэсэн.

### **Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа.**

Шударга бус мэдээллээс үүдэлтэй зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр зөвхөн тухайн нам эсвэл нэр дэвшигч нь гомдол гаргах эрхтэй. Зөрчигдсөн эрх сэргээгдэх аргын хувьд няцаалт хийх хүсэлт, эсрэг мэдээлэл нийтлүүлэх хүсэлтээр дамжуулсан сэргээгдэх боломжтой. Няцаалт хийх хүсэлт - интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгч нь сонгогчийн шийдвэрт нөлөөлж болохуйц, чухал ач холбогдолтой бодит байдлыг хэтрүүлсэн, товойлгосон эсхүл багасгасан, бүдгэрүүлсэн гэх мэт мушгин гуйвуулсан мэдээлэл эсвэл худал мэдээллээр нэр дэвшигчид хохирол учруулсан тохиолдолд няцаалт өгөх хүсэлтээр дамжуулан зөв болгож засварлагдсан мэдээллийг нийтлэх байдлаар сэргээнэ.

Нэр дэвшигч нь цахим орчин дахь сонгуулийн мэдээллийг шударга бус байна гэж үзсэн тохиолдолд уг мэдээллийг олж мэдсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор маргаан таслах комисст няцаалт хийх хүсэлт өгөх боломжтой байдаг. Эсрэг мэдээллийг нийтлэхийг шаардах- мушгин гуйвуулсан мэдээллээс үүдэлтэй хохирол үүссэн тохиолдолд нэр дэвшигч нь уг мэдээллийг олж мэдсэнээс хойш 10 өдрийн дотор, нийлэгдсэнээс хойш 30 хоногийн дотор тухайн интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгчид нийтлэгдсэн агуулгын эсрэг мэдээллийг нийтлэхийг шаардах эрхтэй. Хэрэв интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгч нь сонгуулийн холбогдох мэдээллийн агуулгын эсрэг мэдээллийг нийтлэхээс татгалзсан, тохиролцож чадаагүй тохиолдолд маргаан таслах комисст эсрэг

---

<sup>36</sup> - Сонгогчдын шийдвэрт нөлөөлөх боломжтой бодит байдлыг хэтрүүлэх, товойлгох эсвэл багасгах, бүдгэрүүлсэн мэдээлэл;

- Аль нэг нам эсвэл нэр дэвшигчийн талаарх худал мэдээлэл
- Гүйцэтгэх ажил үүрэгтэй нь ямарч холбоогүй бодит байдлыг онцгойлж, нэр дэвшигч болон түүний эхнэр, нөхөр, хамаатан садан, ах дүүг гүжирдэх;
- Аль нэг нам эсвэл нэр дэвшигчийн бодлого эсвэл амлалтыг харьцуулан үнэлж, үр дүнгээр эрэмбэлэх, үнэлгээний үндэслэлтэй байдал болон обьектив байдлын нотолгоогүй мэдээлэл;
- Сонгуулийн үр дүнгийн талаар үндэслэлгүй таамагласан мэдээлэл;
- Гарчиг болон агуулга зөрөөтэй багасгаж, бүдгэрүүлсэн эсвэл мушгин гуйвуулсан мэдээлэл;
- Түүнээс гадна дээрх агуулгын аль нэгд хамаарах мэдээлэл;

мэдээллийг нийтлэхийг шаардах эрхээ хамгаалуулах хүсэлт гаргаж баталгаа авах боломжтой.

### **Гомдол гаргах эрх бүхий этгээд: Нам, нэр дэвшигч**

Интернэт дэх сонгуулийн мэдээллийн маргаан таслах ажиллагаа нь дараах процесс, дарааллаар явагддаг. Үүнд:

- Гомдол бүртгэх;
- Урьдчилсан нөхцөл хангасан эсэх шинжилгээ хийх;
- Маргаан таслах комиссын хурал товлох;
- Интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгчийн тайлбар, үндэслэл авах;
- Хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөрчигдсөн эрх сэргээх ажиллагаа:
  - ◆ Няцаалт хийх хүсэлт - шууд биелүүлэх
  - ◆ Эсрэг мэдээлэл нийтлэхийг шаардах - 48 цагийн дотор
- Шударга бус мэдээлэл нийтэлсэн Интернэт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгчид арга хэмжээ авах:
  - ◆ Засварласан мэдээлэл нийтлэх- хянан шийдвэрлэх ажиллагааны явцад засварлах шаардлагатай агуулга тодорхой байгаа нөхцөл
  - ◆ Анхааруулга нийтлэх:
    - Сонгуулийн үр дүнд нөлөөлөх боломжтой чухал ач холбогдолтой бодит байдлыг аль нэг нам, нэр дэвшигчид давуу эсвэл сул тал үүсгэх зорилгоор хэтрүүлэх эсхүл багасгах зэргээр мушгин гуйвуулсан тохиолдол;
    - Тодорхой нам, нэр дэвшигчийн талаар худал мэдээлэл эсвэл дайрч доромжилсон яриа нийтэлсэн;
    - Анхааруулах мэдэгдэл өгсөн боловч шийдвэрлэхгүйгээр хууль зөрчсөн үйлдлээ үргэлжлүүлсэн, давтсан тохиолдол;
    - Маргаан хянан шалгах шалгуурыг зөрчсөн байдал нь сонгуулийн үр дүнд ноцтой хэмжээнд нөлөөлөхөөр байгаа гэж үзсэн тохиолдол;
  - ◆ Анхааруулах
    - Тодорхой нам, нэр дэвшигчид давуу эсвэл сул тал үүсгэх зорилгоор нийтэлсэн тохиолдол;
    - Маргаан хянан шалгах шалгуурыг зөрчсөн байдал нь ялимгүй нөлөөлөх тохиолдол;
    - Сануулах мэдэгдэл өгсөн боловч ижил хэлбэрээр зөрчилтэй мэдээллийг давтаж нийтэлсэн;
  - ◆ Сануулах

- Маргаан хянан шалгах шалгуурыг зөрчсөн байдал нь ялимгүй гэж үзсэн тохиолдол
- Интернет хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгч болон гомдол гаргасан этгээдэд шийдвэрийг мэдээлэх зэрэг багтана.

Дүгнэвэл, БНСУ-ын цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны зохицуулалт нь нарийн бөгөөд харин аливаа зөрчил гарсан тохиолдолд авч буй арга хэмжээ нь тухайн үйл ажиллагаа эрхлэлчийг хязгаарлах гэхээс илүү үүссэн хохиролыг хурдан шуурхай арилгахад чиглэсэн байна.

## **2.2. Европын Холбоо, Канад Улс болон Ирланд Улсад цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалтын онцлог**

Канад Улсын Сонгуулийн шинэчлэлийн тухай хууль (Canada's Elections Modernization Act) нь сонгуулийн хугацаанд цахим платформ дахь сурталчилгааны ил тод байдлыг хангах шалгуурыг зохицуулсан бөгөөд уг зохицуулалтад зар сурталчилгааг санд хадгалах, зар сурталчилгаанд төлсөн төлбөрийн мэдээлэл хамаарна.<sup>41</sup> Харин Ирландын Сонгуулийн шинэтгэлийн тухай хуулиар (The Electoral Reform Act) цахим орчин дахь улс төрийн сурталчилгаанд хяналт тавих үйл ажиллагааг Сонгуулийн хороонд хариуцуулсан ба цахим орчин дахь сонгуулийн мэдээлэл болон хуурамч, шударга бус мэдээлэл, түүнд хамаарах үйлдлүүдийг тодорхойлсон. Шинэ зохицуулалтын хүрээнд ил тод байдлыг хангах зорилгоор Үйлчилгээ үзүүлэгч платформ нь сурталчилгаа, мэдээлэл байршуулах захиалагчийг тодорхойлсон байх шаардлагатай.<sup>42</sup>

1. Улс төрийн сурталчилгааны хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:
  - Канад Улсын Сонгуулийн шинэчлэлийн тухай хуульд зааснаар шаардлага хангасан улс төрийн сурталчилгаанд бүртгэлтэй улс төрийн нам эсхүл нэр дэвшигчид хамааралтай асуудлаар дэмжсэн болон эсрэг байр суурь илэрхийлсэн олон нийтэд чиглэсэн сурталчилгааны мэдээллийг ойлгох ба кампанит ажлын сэдвүүдтэй холбоотой мэдээлэл нь мөн сурталчилгаанд хамаарна.

---

<sup>41</sup> International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), “Winning elections the right way: Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally”, 2023. <https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

<sup>42</sup> International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), “Winning elections the right way: Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally”, 2023. <https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

- EU ТТРА Европын парламент болон Зөвлөлийн улс төрийн зар сурталчилгааны ил тод байдал болон зорилтот байдлыг зохицуулалтын санал (Proposal for a Regulation of the European Parliament and the Council on transparency and targeting of political advertising)-д<sup>43</sup> дээр дурдсан агуулгыг багтаана. Гэхдээ улс төрийн намын платформтой шууд холбодоггүй, харин нэр дэвшигч өөрийн нэрээр, эсхүл түүний нэрийн өмнөөс болон сонгогчдийн сонголтот нөлөөлөх боломжтой агуулга бүхий зар сурталчилгаа хамаардаг.
- Ирландын Сонгуулийн шинэтгэлийн тухай хуульд зааснаар сонгуулийн хугацаанд улс төрийн зорилгоор платформыг төлбөр төлж ашиглах буюу тухайн платформыг бусадтай харилцахдаа улс төрийн зорилгоор харилцан мэдээлэл солилцох, түгээх, байдлаар ашиглаж байгааг ойлгоно.

2. Сонгуулийн сурталчилгаа явуулж буй этгээдийг таньж баталгаажуулахад холбогдох зохицуулалт.

- Канад Улсын Сонгуулийн сүлжээний хууль зар сурталчилгааг худалдан авч буй этгээдийг таньж тодорхойлох буюу худалдан авагчтай холбогдоход шаардагдах мэдээлэл болох нэрний бүртгэлийг хөтлөх үүргийг цахим сүлжээний платформд шилжүүлж, таньж тодорхойлох ажиллагааг платформаар гүйцэтгүүлдэг.
- Европын Парламент болон Европын Зөвлөлийн улс төрийн зар сурталчилгааны ил тод байдал болон зорилтот байдлыг зохицуулалтын саналд дурдсанаар цахим сурталчилгаа явуулж буй цахим сүлжээний платформ нь сонгуулийн сурталчилгааг захиалж буй этгээдийг урьдчилан таньж баталгаажуулах ажиллагааг явуулах бөгөөд ямар хэлбэр ашиглахыг өөрөө удирдах зохицуулалтаар (self-regulation) зохицуулна.
- Ирланд Улсын Сонгуулийн шинэтгэлийн хуулиар цахим сурталчилгааг байршуулах олон нийтийн сүлжээний цахим хуудасны эзэмшигч нь тухайн улсын оршин суугч биш тохиолдолд өөрийн хаяг дээрээ шууд болон шууд бус байдлаар сонгуулийн сурталчилгааг байршуулах, дэмжлэг үзүүлэх, түгээх ёсгүй болохыг тодорхойлсон. Ирланд Улсын иргэн биш тохиолдолд олон нийтийн сүлжээний платформ дахь өөрийн цахим хуудсанд сонгуулийн сурталчилгааг явуулах боломжгүй байна.

<sup>43</sup> Proposal for a REGULATION OF THE EUROPEAN PARLIAMENT AND OF THE COUNCIL on the transparency and targeting of political advertising, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A52021PC0731>

3. Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны ил тод байдалтай холбоотой зохицуулалт:<sup>44</sup>
- Канад болон Ирланд улсын сонгуулийн хуулиудад цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны мэдээллийн сантай байх талаар зохицуулт орсон. Тухайлбал, Канад улсын хуулиар цахим сүлжээний платформ нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны мэдээллийг 2 жилийн хугацаанд нээлттэй байршуулж, өөрсдийн мэдээллийн санд 5 жилийн хугацаанд хадгалах үүргийг хүлээдэг. Харин Ирланд улсын зохицуулалтын хүрээнд сонгуулийн сурталчилгаатай холбогдох мэдээллийг 7 жилийн хугацаанд тухайн платформ дээр нээлттэй байршуулах үүргийг цахим сүлжээний платформ хүлээдэг.
  - Нээлттэй байршуулах мэдээлэлд цахим орчин дахь улс төрийн сурталчилгааны мэдээлэл, түүнийг худалдан авсан, төлбөр төлсөн этгээдийн мэдээлэл буюу санхүүжүүлсэн улс төрийн нам, нэр дэвшигчийн мэдээлэл хамаарна.
4. Цахим сүлжээний платформ нь цахим сонгуулийн сурталчилгаанд баримтлах бодлоготой байх агуулгад хамаарх зохицуулалт:
- Цахим сүлжээний платформ нь цахим сурталчилгаанд хамаарах бодлогыг тодорхойлж, тухайн бодлогыг зөрчиж буй талаарх хэрэглэгчээс ирүүлсэн гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, платформ өөрөө шийдвэрлэх зохицуулалттай байна.
  - Европын Холбооны “Цахим үйлчилгээний тухай” хуульд (Digital Service Act)<sup>45</sup> дурдсанаар, цахим орчинд байршуулсан эрсдэлтэй мэдээллийг дөрвөн шатлалд ангилдаг. Үүнд:
    - 1-р ангилалд, үзэн ядсан үг хэллэг, хууль бус бүтээгдэхүүн худалдах, хүүхдийн бэлгийн хүчирхийлэл зэрэг хууль бус агуулгыг бүхий мэдээлэл,
    - 2-р ангилалд, хүний үндсэн эрхийг хэрэгжүүлэх шууд болон дам байдлаар нөлөөлсөн мэдээлэл,
    - 3-р ангилалд, “сонгуулийн зарчим”, ардчиллын үнэт зүйлд, нийтийн аюулгүй байдалд бодит эсвэл дам байдлаар сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээлэл,

---

<sup>44</sup> Thijs Heinmaa, WINNING ELECTIONS THE RIGHT WAY Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally, 2023. <https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

<sup>45</sup> European Union, The Digital Services Act <https://digital-strategy.ec.europa.eu/en/policies/digital-services-act-package>

- 4-р ангилалд, хувь хүний бие махбодын болон сэтгэл зүйн байдалд сөрөг нөлөөлөх үзүүлэхүйц байдлаар платформыг загварчлах буюу буруугаар ашиглах эсхүл жендэрт суурилсан хүчирхийлэл агуулсан мэдээлэл тус тус хамаардаг.

Эдгээр агуулга бүхий мэдээллийг платформ байршуулсантай холбоотой авах арга хэмжээг платформ бодлогоороо зохицуулах боломжтой юм.

5. Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны агуулгад хамаарах зохицуулалт:<sup>46</sup>

- Хуулиар цахим орчинд сурталчлахыг хориглосон хэм хэмжээг тодорхойлдог.
- Канад Улсын Сонгуулийн шинэчлэлийн тухай хуульд “Аливаа этгээд сонгуулийн үр дүнд нөлөөлөх зорилгоор сонгуулийн хугацаанд худал мэдээлэл, ялангуяа нэр дэвшигчийг гэмт хэрэгт шалгагдаж байгаа, төрсөн газар, боловсрол, мэргэшил, гишүүнчлэлийн талаарх болон сонгуульд нэр дэвшихээс татгалзсан тухай худал мэдээлэл тараахыг хориглоно” хэмээн зохицуулсан.
- Ирланд Улсын Сонгуулийн шинэтгэлийн тухай хуулиар сонгуулийн хугацаанд цахим орчин дахь худал мэдээлэл хяналт тавих эрхийг Сонгуулийн хороонд олгосон.

Товч дүгнэлт.

Канад болон Ирланд Улсын сонгуулийн хууль тогтоомжоор цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг зохицуулахдаа дараах 5 агуулгыг багтаасан байна. Үүнд:

1. Сонгуулийн сурталчилгааны хамрах хүрээ,
2. Сонгуулийн сурталчилгааг захиалж буй этгээдийг таньж баталгаажуулах
3. Сонгуулийн сурталчилгааны ил тод байдлыг хангах
4. Олон нийтийн сүлжээний платформ бодлоготой байх
5. Хуулиар хориглосон сонгуулийн сурталчилгааны агуулгыг тодорхойлсон.

Дээрхээс үзвэл, хуулийн зохицуулалтад эрх бүхий байгууллагын чиг үүргээ гадна олон нийтийн сүлжээний платформд хуулиар үүрэг ногдуулахаас гадна өөрөө удирдах бие даасан зохицуулалтыг баталж, хэрэгжүүлэх замаар сонгуулийн сурталчилгааны хяналтыг бий болгож байна.

### 2.3 ХБНГУ-ын цахим орчин дахь сонгуулийн зар сурталчилгаанд холбогдох зохицуулалт

ХБНГУ-д цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаанд холбогдох харилцааг зохицуулсан тусдаа эрх зүйн акт байхгүй ч бодит орчны харилцааг зохицуулсан хууль

<sup>46</sup> *Supra note 40.*

тогтоомжийг цахим орчинд нэгэн адил дагаж мөрдөх хувилбарыг хэрэгжүүлдэг онцлогтой. Цахим орчинд хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Сүлжээнд хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль” (NetzDG)-ийг дагаж мөрддөг.<sup>47</sup> Тус хуульд зааснаар олон нийтийн цахим сүлжээний платформ нь сонгуулийн сурталчилгааны үе эсэхээс үл хамаарч хууль бус агуулгатай мэдээллийг (“хууль бус контент” гэх) байршуулсан талаар аливаа мэдэгдэл ирснээс хойш 24 цагийн дотор устгах, хаах үүрэг хүлээдэг бөгөөд хуульд заасан үүрэг зөрчсөн тохиолдолд торгуулийн хариуцлага хүлээлгэдэг.

“Сүлжээнд хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль” нь аливаа контентийн хууль бус байдлыг шалгах шалгуурыг ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн заалт руу шилжүүлсэн байх бөгөөд цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой дараах агуулга бүхий контентыг хориглосон байна.<sup>48</sup>

- Доромжлох
- Гүтгэх
- Ёс бус үг хэллэг хэрэглэх
- Гэрэл зураг дарах болон бусад зэргийн хэрэгслээр хувь хүний нууцад халдах.

Товч дүгнэлт.

Улс орон харилцан адилгүй байдлаар сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах эрх зүйн орчныг тодорхойлж байгаа хэдий ч дараах зохицуулалтууд нийтлэг байна.

Үүнд:

- Цахим орчинд сонгуулийн сурталчилгааг явуулах сонгуулийн зарчмыг дагаж мөрдөнө.
- Цахим орчинд үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллага аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчид давуу байдлыг олгохгүй бөгөөд тэнцвэрийг хадгална.
- Цахим орчинд сонгуулийн сурталчилгааг явуулж буй этгээдийг таньж тодорхойлох арга хэмжээг зайлшгүй авна.
- Сонгуулийн сурталчилгаанд хамаарах агуулга, хориглосон хэм хэмжээг тодорхойлно.
- Сонгуулийн сурталчилгааг хэзээ байршуулсан, хэдэн хүнд хүрсэн, сонгуулийн үр дүнд нөлөөлж буй эсэх зэрэг шалгуурыг тодорхойлох замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон сонгуулийн үйл ажиллагааг шударгаар зохион байгуулах тэнцвэрийг хангана.
- Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа ил тод байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Олон нийтийн цахим сүлжээний платформуос өөрөө удирдах буюу self-regulation баталж, хэрэгжүүлнэ.

<sup>47</sup> Thijs Heinmaa, WINNING ELECTIONS THE RIGHT WAY Online Political Advertising Rules in Europe and Selected Countries Globally, 2023. <https://www.idea.int/sites/default/files/2023-11/winning-elections-the-right-way-online-political-advertising-rules.pdf>

<sup>48</sup> ХЗҮХ “Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал” судалгааны тайлан, 2022 он.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. Монгол Улс дахь сонгуулийн сурталчилгааг цахим орчин ашиглан явуулах зохицуулалт**

### **3.1 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн сонгуулийн сурталчилгаанд хамаарах нийтлэг зохицуулалт**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (цаашид “Сонгуулийн тухай хууль” гэх)-ийн 7-р зүйлд сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг хуульчилсан бөгөөд тус зарчмыг цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахад нэгэн адил баримтлах нь зүйтэй.

- Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэгэн төлөөлөлгүйгээр оролцож, саналаа нууцаар гаргана.
- Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгууль оролцогч нам, эвсэл, бусад байгууллага, түүний албан тушаалтан сонгууль зохион байгуулах, түүнд оролцохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - Хууль дээдлэх,
  - Ил тод байдлыг хангах,
  - Шударга ёсыг сахих зэрэг багтана.

Хуульд дээдлэх зарчимд үндсэн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны зохицуулалт нь хуульд нийцсэн байх шаардлагатай. Сонгуулийн тухай хуулийн 5.4, 5.6-д зааснаар сонгогч нь хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зорилгоо илэрхийлж саналаа өгөх боломжоор хангагдсан байх бөгөөд сонгогчоос саналаа чөлөөтэй өгөхөд нь хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглосон. Гэтэл тус хуулийн 47 дугаар зүйлд цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахад сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны материалыг цахим хэлбэрээр буюу цахим шуудангаар оролцогчдод хүргүүлж болохыг “онцлог” зохицуулалтыг тусгасан. Энэ тохиолдолд сонгогчийн хувийн халдашгүй байдлыг хэрхэн хангах, сонгогчийн хувийн мэдээллийг хамгаалах, түүн рүү чиглэсэн зорилтот сурталчилгаанаас урьдчилсан сэргийлэхтэй холбоотой авах арга хэмжээг зохицуулаагүй үлдээсэн бөгөөд журмаар үүнийг зохицуулах шаардлага үүсэж байна.

**Сонгуулийн сурталчилгааны хэлбэрийг<sup>49</sup> дараах байдлаар тодорхойлсон бөгөөд үүнээс өөр хэлбэрээр сурталчилгааг явуулахыг хориглоно. Үүнд:**

- Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах

---

<sup>49</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39.2 дахь хэсэг



- Хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж, талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах
- Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх
- Ухуулах байр ажиллуулах
- Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах
- Цахим орчин ашиглах
- Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх

**Сонгуулийн сурталчилгаа явуулж буй нэр дэвшигчийг тодорхойлоход<sup>50</sup> хамаарах зохицуулалтыг дараах байдлаар хуульд тусгасан:**

Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эсвэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Телевизийн нэвтрүүлэг гэж хуулиар тодорхойлсон боловч цахим орчин дахь сурталчилгааны ил тод байдлыг хангах зохицуулах журамлах боломжтой байна.

**Сонгуулийн сурталчилгааны тайлангийн зохицуулалт:<sup>51</sup>**

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлнэ. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевиз нь нийтэд мэдээлсэн тайланг шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нийтэд мэдээлснээс хойг ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ. Радио, телевизийн хүлээх үүргийг хуулиар зохицуулсан байх тул цахим орчин дахь сурталчилгааны санхүүгийн ил тод байдлыг хангах зохицуулалтыг журамд тусгах нь зүйтэй байна.

Сонгуулийн тухай хуулиар олон нийтийн сүлжээний платформд тодорхой үүрэг хүлээлгээгүй хэдий ч цахим орчин дах зар сурталчилгааны харилцаан хамаарах дараах үйлчилгээ эрхлэгч нарт үүрэг хүлээлгэсэн:<sup>52</sup>

- Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй.
- Үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаах үүрэг хүлээнэ.

<sup>50</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39.4 дэх хэсэг

<sup>51</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39.5, 39.7 дахь хэсэг

<sup>52</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.13, 46.15, 46.19, 47.8

### **3.2 Сонгуулийн сурталчилгааг цахим орчин ашиглаж явуулах зохицуулалтад хамаарах эрх зүйн хийдэл**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1-г зааснаар сонгуулийн сурталчилгаанд дараах хэлбэрийн цахим хуудас ашиглаж болно:

1. **Нэр дэвшигчийн болон нам эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас.** Нэр дэвшигчийн үнэмлэх авсан хувь хүний өөрийн 1, улс төрийн нам эсхүл эвслийн 1 цахим хуудас хамаарна.<sup>53</sup>
2. **Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас.** Нэр дэвшигч болон нам эсхүл эвслийн удирддаг буюу эзэмшлийн цахим нийтийн сүлжээний хаяг хамаарна.<sup>54</sup>
3. **Бусад цахим хуудас** - нэр дэвшигч өөрөө эсхүл түүний хүсэлтээр, түүний нэрийн өмнөөс сонгуулийн сурталчилгааг явуулах сонин сэтгүүл, телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагууд, инфлүенсер (байгууллага, хувь хүн)-ийн цахим хуудас болон олон нийтийн сүлжээний цахим хуудас хамаарна.

Энэхүү зохицуулалтаас үзвэл, нэр дэвшигч нь дээр дурдсан 3 хэлбэрийн цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах боломжийг нээлттэй тодорхойлжээ.

Харин хуулийн 47.2-г зааснаар Нэр дэвшигч нь (1) өөрийн болон нам эвслийн тус бүр нэг цахим хуудас (2) цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлэх шаардлага тодорхойлсон. Энэ зохицуулалтаар “Бусад цахим хуудас”-ыг харьяалах сонгуулийн хороонд бүртгүүлэхгүй байна.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд тодорхойлсон сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зохицуулалтын зорилго, агуулга мөн Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 13 дах хэсэгт заасан эрх зүйн хариуцлагаас “Сонгуулийн сурталчилгаа явуулах цахим хуудсыг заавал бүртгүүлэх” хууль зүйн шаардлага урган гарч байна. Тодруулбал:

---

<sup>53</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-г заасныг “цахим хуудас” гэж бүх төрлийн контентыг интернэтийн домэйн нэр ашиглан хэрэглэгчид хүргэдэг программ хангамжийг хэлнэ.

<sup>54</sup> Сонгуулийн тухай хуулийн 47.10-д “Нэр дэвшигч болон нам, эвсэл нь 47.1.1, 47.1.2-г заасан цахим хуудсаа энэ хуулийн 39.1-д заасан сонгуулийн сурталчилгаа дуусах хугацанд хаана” гэж зааснаас үзвэл, олон нийтийн цахим сүлжээнд цахим хуудсанд нэр дэвшигч, нам, эвсэлийн удирддаг, эзэмшидэг цахим хаяг хамаарч байна.

- Хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг хориглоно.<sup>55</sup>
- Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Товч дүгнэлт.

Сонгуулийн хороонд бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хуулиар хориглосон тул Сонгуулийн тухай хуулийн 47.1.3-т заасан “Бусад цахим хуудас”-ыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах боломжгүй байна.

Гэтэл Сонгуулийн тухай хуулийн 47.5, 47.7.1-т тус тус “Бусад цахим хуудас”-ыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан нь (1) бүртгүүлээгүй бусад цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах боломжтой эсхүл (2) бүртгүүлээгүй бусад цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашигласан тохиолдолд тус хуудсыг хааж, Зөрчлийн тухай хуульд заасан торгуулийн хариуцлагыг ногдуулах хууль зүйн хоёрдмол тайлбарыг бий болгож, хуулийн зохицуулалт нэг мөр хэрэгжих боломжгүй, энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд хуулийн нэгдмэл байдлаар тайлбарлаж хэрэглэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Тийм учраас, нэн тэргүүнд хуулийн зохицуулалт хоорондын нийцлийг хангаж, зохицуулалтыг нэгдмэл байдлаар ойлгож, хэрэглэх шаардлага үүсэж байна.

Хууль тогтоогчоос сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах боломжийг 3 хэлбэрээр тодорхойлсон нь хуулиар эдгээр “цахим хуудас”-аар сонгуулийн сурталчилгаа явуулахыг хүлээн зөвшөөрч буйг илтгэж байна. Мөн Сонгуулийн тухай хуулийн 47.4, 47.7 дэх хэсэгт зааснаар “*бүртгүүлсэн цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах*” шаардлагыг нэг мөр тодорхойлсныг харгалзан үзэх нь зүйтэй. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглахад “цахим хуудас”-ыг бүртгүүлэх хуулийн концепцийг хадгалж, Сонгуулийн тухай хуулийн 47.7 дахь хэсэгт заасан зохицуулалтын хийдлийг арилгахад дараах 2 хувилбарыг дэвшүүлж байна. Үүнд:

**I хувилбар.** (Бусад цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй байх)

<sup>55</sup> Монгол Улсын Их Сонгуулийн тухай хуулийн 47.2 дахь хэсэг.

Судалгааны өмнөх хэсэгт дурдсан олон улсын чиг хандлагаас үзвэл, сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зохицуулалтын хамрах хүрээ, зохицуулах зүйл тодорхой байх нь журмын хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Сонгуулийн тухай хуулийн 47.2, 47.4-т заасныг үндэслэн сонгуулийн сурталчилгаа явуулах цахим орчинг (1) нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас, (2) цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас зэрэг хоёр хэлбэрийн цахим хуудсаар хязгаарлаж, сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим орчныг хамрах хүрээг тодорхойлно.

Улмаар “Бусад цахим хуудас”-ыг ашиглаж сонгуулийн сурталчилгаа явуулахгүй байхаар Сонгуулийн тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулж, зохицуулалт хоорондын зөрчлийг арилгах боломжтой байна. Үүнд:

1-р хувилбар. Бусад цахим хуудас”-аар сонгуулийн сурталчилгаа явуулахгүй байх

<b>Сонгуулийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт</b>	<b>Санал</b>
47.3-т “Энэ хуулийн 47.1.1, <del>47.1.3-т</del> заасан цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтэлнэ.”	“47.1.3-т” гэснийг хасах
47.5-д “Энэ хуулийн 47.1.3-т заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах төлбөр нь ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд баримталсан зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн төлбөрийн дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна.”	“47.1.3”-т гэснийг “47.1.2” гэж өөрчлөх
47.7.1-т “энэ хуулийн 47.1.1, <del>47.1.3-т</del> заасан цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн дүн гарч дуусталх хугацаагаар хаах”	“47.1.3-т” гэснийг хасах

Энэхүү хувилбарын ач холбогдол нь сонгуулийн сурталчилгаа явуулах цахим орчны хамрах хүрээг тодорхой болох бүртгүүлээгүй цахим хуудсаар сонгуулийн сурталчилгаа явуулахгүй байх, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэхэд оршино. Цахим орчин нь нутаг дэвсгэрийн хил хязгаар, хүн амын тоо зэргээс үл хамаарах хязгааргүй орон зай тул цахим орчин ашиглах сонгуулийн сурталчилгаа явуулах харилцааны хамрах хүрээ, зохицуулах зүйлийг тодорхойлж, түүнд хяналт тавих, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны ил тод байдлыг хангах, зардлыг тайлагнах зэрэг хүндрэл бэрхшээлүүд үүсдэг. Тиймээс сурталчилгаа явуулах боломжтой цахим хуудас, олон нийтийн сүлжээг

тодорхойлох нь нэр дэвшигчдэд тэгш боломжийг бий болгох, сонгогчдод үнэн зөв мэдээлэл хүргэх, түүний сонголтод чиглэсэн хууль бус арга хэрэгслийг хэрэглэхээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

2-р хувилбар. “Бусад цахим хуудас”-ыг бүртгэсний үндсэн дээр түүгээр сонгуулийн сурталчилгаа явуулахыг хүлээн зөвшөөрөх

Сонгуулийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Санал
47.2-т “Нэр дэвшигч энэ хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш 3 гурав хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.”	47.2-т “Нэр дэвшигч нь энэ хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудсыг, мөн хуулийн этгээд, хувь хүн нь өөрийн эзэмшиж, удирддаг энэ хуулийн 47.1.3-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш 3 гурав хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.” <i>гэж өөрчлөх</i>
-	47.13-т “Бусад цахим хуудсанд байршуулсан сонгуулийн сурталчилгаанд хандах эрхийг байгууллага, хувь хүн нь сонгуулийн сурталчилгаа дуусах хугацаанд хаана.” <i>гэж нэмэх</i>
-	47.14-т “Байгууллага, хувь хүн нь сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаар тайланг нийтэд нээлттэй байршуулж, хэвлэмэл эсхүл цахим хувийг, Шударга, өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”

Одоогийн Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан зохицуулалт хоорондын зөрчлийг арилгах зорилгоор дээрх байдлаар өөрчлөлт оруулснаар “Бусад цахим хуудас”-аар сонгуулийн сурталчилгаа явуулах боломжийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Сонгуулийн сурталчилгаа явуулах “Бусад цахим хуудас” нь нэр дэвшигчийн өөрийн удирддаг, эзэмшдэг цахим хуудас, олон нийтийн сүлжээний цахим хаяг биш байх тул Нэр дэвшигчээс тухайн цахим хуудсыг бүртгүүлэх боломжгүй. Тиймээс “бусад цахим хуудас” эзэмшигч буюу аккаунтыг эзэмшиж, удирддаг хувь хүн, хуулийн этгээдээс өөрийн цахим

хуудас, олон нийтийн сүлжээний цахим хуудсаар сонгуулийн сурталчилгааг явуулах хүсэлтэй байх тохиолдолд түүнийг урьдчилж, бүртгүүлэх хууль зүйн шаардлагыг зохицуулалтаар бий болгох нь зүйтэй. Үүний үр дүнд, сонгуулийн сурталчилгаа явуулах бусад цахим хуудсыг олон нийтэд нээлттэй байршуулах замаар цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааны болон санхүүгийн ил тод байдлыг хангахын зэрэгцээ, бусад бүртгүүлээгүй цахим хуудсыг ашиглан сонгуулийн сурталчилгааг явуулж, сонгуулийн үр дүнд нөлөөлж, сонгуулийн үйл ажиллагааны шударга ёсны зарчмыг зөрчихөөс урьчдилах ач холбогдолтой юм.

Нэмэлт тайлбар.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан зохицуулалт хоорондын уялдаа холбоо алдагдсан, хоёрдмол утгаар хэрэглэгдэх эрсдэл үүссэн байгаатай холбоотой хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн хийдлийг арилгах 2 хувилбарыг дэвшүүлсэн болно.

“Бусад цахим хуудас”-ыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хүлээн зөвшөөрөх эсэх, түүний нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлсны үндсэн дээр аль нэг хувилбарыг сонгож, хуульд өөрчлөлт оруулах замаар хуулийн нийцлийг хангах нь зүйтэй.

Энэ судалгааг хийж гүйцэтгэсэн өдрийн<sup>56</sup> байдлаар Сонгуулийн тухай хууль өөрчлөлт оруулах хуульд заасан хугацаа өнгөрсөн байгааг<sup>57</sup> тэмдэглэж байна.

Тиймээс хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд эрх зүйн зохицуулалтын хоорондын зөрчилдөөнийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн агуулга, сонгуулийн зарчим, сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зохицуулалтын зорилгод нийцүүлэн тайлбарлаж, нэгдмэл байдлаар ойлгож, нэг мөр хэрэглэх хүрээнд хэрэглэх шаардлагыг бий болгож байна. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин орчин ашиглах хуулийн концепциас үзвэл, (1) Сонгуулийн сурталчилгааг явуулах “цахим хуудас”-ыг бүртгэдэг байх (2) Бусад цахим хуудас ашиглаж сонгуулийн сурталчилгааг явуулах боломжийг нээлттэй үлдээх гэсэн хоёр агуулгыг хүлээн зөвшөөрч, нэгдмэл байр хуулийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Энд дурдсан агуулгаар Сонгуулийн тухай хуулийг 47 дугаар зүйлийг тайлбарлаж, хэрэглэснээр Нэр дэвшигч нь хуулийн 47.1-д заасан гурван хэлбэрийн цахим хуудсыг сонгуулийг сурталчилгаанд ашиглах хуулийн зохицуулалт хэрэгжинэ. Тодруулбал, Нэр дэвшигч нь Сонгуулийн тухай хуулийн 47.1.1,

<sup>56</sup> Судалгааг 2024.01.12-2024.01.19-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн болно.

<sup>57</sup> Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 82.1-т зааснаар Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

47.1.2-т заасан цахим хуудсыг бүртгүүлэх бол, сонгуулийн сурталчилгаа явуулах зорилготой хуулийн этгээд, хувь хүн нь мөн хуулийн 47.1.3-т заасан хуудсыг бүртгүүлэх замаар бүртгэлтэй цахим хуудсаар цахим хуудсаар сонгуулийн сурталчилгааг явуулах хуулийн зорилго биелэгдэнэ.

Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан 12 хэсэг зохицуулалтаар цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг бүхэлд нь зохицуулах боломжгүй. Тиймээс Сонгуулийн Ерөнхий хороо нь цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах нарийвчилсан журмыг батлахаар хуульчилсан.<sup>58</sup>

Сонгуулийн ерөнхий хорооноос батлах дээрх журамд судалгааны өмнөх хэсэгт дурдагдсан Online political advertisement (OPA) буюу цахим орчин дахь улс төрийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалтад тусгавал дараах агуулгыг тусгах боломжтой эсэхийг судалж, журмын төсөлд холбогдох өөрчлөлтийг оруулсан болно. Үүнд:

1. Агуулгын хувьд ямар сурталчилгааг сонгуулийн сурталчилгаа хамруулах талаар, журмын зохицуулалтын хамрах хүрээ
2. Сонгуулийн сурталчилгаанд хамаарах шалгуур, тухайн сурталчилгааг худалдан авч буй этгээдийг тодорхойлох
3. Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны ил тод байдлыг бий болгох
4. Цахим хуудас, олон нийтийн сүлжээний цахим хуудсыг удирдаж, эзэмшдэг этгээдийн хүлээх үүргийг тодорхойлох
5. Зар сурталчилгааны агуулгад хамаарах зохицуулалт (хориглосон агуулгыг тодорхойлох, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх механизм, хөндлөнгийн хараат бус мониторинг хийлгэхтэй холбоотой харилцаа хамаарна) багтана.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмыг баталсан байна. “Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал” судалгааны тайланд, тус журамд эрх байгууллагуудаас сонгуулийн сурталчилгаа, мэдээ, мэдээллийн агуулгад хяналт тавих эсэх талаар тусгаагүй байгаа нь тодорхой бус байдлыг үүсгэж байгаага гадна журамд заасан хязгаарлах арга хэмжээнүүдийг ямар тохиолдолд хэрэглэх болон зөрчлийн онцлог, шинжээс хамааран дангаар нь эсхүл хамтад нь хэрэглэх эсэх талаар зохицуулаагүй үлдээсэн. Уг тодорхой бус байдлын улмаас эрх бүхий байгууллагууд нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг өргөнөөр хязгаарлах эрсдэлийг үүсгэсэн тухай дүгнэлт<sup>59</sup> гаргажээ.

<sup>58</sup> Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 47.9 дэх хэсэг

<sup>59</sup> ХЗҮХ “Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал” судалганы тайлан, 2022 он.

Энэ судалгааны хүрээнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журамтай холбоотой дээр дурдсан дүгнэлтийг харгалзан үзэхийг зэрэгцээ Захиалагчаас ирүүлсэн “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын төслийн шинэчилсэн найруулгын агуулгыг судалж үзэхэд, дараах харилцааг “зохицуулсан” болон “зохицуулаагүй” байна. Үүнд:

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын төслийн агуулга

Журмаар зохицуулсан харилцаа	Журмаар зохицуулаагүй харилцаа
Нэм, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийг төлөөлсөн этгээд цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах	Сонгуулийн сурталчилгааны ямар сурталчилгааг хамаарах, агуулгыг тодорхойлсон зохицуулалт
Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч, цахим үйлчилгээ эрхлэгчид хамаарах үүргийг тодорхойлсон	Цахим хуудас, олон нийтийн сүлжээний платформын цахим хуудас эзэмшигч (нэр дэвшигчээс бусад) этгээдтэй холбоотой харилцаа
Цахим шуудан ашиглаж сонгуулийн сурталчилгаа явуулах	Хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой зохицуулалт
Сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн ажиллагаа	Цахим хуудасны хэлбэрүүд, тэдгээрийн ялгааг тайлбарласан тодорхойлолтод
Сонгуулийн хяналтын горим	Харилцаа холбоонд ирүүлсэн дүгнэлтийг шийдвэрлэх процесс ажиллагааны зураглал
Эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагаа	Хөндлөнгийн хараат бус байгууллагын хамтын ажиллагаа
Гомдол маргаан шийдвэрлэх ажиллагаа Self-regulation - Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим үйлчилгээ эрхлэгч өөрөө гомдол шийдвэрлэх механизм	
Хариуцлага	
Сонгуулийн сурталчилгаа явуулж буй этгээдийг тодорхойлох, сонгуулийн үйл ажиллагаа ил тод байх	Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны санхүүгийн ил тод байдлын зохицуулалт
	Олон нийтийн сүлжээний платформ болон Хөндлөнгийн хараат бус байгууллагатай



Дээрх хүснэгтэд, журмын төслөөр зохицуулсан харилцаанаас гадна зохицуулбал зохих харилцаанд хамаарах агуулгыг тодорхойлсон бөгөөд бусад олон улсын чиг хандлага, туршлага болон улс орнуудын зохицуулалтын харьцуулсан судалгаанд үндэслэн журмын төсөлд оруулбал зохих өөрчлөлтүүдийг судалгааны зөвлөмж дэлгэрэнгүй байдлаар тусгаж, Журмын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан болно.

### **3.3 Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын төслийн зохицуулалт**

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмаар сонгуулийн оролцогчид, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгчийн хүлээх үүрэг болон эрх бүхий байгууллагын бүрэн эрх, хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.4-т заасныг үндэслэн сонгуулийн сурталчилгаа явуулах цахим хуудсыг бүртгүүлэх ажиллагааг тус журмаар нарийвчлан зохицуулах шаардлагатай. Цахим хуудсыг бүртгэх ажиллагааг дараах байдлаар журамласан. Үүнд:

1. Нам, эвсэл, нэр дэвшигч нь (1) сонгуулийн ерөнхий хорооноос баталсан бүртгэлийн хуудас, (2) цахим хуудасны домэйн нэр, веб хуудас болон веб сайтын байршлын (веб/сервер хостинг) талаарх мэдээлэл (3) цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудасны бүртгэлийг хаяг, бүртгүүлсэн нэр, цахим шуудан, утасны дугаар, цахим холбоос хаяг (URL хаяг) Аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.
2. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн мэдээллийг бүртгэл хийснээс хойш 1 хоногийн дотор Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.
3. Нам, эвсэл, нэр дэвшигчийн бүртгүүлсэн цахим хуудасны жагсаалтыг Сонгуулийн ерөнхий хороо болон Харилцаа холбооны зохицуулах хороо нь өөрийн албан ёсны цахим хуудсаар мэдээлснээр бүртгэлийн үйл ажиллагаа дуусна.

Дээрхээс гадна, 3.5 дахь хэсэгт “Цахим орчны интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч” нь сонгуулийн сурталчилгаа явуулах тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах

хороонд бүртгүүлэхээр журамласан. Гэвч бүртгүүлэх гаргаж өгвөл зохих мэдээлэл, бүртгэх ажиллагааны талаарх зохицуулаагүй байна.

**Цахим хуудасны бүртгэлийг журамласан байдлыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нийцүүлэх тухай дүгнэлт.**

Захиргааны ерөнхий хуулийн 60.1.1, 60.1.2-т зааснаар захиргааны хэм хэмжээний актын зохицуулалт нь хуульд нийцсэн, мөн тусгайлан эрх олгосон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх шаардлагатай.

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.2-т зааснаар “Нэр дэвшигч” цахим хуудсыг бүртгүүлэх тодорхой зохицуулалттай. Харин журамд “нэр дэвшигч”-ээс гадна нам, эвсэл цахим хуудсыг бүртгүүлэхээр хуулийн зохицуулалтыг өргөжүүлсэн нь хуульд нийцэхгүй байна.
2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.2-т зааснаар сонгуулийн сурталчилгаа явуулах цахим хуудсыг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүртгэнэ. Хуулийн дагуу цахим хуудсыг бүртгэх эрх бүхий байгууллага нь сонгуулийн хороо байна. Гэвч журмын 3.5-д цахим үйлчилгээ эрхлэгчийг Харилцаа холбооны зохицуулах хороо бүртгэхээр журамласан нь хуулиар эрх олгогдоогүй байгууллагад бүртгэлийн үйл ажиллагаа явуулахаар байна.

Журмаар тодорхойлсон цахим хуудсыг бүртгүүлэх ажиллагаатай холбоотой зохицуулалтад “бусад цахим хуудас”-ыг бүртгэх харилцааг зохицуулаагүй, харин Харилцаа холбооны зохицуулах хороо цахим үйлчилгээ эрхлэгчийг бүртгэх талаар журамласан нь хуулиар тусгайлан эрх олгоогүй байгууллага захиргааны үйл ажиллагааг явуулахгүй буюу хуульд үндэслэх зарчмыг зөрчиж байна. Үүнээс гадна, бүртгэлд ирүүлсэн мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хариуцах этгээдийг тодорхойлох нь зүйтэй.

Журамд сонгуулийн сурталчилгааны хяналтын хэрэгжүүлэх дарааллыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.
2. Дээрх эрх бүхий байгууллага нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан үзээд эрх бүхий албан тушаалтны шийдвэр бүхий албан бичиг дүгнэлтийг Харилцаа холбоотой зохицуулах хороонд хүргүүлнэ.
3. Харилцаа холбооны зохицуулах хороо нь албан бичиг, дүгнэлтийг дагуу мэдэгдлийг цахим орчны “цахим үйлчилгээ эрхлэгч”-д даруу хүргүүлнэ.

4. Цахим үйлчилгээ эрхлэгч нь дүгнэлтэд заасан арга хэмжээ хэрэгжүүлж, хариу Харилцаа холбооны зохицуулах хороонд мэдэгдэнэ.
5. Цахим үйлчилгээ эрхлэгчийг олж тогтоох боломжгүй, эсхүл цахим үйлчилгээ эрхлэгч нь арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол Харилцаа холбооны зохицуулах хорооноос дараах мэдэгдлийг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчид хүргүүлнэ.
  - а. Тухайн цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн сурталчилгааны дүн гарч дуусах хүртэлх хугацаанд хаах
  - б. Хуульд заасан технологийн арга хэмжээ авах
6. Үүрэн холбооны эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь мэдэгдэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлж, хариу мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ.

Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны хяналтыг процессыг нарийвчлан тодорхойлох шаардлагад холбогдох дүгнэлт.

Захиргааны ерөнхий хуулийн 60.1.8-д бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх хууль зүйн шаардлага тавигддаг. Харин журамласан сонгуулийн сурталчилгааны хяналтын горимд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн заалтууд давтагдсан байна.

Үүнээс гадна Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.11-д зааснаар “технологийн арга хэмжээ”-г Сонгуулийн Ерөнхий хорооноос гарсан саналыг үндэслэн авах талаар шаталсан хэм хэмжээг тусгасан. Гэтэл журамд Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн технологийн арга хэмжээг авах ажиллагааг дурдаагүй.

Журамд дурдсан “эрх бүхий байгууллагын албан бичиг, дүгнэлт”-ийг үндэслэн гэж дурдсан аль байгууллагыг илэрхийлж байгаа нь тодорхой бус, эрх бүхий байгууллага аль хуульд заасан журмаар хяналтыг хэрэгжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих захиргааны байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог журмаар тодорхойлох шаардлагатай. Тухайлбал, сонгуулийн хугацаанд буюу богино хугацаанд хуулийн зөрчлийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаанд хяналтыг хэрэгжүүлж байгаа тул захиргааны байгууллага ямар хуульд заасан арга хэмжээг хэрхэн хийж гүйцэтгэх талаар тодорхой зохицуулах нь зүйтэй. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49.9-д цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих үйл ажиллагааг энэ журмаар зохицуулахаар хуульчилсан тул хяналтад хамаарах журмын зохицуулалтыг үндсэн зохицуулалт гэж үзнэ.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд хуульд заасан хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдана. Тиймээс хуульд заасан сонгуультай холбоотой маргаанууд, түүнийг харьяалан шийдвэрлэх эрх бүхий этгээдийг журамд тодорхой, ойлгомжтой байдлаар зохицуулна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус зааснаар цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой ирүүлсэн гомдол, түүнийг хянан шийдвэрлэхтэй холбоотой ажиллагаанд Сонгуулийн Ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Тагнуулын байгууллага, Цагдаагийн байгууллага, Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар оролцохоор байна. Хуулиар харьяалан шийдвэрлэх байгууллага, маргааны төрөл, түүнд хамаарах гомдлыг шийдвэрлэх журам, авах арга хэмжээ болон хариуцлагын зохицуулалтын дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү.

Товч дүгнэлт.

Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих ажиллагааны зохицуулалтыг дараах агуулгаар өөрчилж, тодорхойлох нь оновчтой юм. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 35.3-т заасан гомдолтой холбоотойгоор Тагнуулын байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо нь цахим хуудсыг хаах, хязгаарлах талаар журамлах.
2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.3, 47.4-т заасан гомдолтой холбоотойгоор Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо нь цахим хуудсыг хаах, хязгаарлах талаар журамлах;
3. Цахим хуудсыг хаах, хязгаарлахаас өмнө цахим хуудас эзэмшигчид мэдэгдэх;
4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 47.11-д заасныг дагуу Сонгуулийн Ерөнхий хорооны саналыг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос авах олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээнүүдийг тухайлан тодорхойлон журамлах;
5. Цахим орчин дахь зар сурталчилгааны үйл ажиллагааны ил тод байдал болон санхүүгийн ил тод байдлыг хангах зохицуулалтыг оруулах;
6. Нэр дэвшигч, цахим хуудас эзэмшигчийн хүлээх үүргийг тодорхойлж, үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах хуульд заасан арга хэмжээг авахыг журамд тусгах;

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах болон “deep fake”-тэй холбоотой зохицуулалтын онцлог**

### **4.1 Монгол Улсын Эрүүгийн хуулиар тодорхойлсон гэмт хэрэг, түүний онцлог**

Тагнуулын байгууллага нь Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагааг явуулна. Сонгуулийн үеэр нэр дэвшигчтэй холбоотой худал мэдээлэл тараах үйлдэл нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт хамаарна. Эрүүгийн 14.8 дугаар зүйлийн 1-т зааснаар Сонгуулийн оролцогч улс төрийн нас, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэл халдаж, илт худал мэдээлэл тараасан тохиолдолд дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийн обьтив талын шинж нь сонгуулийн үеэр нэр дэвшигчтэй холбоотой худал мэдээлэл тараах үйлдлээр илэрнэ.

Гомдлын дагуу уг хэргийг хянан шийдвэрлэх явцад Тагнуулын байгууллагаас санал бэлтгэж, Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэх замаар мэдээлэл байршсан цахим хуудсыг түр хугацаагаар хаах, хязгаарлах арга хэмжээг авах боломжтой талаар судалгааны өмнөх хэсэгт дурдсан.

Дээрхээс гадна, тухайн гэмт хэргийг Нэр дэвшигч, нөгөө нэр дэвшигчийн эсрэг үйлдсэн нь сонгуулийн санал хураалтын дүн гарахаас өмнө тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хорооноос тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээр хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.<sup>60</sup>

Монгол Улсад “deep fake”-ийг тусгайлан тодорхойлсон зохицуулалт байхгүй байх тул уг мэдээлэлтэй холбоотой зохицуулалтын орчныг бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг судлах замаар тодорхойлно.

### **4.2 Европын Холбооноос гаргасан “deep fake”-д хамаарах бодлого, зохицуулалт**

Европын Холбооноос 2021 онд гаргасан “deep fake”-тэй тэмцэх тухай судалгаанд дурдсанаар, “deep fake” гэдэг нь хиймэл оюун ухаан ашиглан бүтээгдсэн, жинхэнэ мэт санагдах, бодит байдал дээр болж байгаагүй үйлдлийг илэрхийлсэн хиймэл эсвэл синтетик

---

<sup>60</sup> Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 75.2 дахь хэсэг.

аудио эсвэл дүрс бичлэг хэмээн тодорхойлжээ.<sup>61</sup> Мөн Европын Парламентаас хэрэгжүүлэхээр зорьж буй зохицуулалтыг дурдсан байх бөгөөд үүнд:

- “Deep fake” мэдээллийг илрүүлэх, дур мэдэн хаах, шүүх, устгахтай холбоотой автомат шийдвэр гаргахад ашиглаж буй алгоритм, хиймэл оюун ухааны бүрэн ил тод байдал;
- бие даасан, хараат бус гуравдагч fact checking этгээдийн хэрэгцээ шаардлага;
- мэдээллийн эх сурвалжийг баталгаажуулахтай холбоотой үүрэг болон тэдгээрийг ашиглагдаж буй хэрэглүүр;
- хэрэглэгчид худал болон төөрөгдүүлсэн мэдээлэлд гомдол, хүсэлт гаргах боломжийг олгох;
- худал болон төөрөгдүүлсэн мэдээллийг илрүүлсэн тохиолдолд тухайн мэдээллийг тамгалан олон нийтэд таниулах зэргийг багтаажээ.<sup>62</sup>

Мөн “deep fake”-г ашиглан аливаа мэдээллийг тарааж буй тохиолдолд түүнийг заавал тамгалан мэдэгдэх үүргийг цахим хуудсанд өгсөн. Харин “deep fake”-г ашиглан бүтээсэн хуурамч мэдээлэл тараасан тохиолдолд тооцох хариуцлагыг дурдаагүй байна. Сүүлийн тохиолдолд тухайн худал эсвэл төөрөгдүүлсэн мэдээллийг тараасныг цахим орчин хэмээн ялгахгүй нийтлэг зохицуулалтаар хариуцлага тооцдог байна.

Европын холбоонд 2022 оны 11 дүгээр сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Дижитал үйлчилгээний хуулиар социал медиа платформууд deep fake болон бусад худал мэдээллийг өөрийн платформуос устгах, дижитал платформыг хууль бусаар ашиглах хяналтыг нэмэгдүүлэх талаар тусгасан. Мөн Хиймэл оюун ухааны хуулийн төслийг санаачилсан бөгөөд тус хуулиар deep fake үйлчилгээ үзүүлэгчид ил тод, нээлттэй байдлын шаардлагыг дагаж мөрдөнө. Үүнтэй холбоотой Европын Холбооны гишүүн 27 улс Хуурамч мэдээллийн талаар сайжруулсан практикийн дүрмийн deepfake-н журамд хамрагдаж, удахгүй гарах Хиймэл оюун ухааны тухай хуульд хамрагдахаар байна.<sup>63</sup>

### 4.3 БНСУ-ын “deep fake video”-д хамаарах эрх зүйн зохицуулалт

БНСУ нь 2023 оны 12 сарын 28-ны өдөр Сонгуулийн тухай хуулийн 82-ын 8 дугаар зүйлд “deep fake дүрс бичлэг”-ний талаарх анхны зохицуулалтыг тусгасан. Тус зүйлийн 1 дэх хэсэг “deepfake дүрс бичлэг”-ийг “...хиймэл оюун ухааны технологийг ашиглаж бодит байдлаас ялгахад бэрхшээлтэй цахим аудио, зураг, дүрс бичлэг зэргийг хамааруулж үзнэ” гэж тодорхойлсон бөгөөд энэхүү дүрст бичлэгийг аливаа этгээд нь сонгуулийн санал

<sup>61</sup> European Parliamentary Research Service, Scientific Foresight Unit (STOA), Tackling deepfakes in European policy, July 2021.

<sup>62</sup> European Parliament, Resolution on online platforms and the digital single market', June 15<sup>th</sup>, 2017.

<sup>63</sup> Responsible Artificial Intelligence Institute, Global Deepfake Regulation Approaches, <https://www.responsible.ai/post/a-look-at-global-deepfake-regulation-approaches>

хураалт болох өдрөөс сонгуулийн өдөр хүртэл 90 хоногийн дотор сонгуулийн сурталчилгаа явуулах зорилгоор бүтээх, засварлах, тараах, үзүүлэх, нийтлэх үйлдэл хийхийг хориглосон.

Дээрх хугацаанаас бусад үед сонгуулийн сурталчилгаа явуулах зорилгоор deep fake дүрст бичлэгийг бүтээх, засварлах, тараах, үзүүлэх, нийтлэх үйлдэл хийхдээ Сонгуулийн төв хорооны дүрэмд тодорхойлсны дагуу “deep fake дүрст бичлэг” болохыг тамгалсан байхыг шаардана. Өөрөөр хэлбэл холбогдох хуулиар зөвшөөрсөн хүрээнд Deep fake дүрс бичлэг сонгуулийн сурталчилгаанд ашиглах боломжтой бөгөөд Deep fake дүрс бичлэг ашиглаж байгаа тохиолдолд “Deep fake дүрс бичлэг/AI.../” гэсэн тамгыг тавих ёстой. Ийм тамга тавиагүй тохиолдолд Сонгуулийн тухай хуулийн 250 дугаар зүйлд заасан хуурамч мэдээлэл<sup>64</sup> тараасан гэмт хэрэгт тооцдог. Мөн deep fake дүрс бичлэгт дээрх тамгыг хийсэн боловч тухайн дүрс бичлэгийн агуулга нь аль нэг нэр дэвшигчийг сонгогдох эсвэл сонгогдохгүй нөхцөл байдалд хүргэхийг зорилгоо болгосон худал мэдээллийг тараасан эсвэл гүтгэсэн тохиолдолд мөн хуулийн 251 дүгээр зүйлд заасан “нэр дэвшигчийг гүтгэх” гэмт хэрэгт хамааруулж үздэг.<sup>65</sup> Эдгээр гэмт хэрэг нь санкцын хувьд 3 жилээс 7 жилийн хорих ял эсвэл 500 сая вон хүртэл торгох ял оногдуулах боломжтой.

Deepfake видеог цахим орчинд олон нийтэд түгээх байдлаар сонгуулийн сурталчилгаа явуулж байгаа тохиолдолд тухайн дүрс бичлэгийг тараах зорилгоор нийтэлсэн этгээд нь хариуцлага хүлээх субъект байх бөгөөд нэр дэвшигчтэй ямар нэгэн тохиролцоо байсан гэдэг нь нотлогдсон тохиолдолд гэмт гэргийн хамтран оролцогч болж хариуцлага хүлээдэг.

#### 4.4 АНУ-ын deep fake-д хамаарах эрх зүйн зохицуулалт

АНУ-ын Калифорни, Миннесота, Техас, Вашингтон мужуудад сонгуулийн сурталчилгаанд deepfake болон бусад хууран мэхлэх /манипуляц/ хэрэгслийг хориглох эсхүл хязгаарласан хууль батлагдсан.<sup>66</sup>

**Вашингтон муж** 2023 оны 07 дугаар сарын 23-ны өдөр Сонгуулийн сурталчилгаанд синтетик медиа ашиглах асуудлыг хуульчилсан.<sup>67</sup> Тодруулбал, нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаанд гадаад төрх, үйлдэл, яриа нь синтетик медиа ашиглан өөрчлөгдсөн гэж үзсэн тохиолдолд уг синтетик медиаг нийтлэхийг хориглох арга хэмжээг шүүхээр авахуулах, эсхүл ийнхүү адилтгах бусад хориглолтын арга хэмжээг авна. Нэр дэвшигч синтетик медиа ашигласан сонгуулийн сурталчилгааг нийтэлсэн ивээн тэтгэгчийн эсрэг

<sup>64</sup> “Худал мэдээлэл” гэдэгт нэр дэвшигчийн талаарх сонгогчийн дүгнэлтэд буруу ойлголт бий болгох боломжтой ач холбогдолтой мэдээллийг агуулсан байхыг ойлгодог. “Бодит мэдээлэл” гэдэгт өнгөрсөнд болж өнгөрсөн болон одоо болж буй нөхцөл байдлыг нотлох боломжтой байхыг үзнэ. /БНСУ-ын Дээд шүүхийн “2003. 2. 20. 선고 2001도6138” дугаар шийдвэр/

<sup>65</sup> 중앙선거관리위원회, “딥페이크 영상 관련 법규운용기준”, 2023.

<sup>66</sup> <https://www.brennancenter.org/our-work/research-reports/regulating-ai-deepfakes-and-synthetic-media-political-arena>

<sup>67</sup> Electioneering Communications - Use of Synthetic Media <https://lawfilesexpress.wa.gov/biennium/2023-24/Pdf/Bills/Session%20Laws/Senate/5152-S.SL.pdf?q=20231003125542>

хохирлоо шүүхээр нэхэмжилж болох ба энэ тохиолдолд синтетик медиа ашиглан бүтээгдсэн болохыг тодорхой, эргэлзээгүй баримтаар нотлох үүрэгтэй.

Сонгуулийн сурталчилгаанд deepfake ашигласантай холбоотой сурталчилгааг түгээсэн этгээдэд бус зөвхөн ивээн тэтгэгч (sponsor)-д хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, цахим хуудсууд, онлайн платформуудад шууд хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгаагүй. Тодруулбал, Холбооны тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, программ хөгжүүлэгчид хариуцлага хүлээлгэх үндэслэлийг зөвхөн deep fake ашигласан сурталчилгааг түгээх, дамжуулахдаа “Энэ (зураг/видео/аудио)-г өөрчилсөн” гэсэн тамгатайгаар (watermark) нийтлэх үүргийг хүлээлгэсэн. Энэ шаардлагыг хангаагүй, deepfake болохыг дурдалгүй тараасан, эсхүл deepfake ашигласан сурталчилгааны мэдээллийн агуулгыг өөрчлөн тараасан бол л хариуцлага хүлээлгэх тухайлсан зохицуулалт тусгагджээ.

Ийнхүү тамгатай нийтлэхдээ дүрстэй (нүдэнд харагдах) сурталчилгаа бол тухайн видеоны туршид, энгийн үзэгчийн нүдэнд харагдахуйц, хэрэв видеонд текс агуулагдсан бол бусад текстээс жижиг биш хэмжээтэйгээр байршуулж харуулна. Хэрэв аудио хэлбэртэй бол аудионы эхлэл болон төгсгөлд энгийн сонсогч сонсох боломжтойгоор deepfake-р бүтээгдсэн болохыг уншиж танилцуулах нарийвчилсан зохицуулалт орсон байна.

**Техас муж** 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Сонгуулийн тухай хуульдаа<sup>68</sup> deepfake-тэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэр дэвшигчийг хохироох, сонгуулийн үр дүнд нөлөөлөх зорилгоор deep fake бичлэг (бодит хүн бодит байдалд болоогүй үйлдлийг хийж буйг дүрсэлсэн) бүтээсэн, сонгууль болохоос 30 хоногийн өмнө deep fake бичлэгийг нийтэлсэн, тараасан бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилжээ.

**Миннесота мужийн** хувьд “Deep fake” ашигласан гэдэгт дүрслэгдсэн үг хэллэг, үйлдэлд оролцоогүй хувь хүний яриа, үйлдлийг дүрсэлсэн гэдэгт энгийн хүн итгэхээр бодитой, аливаа этгээдийн биеийн болон үйлдлээр илэрхийлэгдэх боломжтойгоос илүү техникийн хэрэгслээр бүтээгдсэн гэдэг нь илэрхий байгааг ойлгохоор заасан. Улмаар сонгууль болохоос өмнө 90 хоногийн дотор, эсхүл дүрслэгдсэн хувь хүний зөвшөөрөлгүйгээр, болон нэр дэвшигчийг хохироох, сонгуулийн үр дүнд нөлөөлөх зорилгоор deep fake-г тараасан, deep fake ашиглан хийсэн гэдгийг мэдсээр байж ийнхүү тараах зорилгоор бусад этгээдэй гэрээ хэлцэл хийсэн хүний үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан.<sup>69</sup> Санкцын хувьд 1,000 ам.доллар хүртэл торгох, эсхүл 90 хоног хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл дээрхийг хамтад нь хэрэглэхээр, урьд өөр төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээд байх тохиолдолд торгуулийн хэмжээ нэмэгдэх, хорих ял оноохоор хуульчилжээ.

АНУ-ын хувьд хууль хэдийгээр батлагдсан ч 2024 оны сонгуулийн сурталчилгааны үеэр deepfake-н дайралтаас урьдчилан сэргийлэх, нэр дэвшигчдийг тодорхой тохиолдолд

---

<sup>68</sup> Election code, Sec. 255.004. <https://statutes.capitol.texas.gov/Docs/EL/htm/EL.255.htm>

<sup>69</sup>

[https://www.revisor.mn.gov/bills/text.php?number=HF1370&type=bill&version=3&session=ls93&session\\_year=2023&session\\_number=0](https://www.revisor.mn.gov/bills/text.php?number=HF1370&type=bill&version=3&session=ls93&session_year=2023&session_number=0)



deepfake ашиглахыг хориглосон нэмэлтийг одоогийн зохицуулалтад оруулах тухай өргөдлийг<sup>70</sup> Холбооны сонгуулийн хороо (Federal Election Commission)-нд гаргасан байна.<sup>71</sup>

#### 4.5 Франц Улсын “худал мэдээлэл тараах”-тай холбоотой эрх зүйн зохицуулалт

Европын Холбооны улсуудаас ХБНГУ, Франц, Ирланд зэрэг улсууд цахим орчин дахь сонгуулийн болон улс төрийн сурталчилгааг тусгайлан зохицуулсан барим бичгийн баталсан байна. Ингэхдээ тухайн сурталчилгааг явуулах механизм гэхээсээ илүү худал мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээг чухалчилсан байна.<sup>72</sup>

Хууль тогтоомж	Мэдээллийн манипуляцын эсрэг хууль (2018). Зөвхөн сонгуультай холбоотой худал мэдээллийг зохицуулсан хууль.
Хуулийн зорилтот зохицуулалтын бүлэг	Өмнөх хуанлийн жилийн байдлаар Франц улсын хүрээнд сард 5 сая гаруй хүн зочилдог хэмээх тодорхойлолттой <b>хэвлэл мэдээлэл болон томоохон хэмжээний олон нийтийн сүлжээний платформууд.</b>
Хуульд тусгагдсан үүрэг	<ul style="list-style-type: none"> <li>● Дээрх томоохон хэмжээний цахим платформууд нь хэрэглэгчдэдээ зориулан олон нийтийн дэг журмыг алдагдуулж, сонгуулийн шударга байдалд нөлөөлж болзошгүй хуурамч мэдээллийн тухай гомдол гаргах хялбар механизмыг бий болгох үүрэгтэй.</li> <li>● Худал мэдээлэлтэй тэмцсэн тухай тайланг жил бүр Франц улсын Өргөн Нэвтрүүлгийн Агентлаг хүргүүлэх үүрэгтэй. Худал мэдээлэлтэй тэмцэхтэй холбоотой хэрэгжүүлж буй арга хэмжээнд платформын алгоритмын ил тод байдлыг дэмжин худал мэдээллийг зохион байгуулалттайгаар тогтмол болон давтамжтай тарааж буй аккаунт үйл ажиллагааг хязгаарлах зэрэг орно.</li> </ul>

<sup>70</sup> Тус өргөдлийг олон нийтийн эрх ашгийг хамгаалах, ашгийн бус хэрэглэгчдийн эрхийг хамгаалах байгууллага болох Public Citizen-ээс гаргасан.

<sup>71</sup> <https://www.citizen.org/news/public-citizen-submits-petition-to-federal-election-commission-calling-for-rulemaking-on-ai/>

<sup>72</sup> France, Organic Law no. 2018-1201 and Law no. 2018-1202 of 22 December 2018 relating to the fight against disinformation. These laws led to the insertion of two new articles in the French Electoral Code: Article 163-1 and 163-2. Research Office, Legislative Council Secretariat of Hong Kong, Information Note: Measures to tackle disinformation in selected places (2021), available at <https://www.legco.gov.hk/research-publications/english/2021in14-measures-to-tackle-disinformation-in-selected-places-20210623-e.pdf>

	<ul style="list-style-type: none"> <li>● Цахим орчин дахь платформууд нь сонгуулийн санал авах өдрөөс 90 хоногийн өмнөөс аливаа улс төрийн болон сонгуулийн захиалгат сурталчилгааны санхүүжилт, тухайн сурталчилгааг явуулж буй этгээдийн мэдээллийг ил тод байршуулах үүрэгтэй.</li> <li>● Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг явуулахад тухайн хэрэглэгчийн хувийн мэдээллийг ашиглаж болохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд бүрийг хэрэглэгчид мэдээлэх, зөвшөөрөл авах үүрэгтэй.</li> </ul>
<p>Үүрэг зөрчсөн тохиолдолд үүрэх хариуцлага, түүний хэмжээ</p>	<ul style="list-style-type: none"> <li>● Шүүгч худал мэдээллийг түгээн дэлгэрүүлсэн тухай гомдол мэдээллийг прокурор, нэр дэвшигч эсвэл бусад холбогдох этгээдээс хүлээн авснаас хойш 48 цагийн дотор худал мэдээллийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зогсоохыг шаардаж болно. Ингэхдээ шүүгч худал мэдээлэлд юу багтахыг гурван нөхцлийн дагуу тодорхойлох бөгөөд үүнд: (1) илт худал мэдээлэл, (2) өргөн цар хүрээнд санаатайгаар тараасан байх, (3) сонгуулийн үр дүнд нөлөөлөх зорилгоор олон нийтийн дэг журмыг алдагдуулсан.</li> <li>● Сонгуультай холбоотой мэдээллийг ил болгох үүргээ зөрчсөн тохиолдолд нэг жилийн хорих ял, 75,000 еврогийн торгууль ногдуулна.</li> </ul>
<p>-</p>	<p>Энэхүү хууль нь олон нийтийн сүлжээний платформ болон бусад цахим мэдээллийн сайтад хэрэглэгчид нээлттэй байдлаар худал мэдээллийн талаар гомдол гаргаж болох цэстэй байхыг, мөн сонгуулийн санал авах өдрөөс 90 хоногийн өмнөөс бүх захиалгат мэдээллийн санхүүгийн эх сурвалжийг дурдсан байхыг, болон тухайн платформын хэрэглэгчдэд өөрсдийнх нь хувийн мэдээлэл аливаа сурталчилгаанд ашиглаж буй сануулж байхыг хуульчилсан байна. Судлаачдын үзэж байгаагаар, ийм төрлийн зохицуулалт нь хоёр төрлийн эрсдэлийг дагуулах ба тэдгээр</p>

	<p>нь сэтгүүл зүйн эрх чөлөө болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болно.</p>
--	--

#### **4.6 Худал мэдээлэл болон deep fake-ийг илрүүлж, сонгогчдод үнэн зөв мэдээлэл хүргэх чиглэлээр хөндлөнгийн мониторингийн хараат бус байгууллагыг дэмжиж ажиллах**

Хиймэл оюун ухаан сонгуулийн компанит ажлыг хөнгөвчлөх, масс имэйл илгээх, нэр дэвшигчийн хэлэх үг, сурталчилгааны материалын контент бэлтгэх зэрэг ажилд туслах боловч сонгогчдыг төөрөгдүүлэх, нэр дэвшигчдийн дүрд хувирах, сонгуулийг өргөн цар хүрээтэй, үр дүнтэй болгох зэрэгт ашиглагдаж байна. Иймд сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчээс гадна сонгогчдын үнэн, зөв мэдээлэл авах боломж, аливаа мэдээлэлд цензууртэй хандах олон нийтийн боловсролд анхаарал хандуулах асуудал мөн хөндөгддөг. Үүнд цахим орчинд цацагдаж буй мэдээллийг баримтаар шалгаж, олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Олон Улсын баримт шалгах сүлжээ, баримт шалгалтын байгууллага, баримт шалгагчид болон нөлөөтэй.

2022 оны байдлаар дэлхийн 105 оронд 400 орчим сэтгүүлч, судлаачдын баг улс төрийн хуурамч, хууран мэхлэлт, бусад төрлийн ташаа мэдээлэлтэй ажиллаж байна. Баримт шалгагчдын 60 орчим хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой (378-ийн 226), 24 нь эрдэм шинжилгээний, 45 нь ашгийн бус эсхүл төрийн бус байгууллагын хэлбэрээр болон холбоотой үйл ажиллагаа явуулдаг. Харин эдгээрийн тавны нэг нь (378-аас 86 нь) бие даан үйл ажиллагаа явуулдаг байна.<sup>73</sup>

Олон улсын баримт шалгах сүлжээ (IFCN)<sup>74</sup> нь 2015 онд дэлхий даяар өсөн нэмэгдэж буй баримт шалгагчдыг нэгтгэж, ташаа мэдээллийн эсрэг дэлхий нийтийн тэмцэлд бодит мэдээллийг дэмжигчдийг нэгтгэх зорилгоор байгуулагдсан. Тус сүлжээний баталгаажсан гишүүн болох FactCheck.org<sup>75</sup> болон PolitiFact<sup>76</sup> веб сайт нь АНУ-ын улс төрийн хууран мэхлэлт, төөрөгдлийн түвшинг бууруулах зорилготой, нам бус баримт шалгагчид юм. Эдгээр нь санхүүжилтийн талаар ил тод мэдээллийг (тухайлбал, \$1,000 дээш хандивлагчдын нэрсийг гаргасан) вебсайтдаа байршуулсан байна.

АНУ-ын Засгийн газар ташаа мэдээлэлтэй тэмцэх санаачилгыг дэмжиж ажилладаг бөгөөд баримт шалгагч байгууллагууд ихэвчлэн төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Жишээлбэл, АНУ-ын сонгуулийн талаар үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх, улс

<sup>73</sup> Stencel, Ryan & Luther, Fact-checking extend their global reach with 391 outlets, but growth has slowed, <https://reporterslab.org/fact-checkers-extend-their-global-reach-with-391-outlets-but-growth-has-slowed/>

<sup>74</sup> International Fact-Checking Network, <https://www.poynter.org/ifcn/>

<sup>75</sup> <https://www.factcheck.org/>

<sup>76</sup> <https://www.politifact.com/>

төрийн үйл явцыг гажуудуулж, иргэдийн зөв шийдвэр гаргахад саад учруулж буй ташаа мэдээлэлтэй тэмцэхэд баримт шалгах үүргийн талаар хэлэлцүүлэг хийсэн.<sup>77</sup>

Европын баримт шалгах стандартын сүлжээ (EFCSN)<sup>78</sup> нь 2022 оны байдлаар 30 гаруй орны 45 баримт шалгах байгууллагын төлөөллөөс бүрддэг. Европын Комиссын санхүүжилтээр хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд төсөл нь 2023 оны 6 дугаар сард дууссан. Цаашид сүлжээг гишүүнчлэлийн татвар болон хандиваар санхүүжүүлэх бөгөөд бүх хандивлагчид болон орлогын эх үүсвэрийг вэбсайтдаа нийтлэх талаар дурдсан.

ХБНГУ-д ташаа мэдээлэлтэй тэмцэхийн тулд төрийн байгууллагууд болон баримт шалгагч байгууллагууд хамтарч ажилладаг. Тухайлбал, Герман-Австрийн Дижитал медиа ажиглалтын газар (GADMO) нь 2022 оны 11-р сард Европын холбооны комиссын төслийн санхүүжилтээр нээгдсэн. Тус холбоо нь Германы эрэн сурвалжлах сэтгүүлзүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг баримт шалгалтын сүлжээ болох CORRECTIV-тэй хамтран ажиллана.<sup>79</sup> Тэд хамтдаа баримт шалгалтыг илүү хүртээмжтэй болгох, ташаа мэдээлэлтэй тэмцэх, хэвлэл мэдээллийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийн сүлжээ хуурамч мэдээтэй тэмцэхэд хангалттай ажиллаж байгаа эсэхийг судлах зорилготой.

Европын баримт шалгагчид эх орондоо болон удахгүй болох парламентын сонгуультай холбоотой хуурамч, ташаа мэдээллийн нийтлэг эх сурвалж дээр хүчин чармайлтаа нэгтгэж, парламентын сонгуулийн талаарх баримт шалгалтыг баримт шалгагч нарт болон олон нийтэд илүү хялбар хүртээмжтэй болгоход чиглэн ажиллана гэжээ.<sup>80</sup>

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулиар тодорхойлсон цахим орчин дах сонгуулийн сурталчилгааг зохицуулахад гуравдагч этгээдтэй хамтран ажиллах талаар тухайлан зохицуулаагүй. Гэхдээ сонгуулийг үйл ажиллагаанд баримтлах шударга ёсны зарчим, сонгогчид үнэн зөв мэдээлэл хүргэх, түүний сонголтод хууль бусаар хөндлөнгөө шууд болон шууд бус байдлаар нөлөөлөхгүй байлгах хүрээнд сонгуулийн хугацаанд “худал мэдээлэл” болон “deep fake” мэдээллийг хянан шалгаж, нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг дэмжиж ажиллах шаардлага үүсэж байна.

Third Check Party буюу Mongolian Fact-Checking centre нь Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн үүр төв НҮТББ-ын харьяанд редакцийн бодлогын хувьд бүрэн хараат бус, бие

---

<sup>77</sup> Election 2022: Fact-Checking and Countering Misinformation <https://www.state.gov/briefings-foreign-press-centers/fact-checking-and-countering-misinformation>

<sup>78</sup> European Fact-Checking Standards Network, <https://efcsn.com/>

<sup>79</sup> Lauralie Schweiger, Immune to fake news, <https://www.deutschland.de/en/topic/culture/fact-checking-in-germany-recognizing-fake-news>

<sup>80</sup> Angie Drobnic Holan, European fact-checkers prepare for elections under a new law that regulates tech companies, 2023, <https://www.poynter.org/fact-checking/2023/european-fact-checkers-prepare-for-elections-under-a-new-law-that-regulates-tech-companies/>

даасан байдлаар ажиллах<sup>81</sup> зарчмыг баримталдаг байх тул дэмжих замаар хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулж, сонгуулийн хугацаанд сонгогчид нөлөөлөх хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлж, үнэн зөв бодит мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.

#### Товч дүгнэлт

Энэхүү бүлэгт deep fake мэдээлэл болон худал мэдээллийн хяналтын тухайн олон улсын туршлага болон тэдгээрт хөндлөнгийн мониторинг хийдэг байгууллагыг дэмжиж ажиллах тухай судалсан. Deep fake гэдэг нь хиймэл оюун ухаан ашиглан бүтээгдсэн, жинхэнэ мэт санагдах, бодит байдал дээр болж байгаагүй үйлдлийг илэрхийлсэн хиймэл эсвэл синтетик аудио эсвэл дүрс бичлэгийг хэлэх бөгөөд олж илрүүлэх тухай зохицуулалт хийх оролдлогыг зарим улс орон хийсэн байна. Харин худал болон төөрөгдүүлсэн мэдээлэлтэй тэмцэх асуудал нь илүү сайн зохицуулалттай байх бөгөөд сонгуулийн сурталчилгаанд сонгогчдын үзэл санаа болон сонгуулийн үр дүнд шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжтой худал мэдээллийг санаатайгаар түгээн дэлгэрүүлсэн тохиолдолд оногдуулах хариуцлага нь нэг жилийн хорих ялаас 75,000 еврогийн торгууль байна.

---

<sup>81</sup> Mongolian fact checking center, <https://mfcc.mn/mfcc-n-tuhai/>

## **ТАВДУГААР БҮЛЭГ. Олон нийтийн сүлжээний платформын сонгуулийн үеийн тусгай зохицуулалт**

Энэ бүлэгт Монгол Улсын хэмжээнд өргөн ашиглагддаг олон нийтийн сүлжээний платформ нь сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой гарсан санал, гомдлыг хянан шийдвэрлэх явцыг судалсан болно.

### **5.1 META (Facebook, Instagram болон бусад) хүсэлт, гомдлыг шийдвэрлэх процесс**

Аливаа орны загийн газар болон бусад холбогдох эрх бүхий байгууллага нь META-гийн олон нийтийн сүлжээний платформд байрлах аккаунт, контент болон бусад төрлийн нийтлэл нь тухайн улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзвэл META руу тухайн зөрчлийг арилгуулахаар хүсэлт илгээдэг. Ерөнхий дүрмийн дагуу энэхүү хүсэлтийг төрийн бус байгууллага болон META-гийн хэрэглэгчид ч гаргах боломжтой бөгөөд гагцхүү хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацаа дээр зөрүү гарах боломжтой юм. META нь Global Network Initiative<sup>82</sup> болон Corporate Human Right Policy<sup>83</sup>-н гишүүн байгууллагын хувьд хүлээсэн үүргийнхээ хүрээнд дээрх хүсэлтийг хянах үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн байж болзошгүй контентийг устгах хүсэлтийг хянан үзэх процесс:

1. Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагаас контентийг хязгаарлах, устгах хүсэлтийг тусгайлан тогтсон сувгаар (ногоон суваг) хүлээн авна. Эхлээд хүсэлтийг META-гийн баримталдаг бодлогыг<sup>84</sup> зөрчсөн эсэхийг шалгах ба зөрчил илэрсэн тохиолдолд шууд устгана.
2. Зөрчил илрээгүй тохиолдолд хүсэлт үндэслэлтэй эсэхийг баталгаажуулахын тулд хууль зүйн дүн шинжилгээг META-гийн хуулийн хэлтэс хийнэ. Ингэхдээ тусгайлан хүний эрхийг хамгаалах тухай хууль зүйн задлан шинжилгээг давхар хийнэ.
3. Хууль зүйн дүн шинжилгээний үндсэн дээр хүсэлт дотоодын хууль тогтоомжийг зөрчөөгүй, хүчин төгөлдөр бус, хэт өргөн хүрээтэй, олон улсын хүний эрхийн стандартад нийцэхгүй гэж үзэж байгаа тохиолдолд тухайн хүсэлт өгсөн этгээдээс тодруулга авах эсвэл аливаа арга хэмжээ авахгүй байх эрхтэй. Арга хэмжээ авахгүй байх шийдвэр гарсан тохиолдолд энэ тухай мөн хүсэлт гаргасан этгээдэд мэдэгдэнэ.
4. Хэрэв хууль зүйн дүн шинжилгээний үндсэн дээр тухайн улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд зөрчил бүхий аккаунт эсвэл контентыг устгахдаа зөвхөн тухайн улсаас хандаж болохгүй байхаар тохиргоотой хийнэ. Энэхүү

---

<sup>82</sup> GNI нь компаниудад хэрэглэгчийн мэдээллийг шилжүүлэх, устгах, харилцаа холбоог хязгаарлах зэрэг засгийн газрын дарамт шахалттай тулгарах үед үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн нууцын эрхийг хүндэтгэн үзэхэд дэмжлэг үзүүлдэг байгууллага. Гишүүд нь ихэвчлэн үндэстэн дамнасан компаниуд байх бөгөөд бусад улсын засгийн газруудтай тодорхой хэмжээгээр харилцаа холбоо, хамтын ажиллагаатай байна.

<sup>83</sup> CHRP нь META-гийн дотоодын хүний эрхийг хамгаалах тухай баримт бичиг болно.

<sup>84</sup> Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас гаргасан тодорхойлолтын дагуу Facebook Community Standard, Instagram Community Guidelines зэргийг ийнхүү орчуулав.

шийдвэрийг тухайн аккаунт болон контентын эзэмшигчид мэдэгдэнэ. Үүнээс өөр төрлийн буюу торгууль зэрэг арга хэмжээ авахгүй.

5. Төлбөртэй зар сурталчилгаа нь дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд тухайн зар сурталчилгааг зөвхөн харьяаллын улсаар хязгаарлагдахгүй нийт сүлжээнээс устгана.



Дээрх процессыг явуулахад МЕТА-гийн баримталдаг үндсэн зарчмууд байх бөгөөд үүнд: (а) дотоодын хууль тогтоомжийн нийцлийг шалгахад гадна тухайн улс олон улсын хүний эрхийг зарчмын ямар түвшинд дагаж мөрддөгийг баталгаажуулах; (б) аливаа аккаунт, контентыг устгах хүсэлт нь олон улсын хүний эрхийн тухай хууль ёсны үндэслэлүүдийг хангасан эсэх;<sup>85</sup> (в) хязгаарлах, устгах хүсэлт ардчилсан нийгмийн тогтолцоог хадгалж үлдэхэд зайлшгүй шаардлагатай байх; (г) хязгаарлах, устгах хүсэлт нь тухайн зөрчилд тохирсон байх; болон (д) аливаа гадны эрсдэл байгаа эсэх багтана. Гэвч, МЕТА хүсэлт хянан шийдвэрлэх процессын хугацааг тодорхой заагаагүй бөгөөд кэйс тус бүрээс хамааран онцлог байдгийг дурджээ.

“Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал” судалгааны тайланд дурдсанаар, Фейсбүүк компанитай хамтран ажиллах хүрээнд Монгол Улсад 2019 оны 10-р сард албан ёсоор “Government-Case-Work-Channel” буюу шууд харилцах ногоон сувгийг нэвтрүүлсэн байна.<sup>86</sup> Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2020 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль, 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаанд хамтран ажиллаж, зөвхөн хууль бус, фейсбүүк

<sup>85</sup> Эдгээр үндэслэлд бусдын эрхийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зэрэг багтана.

<sup>86</sup> ХЗҮХ “Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал” судалгааны тайлан, 2022 он.

хэрэглэгчийн дагаж мөрдөх хэм хэмжээ “Community Standards”-г зөрчсөн контентыг платформаар устгах чиглэлээр ажилласан байна.<sup>87</sup>

## 5.2 X буюу Twitter-т илгээсэн хүсэлт, гомдлыг шийдвэрлэх процесс

Твиттер нь аливаа зөрчилтэй хаягийг устгах эсвэл түр хугацаагаар хаах арга хэмжээг авах хүсэлтийг хүлээж авдаг.

Зөрчлийн төрөл	Твиттер баримталдаг бодлогыг <sup>88</sup> зөрчих	Хууль тогтоомжийг зөрчих
Тодорхойлолт	Аюулгүй байдал, хүний эрх, үг хэлэх эрх чөлөө, ялгаварла гадуурхалтын эсрэг зохицуулалтууд	Хууль тогтоомжийг аль нэг улсынх эсвэл олон улсын баримт бичиг зэргээр ялгаагүй бөгөөд ерөнхийлөн нэрлэсэн
Гомдол, хүсэлт гаргах процесс	Зөрчлийг арилгуулах гомдол хүсэлтийг хүлээж авах үндсэн сувгаар илгээх ( <a href="https://help.twitter.com/en/forms">https://help.twitter.com/en/forms</a> )	Засгийн газар, эрх бүхий этгээд эсвэл шүүхийн шийдвэрийг үндэслэн X хаягийг хаах хүсэлтийг тусгай сувгаар илгээх ( <a href="https://legalrequests.twitter.com/forms/landing_disclaimer">https://legalrequests.twitter.com/forms/landing_disclaimer</a> ) Ингэхдээ, хязгаарлахыг хүссэн хаяг, контентыг болон зөрчигдөөд буй хууль тогтоомжийг хавсарган илгээнэ.
Гомдол шийдвэрлэх процесс	Аль аль гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэхээр тусгасан боловч тодорхой процесс, хугацаа зэргийг заагаагүй байна.	
Авах арга хэмжээ	Зөрчсөн гэж үзвэл тухайн хаягийг хаах, түр хугацаагаар хязгаарлах.	Зөрчсөн гэж үзвэл тухайн хаягийг хаах, түр хугацаагаар хязгаарлах. Ингэхдээ хязгаарлалт нь тухайн гомдол, хүсэлт өгсөн улсын нутаг дэвсгэр дээр үйлчлэхээр арга хэмжээг авна.

<sup>87</sup> ХЗҮХ “Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал” судалгааны тайлан, 2022 он.

<sup>88</sup> X Rules буюу X-ийн бодлогын баримт бичиг: <https://help.twitter.com/en/rules-and-policies/x-rules>



### 5.3 Youtube хүсэлт, гомдлыг шийдвэрлэх процесс

Youtube-ийн сонгуулийн үед худал мэдээлэл зохицуулах бодлогын хүрээнд ноцтой хохирол учруулах эрсдэлтэй зарим төрлийн худал эсвэл төөрөгдүүлсэн контентыг YouTube дээр тавихыг хориглосон байна.<sup>89</sup> Үүнд техникийн аргаар боловсруулсан худал мэдээлэл, ардчилсан зарчимд саад учруулж болзошгүй бусад контент зэрэг бодит байдалд хохирол учруулж болзошгүй худал болон төөрөгдүүлсэн мэдээлэл багтана.

Ийнхүү зөрчил үүсгэсэн контентыг цахимаар гомдол гарган шийдвэрлүүлэх бөгөөд хэрхэн шийдвэрлэх процесс нь олон нийтэд ил бус байна.

“Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал” судалгааны тайланд дурдсанаар, Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2021 оны 05-р сараас эхлэн тус платформтой хамтран ажиллаж, хууль бус контентыг “trusted partner” горимоор мэдээлж эхэлсэн.<sup>90</sup>

Харин дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Youtube хаяг хаах, хязгаарлах, Youtube суваг дээр байршуулсан контентыг устгах зэрэгтэй холбоотой гомдол, хүсэлт нь Google компанийн Ил тод байдлын бодлогоор зохицуулагддаг байна.<sup>91</sup> Тус бодлогын хүрээнд аливаа улсын засгийн газар, эрх бүхий холбогдох байгууллага болон шүүх нь цахим болон бусад сувгийг ашиглан бичгээр ирүүлнэ. Ингэхдээ зөрчил үүсгэж буй хаяг, контентын мэдээлэл болон зөрчигдөж буй дотоодын хууль тогтоомжийн хуулбар, орчуулга зэргийг давхар ирүүлэх шаардлагатай. Бусад олон нийтийн сүлжээний платформын адилаар тус платформ нь тухайн ирсэн саналд өөрсдийн зүгээс үнэлэлт хийх бөгөөд хэрэв зөрчил нь бодитой гэж үзвэл хаягийг хаах, устгах зэрэг арга хэмжээг авдаг. Гэвч энэхүү процесс нь ямар журмаар явдаг болон хэрхэн шийдвэрлэгддэг зэрэг нь олон нийтэд нээлттэй бус байна.

#### Товч дүгнэлт

Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны томоохон хэсгийг эзэлдэг олон нийтийн сүлжээний платформ дээрх зөрчилтэй хаяг, контентыг хаах, хязгаарлах асуудал нь аливаа улсын дотоодын эрх зүйн зохицуулалтаас хальсан асуудал байдаг. Харин хамтын ажиллагаа болон өөрсдийн хариуцлагын хүрээнд тухайн олон нийтийн сүлжээний платформ нь компанийн баримталдаг бодлогын хүрээнд зөрчилтэй хаяг, контентыг зохицуулдаг. Мөн тухайн платформ дээрх аливаа контент нь аль нэг улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн гэх гомдол, саналыг тусгай сувгаар хүлээн авч хянадаг механизмтай байна. Манай улсын хувьд МЕТА-тай тус сувгаар харилцдаг бөгөөд цаашид

<sup>89</sup> Youtube Elections misinformation policy, available at: <https://support.google.com/youtube/answer/10835034?hl=en>

<sup>90</sup> ХЗҮХ “Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал” судалгааны тайлан, 2022 он.

<sup>91</sup> Google Transparency Policy, Government request to remove content. Available at: <https://transparencyreport.google.com/government-removals/overview?hl=en>

бусад олон нийтийн сүлжээний платформуудтай ижил хамтын ажиллагааг эхлүүлэх боломжтой юм.

## Дүгнэлт

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулахаас хамрах хүрээ, зохицуулалтын субъектээр ялгаатай байгаа бөгөөд олон улсын туршлагыг харахад, хэдий улс орнууд өргөн нэвтрүүлэг тэргүүтэй уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгддэг сонгуулийн сурталчилгааг зохицуулдаг боловч цахим орчин дахь сурталчилгааг төдийлөн үр дүнтэй зохицуулж чадахгүй байна. Мөн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа нь ардчилсан нийгмийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, ил тод байдал, эрх тэгш байдал, мэдэх эрх зэрэг суурь эрхтэй хэрхэн уялдаж байгааг тодруулах шаардлага үүсэж байна. Мөн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаанд ямар төрлийн мэдээлэл ордгийг тусгайлан тодорхойлох шаардлагатай бөгөөд ингэхдээ сонгуулийн сурталчилгаа болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хоёрын зааг ялгааг мөн тодорхойлох нь зүйтэй юм.

Түүнчлэн, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг үнэлэх үндсэн нэг шалгуур нь түүний нөлөөлөл байх бөгөөд нөлөөллийг тодорхойлоход цахим орчин дахь мэдээллийн хамрах хүрээ буюу хандалтыг харгалзах шаардлагатай. Ингэхдээ, нийтлэг байдлаар бус өөрийн улс орны нийт хүн ам, тэр дундаа цахим орчин хэрэглэгчийн тоог харгалзан үзэх нь зүйтэй бөгөөд үүнийг үндэслэн хандалтын шалгуурын гаргах боломжтой юм.

Улс орнууд харилцан адилгүй байдлаар сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах эрх зүйн орчныг тодорхойлж байгаа хэдий ч дараах зохицуулалтууд нийтлэг байна. Үүнд:

- Цахим орчинд сонгуулийн сурталчилгааг явуулах сонгуулийн зарчмыг дагаж мөрдөнө.
- Цахим орчинд үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллага аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчид давуу байдлыг олгохгүй бөгөөд тэнцвэрийг хадгална.
- Цахим орчинд сонгуулийн сурталчилгааг явуулж буй этгээдийг таньж тодорхойлох арга хэмжээг зайлшгүй авна.
- Сонгуулийн сурталчилгаанд хамаарах агуулга, хориглосон хэм хэмжээг тодорхойлно.
- Сонгуулийн сурталчилгааг хэзээ байршуулсан, хэдэн хүнд хүрсэн, сонгуулийн үр дүнд нөлөөлж буй эсэх зэрэг шалгуурыг тодорхойлох замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон сонгуулийн үйл ажиллагааг шударгаар зохион байгуулах тэнцвэрийг хангана.
- Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаа ил тод байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Олон нийтийн цахим сүлжээний платфoмoоc өөрөө удирдах буюу self-regulation баталж, хэрэгжүүлэх зэрэг багтаж байна.

Харин манай улсын дотоодын зохицуулалтыг үзвэл, Сонгуулийн хороонд бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хуулиар хориглосон тул Сонгуулийн тухай хуулийн 47.1.3-т заасан “Бусад цахим хуудас”-ыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах боломжгүй байна. Гэтэл Сонгуулийн тухай хуулийн 47.5, 47.7.1-т тус тус “Бусад цахим хуудас”-ыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан нь (1) бүртгүүлээгүй бусад цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах боломжтой эсхүл (2) бүртгүүлээгүй бусад цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашигласан тохиолдолд тус хуудсыг хааж, Зөрчлийн тухай хуульд заасан торгуулийн хариуцлагыг ногдлуулах хууль зүйн хоёрдмол тайлбарыг бий болгож, хуулийн зохицуулалт нэг мөр хэрэгжих боломжгүй, энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд хуулийн нэгдмэл байдлаар тайлбарлаж хэрэглэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Тийм учраас, нэн тэргүүнд хуулийн зохицуулалт хоорондын нийцлийг хангаж, зохицуулалтыг нэгдмэл байдлаар ойлгож, хэрэглэх шаардлага үүсэж байна.

Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны томоохон эрсдэлийн нэг нь “deep fake” мэдээлэл болон худал мэдээллийн хяналтын юм. Deep fake гэдэг нь хиймэл оюун ухаан ашиглан бүтээгдсэн, жинхэнэ мэт санагдах, бодит байдал дээр болж байгаагүй үйлдлийг илэрхийлсэн хиймэл эсвэл синтетик аудио эсвэл дүрс бичлэгийг хэлэх бөгөөд олж илрүүлэх тухай зохицуулалт хийх оролдлогыг зарим улс орон хийсэн байна. Харин худал болон төөрөгдүүлсэн мэдээлэлтэй тэмцэх асуудал нь илүү сайн зохицуулалттай байх бөгөөд сонгуулийн сурталчилгаанд сонгогчдын үзэл санаа болон сонгуулийн үр дүнд шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжтой худал мэдээллийг санаатайгаар түгээн дэлгэрүүлсэн тохиолдолд оногдуулах хариуцлага нь нэг жилийн хорих ялаас 75,000 еврогийн торгууль байна. Үүнээс гадна, олон улсын туршлагыг судлан “deep fake” мэдээлэл болон худал мэдээлэлд хөндлөнгийн мониторинг хийдэг байгууллагыг дэмжиж ажиллах шаардлагатай.

Түүнчлэн, цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны томоохон хэсгийг эзэлдэг олон нийтийн сүлжээний платформ дээрх зөрчилтэй хаяг, контентыг хаах, хязгаарлах асуудал нь аливаа улсын дотоодын эрх зүйн зохицуулалтаас хальсан асуудал байдаг. Харин хамтын ажиллагаа болон өөрсдийн хариуцлагын хүрээнд тухайн олон нийтийн сүлжээний платформ нь компанийн баримталдаг бодлогын хүрээнд зөрчилтэй хаяг, контентыг зохицуулдаг. Мөн тухайн платформ дээрх аливаа контент нь аль нэг улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн гэх гомдол, саналыг тусгай сувгаар хүлээн авч хянадаг механизмтай байна. Манай улсын хувьд МЕТА-тай тус сувгаар харилцдаг бөгөөд цаашид бусад олон нийтийн сүлжээний платформуудтай ижил хамтын ажиллагааг эхлүүлэх боломжтой юм.

## Зөвлөмж

### Зөвлөмж 1.

Дотоодын эрх зүйн зохицуулалтыг нийцлийг хангахтай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн 47.1 дэх хэсэгт заасан цахим хуудсуудыг бүртгүүлэх болон бүртгүүлээгүй цахим хуудсаар сонгуулийн сурталчилгааг явуулахгүй байх зохицуулалт хоорондын зөрчилдөөнийг судалгааны 3-р бүлэгт дурдсан хувилбарыг аль нэгийг сонгох замаар арилгах арга хэмжээг авах;

### Зөвлөмж 2.

Олон улсын чиг хандлага, гадаад улс орнуудын эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор Захиалагчийн ажлын даалгаварт дурдсан журмын төсөлтэй холбоогүйгээр цаашид “Сонгуулийн зар сурталчилгаанд цахим орчин ашиглах” талаарх зарчмын шинжтэй суурь зохицуулалт болон хориглосон хэм хэмжээг Сонгуулийн тухай хуульд дараах байдлаар тусгах:

- Цахим орчинд дахь сонгуулийн сурталчилгаанд баримтлах зарчим тодорхой болгох;
- Цахим орчин дахь сонгуулийн зар сурталчилгаа явуулах платформыг бүртгүүлэхээр хуульчлах;
- Дээрх бүртгэлийг хийлгээгүй боловч цахим орчинд хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээд болон инфлүнсертэй холбоотой шударга, тэгш сонгуулийн сурталчилгааны үүрэг бий болгох;
- Цахим орчинд болон радио, телевизээр, сонин, сэтгүүлээр нэгэн зэрэг сонгуулийн сурталчилгаа явуулдаг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тусгай зохицуулалт оруулж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Цахим орчин дахь сонгуулийн зар сурталчилгааг хийж буй этгээд болох санхүүжүүлэгчийн таньж тодорхойлох ажиллагааг хариуцан гүйцэтгэх этгээдийг тодорхойлох;
- Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны агуулгын хориглосон хэм хэмжээг хуульд заах;
- Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааны болон ил тод байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтыг сонгуулийн сурталчилгаанд баримтлах зарчим болон санхүүжилтийн зардал хэсэгт оруулах;
- Хүний хувийн мэдээллийг хууль бусаар цуглуулж, боловсруулж, ашиглах замаар түүн рүү чиглэсэн зорилтот буюу сонголтод нөлөөлөхийг хуулиар хориглох;

### **Зөвлөмж 3.**

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн үзэл санаа, зорилго болон тус хуульд заасан сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зохицуулалтад хамаарах зохицуулалтыг нарийвчлан тодорхойлогдох чиглэгдэнэ. Тиймээс хуулийн агуулгаас өргөн хүрээний харилцааг журмаар зохицуулах боломжгүйн зэрэгцээ хуулиар хориглоогүй харилцааг захиргааны хэм хэмжээний актаар хориглохгүй байх зарчмыг захиргааны байгууллага үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө. Судалгааны багаас тус зарчмыг харгалзан үзэхийн зэрэгцээ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалтын хуулийн зорилго, сонгуулийн зарчимд нийцүүлэн тайлбарлах замаар журмын төсөлд нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналыг Хавсралт 1-ээр хүргүүлж байна.

*Хавсралт 1. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтын судалгааг үндэслэж боловсруулсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын төсөл.*

## **ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ (Төсөл)**

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.7 дахь заалтад заасан цахим орчин ашиглан ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулийн сурталчилгаа явуулах болон түүнд хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулна

1.2. Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч болон тэдгээрийн сонгууль эрхэлсэн байгууллага нь цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сонгуулийн хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернетийн үйлчилгээ эрхлэгч болон интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь сонгуулийн хугацаанд энэ журмын 1.2-т заасан хууль тогтоомж, журмыг дагаж мөрдөнө.

1.4. “Цахим орчны үйлчилгээ эрхлэгч” гэдэгт цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контент, бүтээлийг олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлэгч хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

1.5. “Нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн цахим хуудас” гэдэгт нэр дэвшигчийн өөрийн болон улс төрийн нам, эвслийн эзэмшиж, ашигладаг вебсайтыг ойлгоно.

1.6. “Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас” гэдэгт цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хаяг/ пэйж хуудас, профайл/-ийг ойлгоно.

1.7. “Бусад цахим хуудас” гэдэгт Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч болон тэдгээрийн сонгууль эрхэлсэн байгууллагын соотой байгуулсан **гэрээний дагуу сонгуулийн сурталчилгааг нийтлэх үүрэг хүлээсэн** интернэтэд Цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн удирддаг вебсайтыг ойлгоно. 1.4.4.

**“Бусад цахим хуудас”** гэж сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг явуулах цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн удирддаг, эсхүл эзэмшдэг вебсайтыг ойлгоно;

1.4.5 **“Эрх бүхий байгууллага”** гэж Сонгуулийн ерөнхий хороо, тагнуулын төв байгууллага, цагдаагийн төв байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, хяналтын улсын байцаагч хамаарна.

1.5 Тус журмаар зохицуулаагүй харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтална.

### **Хоёр. Цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах, хяналт тавихад баримтлах зарчим**

2.1. Сонгуулийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын хүрээнд сонгуулийн сурталчилгааг цахим хуудсанд байршуулахад нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл */нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, нээлттэй ил тод харагдахуйц байдлаар тэмдэглэсэн байна.*

2.2 Сонгуулийн сурталчилгаа явуулах цахим хуудсыг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ. Бүртгүүлээгүй цахим хуудсаар сонгуулийн сурталчилгааг явуулахыг хориглоно.

2.3. Сонгууль эрхэлсэн байгууллага нь бүртгэлтэй цахим хуудсаар сонгуультай холбоотой мэдээ, мэдээллийг нийтлэхдээ дараах цахим хуудасны мэдээ, мэдээллийг эх сурвалжаа болгохгүй:

2.3.1. албан ёсны бус веб хуудас;

2.3.2. албан ёсны бус олон нийтийн сүлжээний цахим хуудас;

2.3.3. эх сурвалж нь тодорхойгүй мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн цахим хуудас;

2.4. Сонгуулийн үйл ажиллагаанд шударга ёс, сонгогчид үнэн зөв, бодит мэдээллийг хүргэх зарчмыг хангах хүрээнд сонгуулийн сурталчилгааг нийтлэхээр бүртгүүлээгүй интернетэд суурилсан үйл



ажиллагаа эрхлэгч нь аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчид давуу эсхүл сул талыг бий болгосон мэдээ, мэдээлэл нийтлэхгүй.

2.5. Эрх бүхий байгууллага нь сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулсантай холбоотой аливаа хэрэг маргаан шийдвэрлэх, арга хэмжээ авахдаа мэдээллийн агуулга болон сонгогчдын шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэх хэмжээг харгалзаж үзнэ.

2.6. Сонгогчдын хувийн мэдээлэл (цахим шуудан, утасны дугаар, гэрийн хаяг г.м)-ийг хууль бусаар цуглуулж, боловсруулах замаар мэдээллийн сан үүсгэж, сонгуультай холбоотой зар сурталчилгаанд ашиглахгүй.

### **Гурав. Сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэл**

3.1. Нэр дэвшигч нь өөрийн болон нам, эвслийн цахим хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг тус тус сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд хуульд заасан хугацаанд багтаан аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүртгэл хариуцсан ажилтанд бүртгүүлнэ.

3.2. Сонгуулийн ерөнхий хороо нь журмын 3.1-д цахим хуудсыг бүртгүүлэх бүртгэлийн хуудсыг дараах агуулгаар журмын Хавсралт 1-ээр батална:

3.2.1. цахим хуудасны домэйн нэр, вэб хуудас болон вэб сайтын байршлын (вэб/сервер хостинг) талаарх мэдээлэл, тухайн хуудасны админ эрх олгогдсон этгээдийн мэдээлэл, нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл;

3.2.2. цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудасны бүртгэлийн хаяг, бүртгүүлсэн нэр, цахим шуудан, утасны дугаар, цахим холбоос хаяг (URL хаяг), тухайн хуудасны админ эрх олгогдсон этгээдийн мэдээлэл, нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл.

3.3. Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч Монгол улсын иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-д заасны дагуу төлбөртэй сонгуулийн сурталчилгаа явуулах тохиолдолд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо байгуулагдсанаас хойш сонгуулийн сурталчилгаа эхлэх хүртэл аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүртгэл хариуцсан ажилтанд бүртгүүлнэ.

3.4. Сонгуулийн ерөнхий хороо нь журмын 3.3-д заасан цахим хуудсыг бүртгүүлэх бүртгэлийн хуудсыг дараах агуулгаар журмын Хавсралт 2-оор батална:

3.4.1. цахим хуудасны домэйн нэр, вэб хуудас болон вэб сайтын байршлын (вэб/сервер хостинг) талаарх мэдээлэл, цахим хуудас эзэмшигч хувь хүн бол овог, нэр, харьяалал, хаяг, утасны дугаар, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, төлөөлөх эрх бүхий этгээд, харьяалал, албан ёсны хаяг, утасны дугаар;

3.4.2. цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудасны бүртгэлийн хаяг, бүртгүүлсэн нэр, цахим шуудан, цахим холбоос хаяг (URL хаяг), цахим хуудас эзэмшигч хувь хүн бол овог, нэр, харьяалал, хаяг, утасны дугаар, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, төлөөлөх эрх бүхий этгээд, эцсийн өмчлөгчийн харьяалал, албан ёсны хаяг, утасны дугаар.

3.5. Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан бүртгэлийн хуудсыг бүрэн гүйцэт, үнэн зөв бөглөж, ирүүлсэн тохиолдолд аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүртгэл хариуцсан ажилтан нь нэн даруй бүртгэх бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг бүртгүүлэгч этгээд хариуцна.

3.6. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн мэдээллийг бүртгэл хийснээс хойш нэг хоногийн дотор Харилцаа холбооны зохицуулах хороо болон Сонгуулийн ерөнхий хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.7. Нам, эвсэл, нэр дэвшигчийн бүртгүүлсэн цахим хуудасны жагсаалт болон интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгүүлсэн цахим хуудасны жагсаалтыг Сонгуулийн ерөнхий хороо болон Харилцаа холбооны зохицуулах хороо нь өөрийн албан ёсны цахим хуудаст сонгуулийн жил дуусах хүртэл хугацаанд байршуулна.

### **Дөрөв. Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг**

4.1. Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг цахим орчинд шуурхай хангуулах ажлын хүрээнд холбогдох эрх бүхий байгууллагууд хамтран ажиллана.

4.2. Эрх бүхий байгууллагууд нь хамтран ажиллах эрх бүхий албан тушаалтны овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, факсын дугаар, цахим хаягийн жагсаалтыг гаргаж, сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 7 хоногийн өмнө харилцан солилцоно.

4.3. Цахим хуудаст нийтлэгдсэн сонгуультай холбоотой мэдээ, мэдээллийг хянан шалгасан эрх бүхий байгууллага нь хууль бус үйлдлийг тогтоож, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай

хуулийн 47.7-д заасан арга хэмжээг авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хороонд дараах санал, шийдвэрийг цахим хэлбэр (цахим шуудан, систем, чат гэх мэт)-ээр нэн даруй хүргүүлнэ.

4.3.1. Эрүүгийн хуулийн 14.8-д заасан гэмт хэрэгт холбогдуулан Тагнуулын байгууллагын санал;

4.3.2. Зөрчлийн тухай хуулийн 17.1.13, 17.1.15-д заасныг зөрчсөн гомдолтой холбоотой Цагдаагийн байгууллагын санал;

4.3.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.7 дахь заалтыг зөрчсөн гомдолтой холбоотой Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газрын шийдвэр;

4.4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11 дэх хэсэгт заасны дагуу Сонгуулийн Ерөнхий хорооноос гаргасан шийдвэрийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо нь тус хуульд заасан арга хэмжээг зохион байгуулна.

4.5. Эрх бүхий байгууллагууд нь цахим орчин дахь хууль бус сонгуулийн сурталчилгаатай холбоотой санал, шийдвэрийг цахим хэлбэрээр нэн даруй Харилцаа холбооны зохицуулах газарт хүргүүлэх бөгөөд хэвлэмэл байдлаар шуудангаар хүргүүлнэ.

4.7 Эрх бүхий байгуулагаас гарах санал, шийдвэр нь дараах хэлбэрийн болон агуулгын шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.7.1. Санал, шийдвэрийг гаргасан эрх бүхий байгууллагын нэр, хаяг, тамга, тэмдэг дарагдсан, эрх бүхи албан тушаалтны нэр, гарын үсэг зурагдсан, албан бичгийн он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх;

4.7.2. Санал, шийдвэр гаргаж буй шалтгаан, нөхцөл байдал нь энэ журмын 4.3, 4.4-т заасан аль үндэслэлд хамаарч байгааг заах;

4.7.3. Санал, шийдвэрийг гаргах болсон нөхцөл байдлыг тайлбарлах;

4.7.4 Санал, шийдвэрийн дагуу авах арга хэмжээг зохион байгуулах хугацааг заах;

4.7.5 Хууль зөрчсөн зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийг байршуулсан цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг хавсаргах;

4.8 Эрх бүхий байгууллагаас гаргасан санал нь энэ журмын 4.7-д заасан шаардлагуудыг хангаагүй тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хороо нь санал, шийдвэр бүрэн бус байгаа талаар хариу мэдэгдэнэ. Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн санал, шийдвэр нь журмын шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд Харилцан холбооны зохицуулах хорооноос журмын 7-р бүлэгт заасан арга хэмжээг зохион байгуулна.

4.6. Харилцаа холбооны зохицуулах хороо нь авсан арга хэмжээний талаарх мэдээллийг санал, шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

### **Тав. Бусад холбогдох байгууллагын эрх, үүрэг**

5.1. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй:

5.1.1. сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс гүйцэтгэх удирдлага болон сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамтран ажиллах техникийн багийн овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;

5.1.2. сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөл бололцоогоор хангах;

5.1.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.8, 47.11 дэх хэсэгт заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлэхээс өмнө туршилтыг хийх, техник технологийн бэлэн байдлыг хангасан байх;

5.1.4. интернетийн үйлчилгээ эрхлэгч нь зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт /black-list.mn/-ыг өөрийн сүлжээнд даруй хязгаарлах;

5.1.5. зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтыг сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд 4 цаг тутамд шинэчлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэн даруй шинэчлэх;

5.1.6. интернетийн үйлчилгээ эрхлэгч нь домэйн нэрийн сервер (Domain Name Server)-тээ болон сүлжээний хамгаалалтын төхөөрөмж (Firewall)-дөө “[www.black-list.mn](http://www.black-list.mn)” домэйн нэрт харгалзах АйПи(IP) хаягаас ирэх домэйн нэрийн асуулга, хүсэлтийг зөвшөөрөх, хариулах боломжийг бүрдүүлсэн байх;

5.1.7. интернетийн үйлчилгээ эрхлэгч нь интернетийн үйлчилгээнд ашиглаж буй домэйн нэрийн серверүүд (Domain Name Server)-ийн АйПи (IP) хаягууд болон хариуцан ажилладаг ажилтны овог, нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;

5.1.8. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 47.7-д заасан эрх бүхий байгууллагуудад шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх, технологийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцааг үзүүлэх;

5.1.9. эцсийн хэрэглэгчийг тодорхойлох боломжтойгоор бүх төрлийн домэйн болон АйПи(IP) хаяг руу хандсан талаар лог бүртгэлийг 1 сарын хугацаатайгаар хадгалдаг байх.

5.2. Бүртгэлгүй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүрэгтэй:

5.2.1. сонгуультай холбоотой мэдээ, мэдээллийг дамжуулахдаа агуулгын хувьд аль нэг нам, нэр дэвшигчид давуу болон сул талыг бий болгохоос зайлсхийж, шударга байх үүрэгтэй;

5.2.2. сонгуулийн мэдээ, мэдээллийг дамжуулахдаа агуулгын бүтэц болон харьцааны хувьд нам, нэр дэвшигч тус бүрд тэгш хандах, тэнцвэртэй байлгах үүрэгтэй;

5.2.3. сонгуультай үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг түгээхдээ бодит /объектив/ байдлаар хандах үүрэгтэй бөгөөд бодит байдал болон өөрийн үзэл бодол нь ялгагдаж байх ёстой;

5.2.4. сонгуулийн сурталчилгаа нийтлэх эрхгүй этгээд болохынхоо хувьд өөрийн үйл ажиллагааг нь удирддаг цахим хуудаст хэрэглэгчийн зүгээс нийтэлж буй мэдээлэлд сонгуулийн хууль тогтоомжид нийцүүлж хяналт тавина.

5.3. Бүртгэлтэй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүрэгтэй:

5.3.1. сонгуулийн сурталчилгаа явуулахдаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл /нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, ил тод харагдахуйц байдлаар нийтлэх;

5.3.2. нам, эвсэл, нэр дэвшигчийн олон нийтийн сүлжээний цахим хуудасны сурталчилгаа саадгүй явуулах технологийн боломжоор хангах арга хэмжээ авах;

5.3.3. нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд түр хязгаарлах буюу сонгогчдод харагдахгүй болгох технологийн арга хэмжээ авах;

5.3.4. төлбөртэй сонгуулийн сурталчилгаа хийсэн тохиолдолд сонгуулийн сурталчилгааг захиалсан этгээд болон сонгуулийн сурталчилгааны төлбөрийн талаарх мэдээлэл агуулсан тайланг сонгуулийн санал хураах өдрийн дараа өдрөөс хойш 5 хоногийн дотор бүртгэл хийлгэсэн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлнэ;

5.3.5. аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь 5.3.4-д заасан тайланг хүлээж авснаас хойш нэг хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ;

5.3.6. энэ журмын 7.4-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх техник технологийн боломжийг заавал хангасан байх;

5.3.7. интернетэд суурилсан хэвлэл мэдээллийн чиглэлээр арилжааны үйл ажиллагаа эрхлэгч нь сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.

5.3.8. сонгуулийн мэдээ, мэдээлэл нийлэхдээ энэ журмын 5.2-т заасан үүргийг бүртгэлгүй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн нэгэн адил хүлээнэ.

5.4. Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч нь дараах үүрэгтэй:

5.4.1. сонгуулийн сурталчилгаа явуулахдаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл /нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, ил тод харагдахуйц байдлаар нийтлэх;

5.4.2. нам, эвсэл, нэр дэвшигч нь цахим хуудас болон цахим шуудангийн мэдээллээ аливаа халдлагаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

5.4.3. нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаанд ашигласан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд түр хязгаарлах буюу сонгогчдод харагдахгүй болгох технологийн арга хэмжээ авах.

**Зургаа. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой маргааны харьяалал**

6.1. Цахим орчинд явуулж байгаа сонгуулийн сурталчилгаа сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзвэл нам, эвсэл, нэр дэвшигч нь эрх бүхий байгууллагад өргөдөл, гомдлыг гаргаж болно.

6.2. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.7 болон 48.7-д заасан хориглосон хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой гомдлыг Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөрчил шалган шийдвэрлэнэ.

6.3. Зөрчлийн тухай хуулийн 17.1.13, 17.1.15-д заасан зөрчилтэй холбоотой гомдлыг цагдаагийн байгууллага шалган шийдвэрлэнэ.

6.4. Эрүүгийн тухай хуулийн 14.8 дугаар зүйлд заасан гэмт хэрэгтэй холбоотой гомдлыг Тагнуулын байгууллага эрүүгийн журмаар шалган шийдвэрлэнэ.

6.5. Нэр дэвшигч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.3, 48.1.6, 48.1.7, 48.5.1, 48.5.1, 48.5.2-т заасныг зөрчсөн тогтоогдсонтой холбоотой өргөдөл, гомдлыг тус хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо арга хэмжээ авна.

6.6. Зөрчлийн тухай хуулийн 17.1.14, 17.1.15, 17.1.17-д заасан зөрчилтэй холбоотой гомдлыг хяналтын улсын байцаагч хянан шийдвэрлэнэ.

6.7. Зөрчлийн тухай хуулийн 17.1.7, 17.1.16, 17.1.18-д заасан зөрчилтэй холбоотой гомдлыг цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлт явуулсны үндсэн дээр Эрүүгийн хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.

**Долоо. Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчид авах арга хэмжээ**

7.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 4.5-д заасан санал, шийдвэрт үндэслэн зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийг нийтэлсэн цахим хуудсыг хаах, хандах эрхийг түр хязгаарлах тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллагын санал, шийдвэрийн хамт интернэтэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчид нэн даруй мэдэгдэнэ

7.2. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 7.1-т заасан мэдэгдлийг тухайн интернэтэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн цахим орчин дахь хаяг эсхүл Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгэлтэй цахим шуудангаар хүргүүлснээр мэдэгдсэнд тооцно.

7.2. Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь энэ журмын 7.1-т заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг мэдэгдэлд заасан хугацаанд даруй хэрэгжүүлж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр нэр даруй ирүүлнэ.

7.3. Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь хууль бус үйлдлээ таслан зогсоогоогүй эсхүл давтан үйлдсэн тохиолдолд түүний цахим хуудас болон олж тогтоох боломжгүй этгээдийн удирдаж, үйл ажиллагааг нь явуулж буй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуустал хаах, эсхүл тодорхой хугацаагаар түр хязгаарлах арга хэмжээ авах тухай мэдэгдлийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос операторын үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нарт нэн даруй цахим хэлбэрээр хүргүүлнэ.

7.4. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 7.3-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.

### **Найм. Хариуцлага**

8.1. Энэ журмыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Хавсралт 2. Сонгуулийн сурталчилгааг цахим орчин ашиглаж явуулахтай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага

Хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага	Хуулиар эрх олгосон байдал	Хориглосон хэм хэмжээ	Авах арга хэмжээ/Хууль зүйн хариуцлага
Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48.13 дугаар зүйл.	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль:</p> <p>48.1.7. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэхийг хориглоно.</p> <p>48.7.Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хуулийн 48.14-т зааснаар ШӨХТГ хэвлэл мэдээллийн байгууллагад эхний удаа сануулах арга хэмжээ авч болно.</li> <li>2. Хуулийн 48.15-д зааснаар зөрчлийг шалгах хугацаанд ШӨХТГ нь санал хураалтын дүн гарах хүртэлх хугацаанд үйл ажиллагааг нь зогсоох тухай дүгнэлтийг зөвшөөрөл олгосон байгууллагад нь хүргүүлэх арга хэмжээг авч болно.</li> <li>3. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Хуулийн 48.15-д заасан дүгнэлтийг үндэслэн <b>тухайн телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг дүгнэлтэд дурдсан хугацаагаар хязгаарлах арга хэмжээг авна.</b></li> </ol> <p>*Энэ зөрчлийн тохиолдолд цахим хуудсыг хаах, түр хязгаарлах үндэслэлийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар зохицуулаагүй үлдээсэн тул ХХЗХ-оос цахим хуудсыг хязгаарлах арга хэмжээ авахгүй.</p>
Цагдаагийн байгууллага	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн	Зөрчлийн тухай хууль:	хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

	1.8 дугаар зүйлийн 6.8 дах хэсэг	17.1.13 Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол	
		17.1.15 Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол	хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
<b>Тагнуулын байгууллага</b>  (хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна)	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	<b>Эрүүгийн хууль:</b>  <b>14.8 дугаар зүйлийн 1. Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол</b>	дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
<b>Харилцаа холбооны зохицуулах хороо</b>	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.7	<b>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль:</b>  <b>Тус хуулийн 35.3, 47.4-т заасныг зөрчсөн талаарх гомдлын дагуу тагнуулын байгууллага эсхүл цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо холбогдох арга хэмжээг нэн даруй авна.</b>	Харилцаа холбооны зохицуулах хороо нь:  47.7.1-т зааснаар 47.1.1, 47.1.3-т заасан цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн дүн гарч дуусталх хугацаагаар хаана.  47.7.2-т зааснаар 47.1.2-т заасан тухайн цахим хуудсыг хаах, эсхүл түр хугацаагаар хязгаарлах арга хэмжээг авна.
<b>Сонгуулийн Ерөнхий хороо</b>	Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 75.2 дах хэсэг	<b>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль:</b>  <b>35.3.Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглоно.</b>	75.2-т зааснаар Нэр дэвшигч ... 35.3, 48.1.6, 48.1.7, 48.5.1, 48.5.2-т заасныг зөрчсөн болох нь санал хураалтын дүн гаргахаас өмнө тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.
		48.1.6. Сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулахыг хориглоно.	

		48.1.7. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэхийг хориглоно.	Дээрх шийдвэрт холбогдох гомдлыг шийдвэр гарснаас хойш 7 хоногт багтаан хуулийн 81.4-т зааснаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар гомдол гаргана.
		48.5.1. Энэ хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.	
		48.5.2. Зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.	
Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.50 хэсэг	Зөрчлийн тухай хууль:	хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
		17.1.14. Үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаагаагүй бол	
		<b>17.1.15 Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол</b>	хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
		17.1.17. Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдээс бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийсэн бол	хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
		17.1.20. Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад оролцсон, эсхүл сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн, нийтэлсэн бол	хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
Эрүүгийн шүүх (Цагдаагийн байгууллага хэрэг	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар	<b>Зөрчлийн тухай хууль:</b> <b>17.1.7 Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийгэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол</b>	хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

бүртгэлтэй үйл ажиллагааг явуулна.)	зүйлийн 7 дах хэсэг	17.1.16 Хүн, хуулийн этгээд нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийн дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал өдрийг дуустал сонгогчдын санал татах зорилгоор сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулсан, эсхүл харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
		17.1.18 Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан, эсхүл зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн, эсхүл нам, эвслийн нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн мөрийн хөтөлбөрөөс тусдаа мөрийн хөтөлбөр ашигласан бол	хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
<b>Харилцаа холбооны зохицуулах хороо</b>	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.11 дэх хэсэг	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль: 47.11-т зааснаар Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн	цахим орчин дах олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авна.

*Хавсралт 3. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журамд орсон нэмэлт өөрчлөлт болон тэдгээрийн үндэслэл.*

<b>ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ</b> / Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт /	<b>ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРМЫН ТӨСӨЛ</b>	<b>ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР</b>
<b>*Өөрчлөөгүй, Өөрчлөлт орсон, Хасагдсан, Шинээр нэмсэнийг ялган тэмдэглэж, үндэслэл, тайлбарыг оруулав.</b>		
<b>Нэг. Ерөнхий зүйл</b>	<b>Нэг. Ерөнхий зүйл</b>	

<p>1.1. Энэхүү журмаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.7, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.7 дахь заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.7 дахь заалтад заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах болон түүнд хяналт тавихтай холбогдон гарах харилцааг зохицуулна.</p> <p><i>/Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</i></p>	<p>1.1. Энэхүү журмаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.7 дахь заалтад заасан цахим орчин ашиглан ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулийн сурталчилгаа явуулах болон түүнд хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулна.</p>	<p>Зөвхөн УИХ-ын сонгуулийн сурталчилгааг цахим орчин явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой болгож хүрээг нарийвчилсан. Иймд энэ хэсгийг өөрчлөн найруулсан.</p>
<p>1.2. Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийг төлөөлсөн этгээд нь цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сонгуулийн хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.</p>	<p>1.2. Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгууль эрхэлсэн байгууллага нь цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сонгуулийн хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.</p>	<p>Өөрчлөгдөөгүй.</p>
<p>1.3. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернетийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны интернетэд суурилсан үйлчилгээ эрхлэгч (цахим хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, аппликэйшн, гэх мэт) нь сонгуулийн сурталчилгааны хугацаанд энэ журмын 1.2-т заасан хууль тогтоомж, журмыг мөн адил дагаж мөрдөнө. <i>/Энэ хэсэгт СЕХ-ын 2020 оны 280-р</i></p>	<p>1.3. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернетийн үйлчилгээ эрхлэгч болон интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь сонгуулийн сурталчилгааны хугацаанд энэ журмын 1.2-т заасан хууль тогтоомж, журмыг дагаж мөрдөнө.</p>	<p>Энэхүү журам нь нэг талаас нам, эвсэл, нэр дэвшигчийг цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахдаа ямар зарчим барих, хэрхэн цахим хуудсаа бүртгүүлэх, эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд ямар журмаар гомдол гаргах талаар нарийвчлан зохицуулснаас гадна үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернетийн үйлчилгээ эрхлэгч болон интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нар мөн энэхүү журам үйлчлэхээр өөрчлөн найруулсан.</p> <p>Учир нь үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.8-д зааснаар зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаах үүрэг хүлээсэн байдаг.</p>

<p><u>тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</u></p>		<p>Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчид хамаарах цахим орчинд хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчийн хувьд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48.7-д заасны дагуу сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглодог бөгөөд мөн хуулийн 47.4-т бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг нийтлэг байдлаар/бүх субъектэд хамааралтай байдлаар/ тус тус хориглосон. Харин төлбөртэй сонгуулийн сурталчилгааг бусад цахим хуудсаар буюу интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн цахим хуудас/веб хуудас, олон нийтийн сүлжээний хуудаснууд бүгд хамаарна/-аар хийж болох тухай зохицуулсан.</p> <p>Иймд дээрх этгээдүүдэд цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам хамааралтай байна.</p>
<p>1.4.Энэ журмын 1.2-т заасан этгээд нь цахим шуудан, цахим хуудас болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулж болно.</p>	<p>Хассан.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1-тэй давхардаж байна гэж үзсэн бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 60.1.8-д заасны дагуу бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх ёстой.</p>
<p>1.5.Гүний цахим хуудас /Deep Web/-наас бусад бүх төрлийн контентийг хэрэглэгчид хүргэдэг веб сайт, цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас (пэйж хуудас) нь энэ журмын үйлчлэлд хамаарна. /Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар нэмсэн/, /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар өөрчлөн найруулсан/</p>	<p>Хассан.</p>	<p>Зохицуулалтаас хасах хууль зүйн үндэслэл байхгүй.</p>

<p>Шинээр нэмсэн.</p>	<p>1.4. Журамд дурдсан нэр томъёог дараах байдлаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:</p> <p>1.4.1. “Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч” гэж цахим орчинд интернет хэрэглэгчийн хандалтыг татах зорилгоор тогтмол контент нийтлэж, түүгээрээ дамжуулан цахим орчинд ашгийн төлөө, тогтвортой үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийг;</p> <p>1.4.2. “Нэр дэвшигчийн болон нам эвслийн өөрийн цахим хуудас” гэж нэр дэвшигчийн өөрийн болон улс төрийн нам, эвслийн эзэмшиж, ашигладаг вебсайтыг;</p> <p>1.4.3. “Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас” гэж нэр дэвшигч болон нам, эвслийн удирддаг болон эзэмшлийн олон нийтийн сүлжээний цахим хуудсыг;</p> <p>1.4.4. “Бусад цахим хуудас” гэж нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүнээс бичгээр байгуулсан гэрээний дагуу сонгуулийн сурталчилгааг нийтлэх үүрэг хүлээсэн интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн удирддаг вебсайт болон олон нийтийн сүлжээний цахим хуудсыг;</p> <p>1.4.5 “Эрх бүхий байгууллага” гэж Сонгуулийн ерөнхий хороо,</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1-д заасны дагуу сонгуулийн сурталчилгаанд нэгд, нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас; хоёрт, цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас; гуравт бусад цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглаж болохоор заасан боловч эдгээр цахим хуудасны ялгаа нь сонгуулийн оролцогч этгээдүүд болон энгийн иргэдэд ойлгомжтой, тодорхой харагдахгүй байна. Иймд сонгуулийн ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих зарчмын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн зорилго, системчлэлийн үүднээс цахим хуудас бүрийн ялгааг бий болгож тусгасан.</p> <p>Мөн Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд зааснаар Монгол улсын иргэн нь итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Иймд сонгуулийн сурталчилгаа, мэдээ, мэдээлэлтэй холбогдуулан интернет хэрэглэгчдийг бүхэлд нь хянах боломжгүй бөгөөд үүнээс зөвхөн интернетэд суурилсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээ, мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч гэх мэт интернет хэрэглэгчдийн хандалтыг татах зорилгоор тогтмол контент бүтээж, түүгээрээ дамжуулан цахим орчинд ашгийн төлөө, тогтвортой үйл ажиллагаа эрхлэгч нарын хувьд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1.3-т заасан “бусад цахим хуудас”-ыг үйл ажиллагааг нь удирдагч, эзэмшигч болохынхоо хувьд энэ журамд заасан эрх, үүргийг хүлээх юм. Өөрөөр хэлбэл, иргэн А-гийн фэйсбүүк хаягаараа тавьсан аливаа пост нь зохицуулалтад хамаарахгүй. Хамааруулахгүй байхын тулд “Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч”-ийг тодорхойлох шаардлагатай юм.</p>
-----------------------	--	---

	<p>тагнуулын төв байгууллага, цагдаагийн төв байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, хяналтын улсын байцаагч хамаарна.</p>	
<p>Шинээр нэмсэн.</p>	<p>1.5 Тус журмаар зохицуулаагүй харилцаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай</p>	<p>Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой үүсэх аливаа харилцааг зөвхөн энэ журам бүхэлд нь зохицуулах боломжгүй тул хууль хэрэглэх тусгайгаас ерөнхий рүү чиглэх зарчмын хүрээнд нийтлэг үйлчлэх зохицуулалтыг тогтоосон.</p>



	хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтална.	
<b>Хоёр. Баримтлах зарчим</b>	<b>Хоёр. Цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах, хяналт тавихад баримтлах зарчим</b>	
<p>2.1.Сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулахдаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл /нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, нээлттэй ил тод харагдахуйц байдлаар нийтэлнэ.</p> <p>/Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар өөрчлөн найруулсан/</p>	<p>2.1.Сонгуулийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын хүрээнд сонгуулийн сурталчилгааг цахим хуудсанд байршуулахад нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл /нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, нээлттэй ил тод харагдахуйц байдлаар тэмдэглэсэн байна.</p>	<p>Ойлгомжтой, тодорхой байлгах үүднээс ялимгүй өөрчлөлт оруулсан.</p>

<p>2.2.Сонгуульд нэр дэвшигчийн бүртгэлтэй цахим хаяг, цахим хуудас нь аливаа мэдээ, мэдээллийг нийтлэхдээ албан бус цахим хаяг, цахим хуудас сонинд нийтлэгдсэн мэдээллийг эх сурвалжаа болгон ашиглахгүй./гөслийн 2.3-т өөрчлөн найруулсан/</p> <p>/Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>2.2.Сонгуулийн сурталчилгаа явуулах цахим хуудсыг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ. Бүртгүүлээгүй цахим хуудсаар сонгуулийн сурталчилгааг явуулахыг хориглоно.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1-д сонгуулийн сурталчилгаанд ашиглаж болох 3 хэлбэрийн “цахим хуудас”-ыг 47.1.1, 47.1.2, 47.1.3-т тогтоож өгсөн бөгөөд мөн хуулийн 47.2-т зөвхөн 47.1.1 болон 47.1.2-ыг бүртгүүлэх тухай заасан байна. Харин 47.4-т бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хориглосон. Эндээс үзэхэд 47.1.3-т заасан “цахим хуудас”-ыг бүртгүүлэхгүй сонгуулийн сурталчилгаанд ашиглаж болох юм шиг логик гарч байгаа ч эргээд бүртгүүлээгүй гэдэг утгаараа 47.4-т зааснаар сонгуулийн сурталчилгаанд ашиглах боломжгүй мэт хоорондоо зөрчилтэй зохицуулалт байна. Иймд энэ зүйлийн зорилго, агуулгын үүднээс эдгээр зохицуулалтыг тайлбарлах, хэрэглэх шаардлага гарч байгаа бөгөөд 47.2-т “47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудсыг...” гэх мэтээр аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг бүртгүүлэх үүрэг ногдуулахдаа “47.1.3”-ыг хууль тогтоогч санамсаргүй оруулаагүй байх магадлалтай байна. Энэ ойлгомжгүй байдлыг арилгах үүднээс энэхүү зарчмын зохицуулалтыг оруулсан.</p>
--	--	--

<p>Журмын 2.2-ыг өөрчлөн найруулсан.</p>	<p>2.3. Сонгууль эрхэлсэн байгууллага нь бүртгэлтэй цахим хуудсаар сонгуультай холбоотой мэдээ, мэдээллийг нийтлэхдээ дараах цахим хуудасны мэдээ, мэдээллийг эх сурвалжаа болгохгүй:</p> <p>2.3.1. албан ёсны бус веб хуудас;</p> <p>2.3.2. албан ёсны бус олон нийтийн сүлжээний цахим хуудас;</p> <p>2.3.3. Эх сурвалж нь тодорхойгүй мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн цахим хуудас;</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.19.-д заасны дагуу хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй бөгөөд энэхүү заалт нь цахим орчинд ч мөн хамааралтай. Мөн 35.3-д заасны дагуу аливаа этгээд нь нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглодог. Эдгээр зохицуулалтад үндэслэн сонгуультай холбоотой мэдээ, мэдээлэл нийтлэхдээ баримтлах зарчмыг тусгасан.</p>
--	--	--

Шинээр нэмсэн.	<p>2.4. Сонгуулийн үйл ажиллагаанд шударга ёс, сонгогчид үнэн зөв, бодит мэдээллийг хүргэх зарчмыг хангах хүрээнд сонгуулийн сурталчилгаа нийтлэхээр бүртгүүлээгүй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчид давуу эсхүл сул талыг бий болгосон мэдээ, мэдээлэл нийтлэхгүй.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.13.-д заасны дагуу радио, телевиз нь мэдээллийн хөтөлбөрөөрөө нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх сонгуулийн үйл явцын мэдээллийг хүргэхдээ бодит, тэнцвэртэй, нэг талыг барихгүй, хараат бус байх зарчмыг баримтлах үүрэгтэй бөгөөд 48.7-д зааснаар аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглодог. Нэгэнт цахим орчинд ч хэвлэл мэдээллийн байгууллага болон мэдээ, мэдээлэл нийтлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нар үйл ажиллагаагаа явуулж байгаа учраас эдгээр заалт нь цахим орчинд мөн ижил үйлчлэх ёстой зарчмын заалт юм. Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.4-т зааснаар бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг тус тус хориглосон. Эдгээр заалтуудыг үндэслэн зөвхөн сонгуулийн сурталчилгааг нийтлэхээр бүртгүүлээгүй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчид нь аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчид давуу эсхүл сул талыг бий болгосон мэдээ, мэдээлэл нийтлэх эрхгүй бөгөөд харин энгийн интернет хэрэглэгч нарын хувьд ямар нэг хязгаарлалтад орохгүй учраас үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хязгаарлагдахгүй юм.</p>
Шинээр нэмсэн.	<p>2.5. Эрх бүхий байгууллага нь сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулсантай холбоотой аливаа хэрэг маргаан шийдвэрлэх, арга хэмжээ авахдаа тухайн зөрчилтэй мэдээ, мэдээллийн агуулга болон сонгогчдын шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэх хэмжээг харгалзаж үзнэ.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаар сонгуулийн зарчим нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад үндэслэдэг тул сонгогчийн мэдэх эрх болон нэр дэвшигчийн мэдээллээ түгээх эрхийг хязгаарлахгүй байх шаардлага бий болдог. Мөн эрх бүхий байгууллага нь дээрх хуулийн 7.4-т заасан хууль дээдлэх зарчим, ил тод байдлыг хангах зарчим, шударга ёсыг сахих зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох үүрэгтэй. Цахим орчны онцлог нь тухайн зөрчилтэй мэдээ, мэдээллийн агуулгаас гадна гол анхаарах ёстой асуудал нь тухайн мэдээ, мэдээллийн “хандалт авсан байдал” буюу “нөлөөлөл” бий болсон байдал нь чухал ач холбогдолтой байдаг. Иймд дээрх үндсэн зарчмын хүрээнд цахим орчны онцлогтой нийцүүлэн баримтлах зарчмыг тусгасан.</p>
Шинээр нэмсэн.	<p>2.6. Сонгогчдын хувийн мэдээлэл (цахим шуудан, утасны дугаар, гэрийн</p>	<p>Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 29.1-д заасны дагуу мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглодог. Гэтэл Монгол Улсын Их Хурлын</p>

	хаяг г.м)-ийг хууль бусаар цуглуулж, боловсруулах замаар мэдээллийн сан үүсгэж, сонгуультай холбоотой зар сурталчилгаанд ашиглахгүй.	сонгуулийн тухай хуулийн 47.6-д сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны материалыг цахим хэлбэрээр буюу цахим шуудангаар сонгогчдод хүргүүлж болохоор заасан. Эдгээр зохицуулалтын хувьд сонгуулийн сурталчилгааг сонгогчдын цахим шуудангаар нь хүргүүлэхдээ шууд ашиглах уу эсхүл сонгогчдоос зөвшөөрөл авсаны үндсэн дээр зөвхөн ашиглах боломжтой юу гэдэг дээр эргэлзээ үүсгэж болохоор байна. Гэхдээ зарчмын хувьд этгээд зохицуулалт нь хоорондоо зөрчилтэй биш юм. Учир нь хүний хувийн мэдээлэл болох цахим шууданг хууль бусаар цуглуулах, боловсруулах, ашиглахыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хориглосон бол Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар хууль ёсны дагуу цуглуулсан буюу эзнийх нь зөвшөөрлөөр сонгуулийн сурталчилгааг цахим хуудсаар нь хүргүүлэх боломжийг хуульчилсан. Иймд эдгээр зохицуулалтад үндэслэн ойлголтыг нэг мөр тодорхой болгох үүднээс энэхүү заалтыг тусгасан.
<b>Гурав. Сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэл</b>	<b>Гурав. Сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэл</b>	
3.1.Нам, эвсэл, нэр дэвшигч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудас ашиглах тохиолдолд аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ./Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/	3.1. Нэр дэвшигч нь өөрийн болон нам, эвслийн цахим хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг тус тус сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд хуульд заасан хугацаанд багтаан аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүртгэл хариуцсан албан хаагчид бүртгүүлнэ.	Энэ журам нь зөвхөн Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахаар хүрээгээ хязгаарласан тул бусад сонгуультай холбоотой хэсэг хасагдсан.
3.3.Нам, эвсэл, нэр дэвшигч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн сурталчилгаанд цахим хуудас ашиглах тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлнэ. /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/	Хассан.	Энэ журам нь зөвхөн Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахаар хүрээгээ хязгаарласан тул бусад сонгуультай холбоотой хэсэг хасагдсан.

<p>3.3.1. Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан бүртгэлийн хуудас; /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p> <p>3.3.2. цахим хуудасны домэйн нэр, вэб хуудас болон вэб сайтын байршлын (вэб/сервер хостинг) талаарх мэдээлэл; /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p> <p>3.3.3. цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудасны бүртгэлийн хаяг, бүртгүүлсэн нэр, цахим шуудан, утасны дугаар, цахим холбоос хаяг (URL хаяг). /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>3.2. Сонгуулийн ерөнхий хороо нь журмын 3.1-д цахим хуудсыг бүртгүүлэх бүртгэлийн хуудсыг дараах агуулгаар журмын Хавсралт 1-ээр батална:</p> <p>3.2.1. цахим хуудасны домэйн нэр, вэб хуудас болон вэб сайтын байршлын (вэб/сервер хостинг) талаарх мэдээлэл, тухайн хуудасны админ эрх олгогдсон этгээдийн мэдээлэл, нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл;</p> <p>3.2.2. цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудасны бүртгэлийн хаяг, бүртгүүлсэн нэр, цахим шуудан, утасны дугаар, цахим холбоос хаяг (URL хаяг), тухайн хуудасны админ эрх олгогдсон этгээдийн мэдээлэл, нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хууль зүйн техникийн хувьд зөвхөн Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд хамааралтай мэт бичигдсэн байна.</li> <li>2. Админ эрх олгогдсон этгээдийн нийтэлсэн аливаа мэдээ, мэдээллийг сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий этгээд хариуцах эсэх дээр маргаан гарахаас сэргийлэх, сонгуулийн сурталчилгааны үеэр зөрчилтэй мэдээ, мэдээллийг засах, устгах ажлыг хурдан шуурхай авах хүрээнд бүртгэл хийхдээ авах шаардлагатай мэдээллийг тусгасан.</li> <li>3. Бүртгэж байгаа цахим хуудасны хэлбэр нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1-д заасан аль хэлбэр болохоос хамаарч бүртгэлийн хуудсаар авах мэдээлэл өөр өөр байх тул үүнийг харгалзан энэхүү хэсэгт бүртгэлийн хуудасны мэдээллийн агуулгыг тодорхойлсон.</li> </ol>
--	--	---

Шинээр нэмсэн.	<p>3.3. Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч Монгол улсын иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-д заасны дагуу төлбөртэй сонгуулийн сурталчилгаа явуулах тохиолдолд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо байгуулагдсанаас хойш сонгуулийн сурталчилгаа эхлэх хүртэл аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.2 дах хэсэгт 47.1.3-т заасан цахим хуудас “бичилтийн техник”-ийн алдаанаас болоод тусгагдаагүй гэж үзэж байгаа тул шууд 47.2-ыг эшлэх тохиолдолд 47.1.3-т заасан цахим хуудас бүртгүүлэх шаардлагагүй гэсэн логикт хүрэх тул мөн хуулийн 47.4-ийг үндэслэн 47.1.3-т заасан цахим хуудсыг агуулгаар бичиж зохицуулсан.</li> <li>2. Сонгуулийн үндсэн зарчим нь Монгол улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад орших тул гадаад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах нь үндэсний эрх ашигт сөрөг нөлөөтэй буюу энэхүү зарчимд харш тул “Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч Монгол улсын иргэн, хуулийн этгээд” 47.1.3, 47.5-ыг үндэслэн зөвхөн сонгуулийн сурталчилгааг төлбөртэй нийтлэх эрх эдлэхээр зохицуулсан.</li> </ol>
Шинээр нэмсэн.	<p>3.4. Сонгуулийн ерөнхий хороо нь журмын 3.3-д заасан цахим хуудсыг бүртгүүлэх бүртгэлийн хуудсыг дараах агуулгаар журмын Хавсралт 2-оор батална:</p> <p>3.4.1. цахим хуудасны домэйн нэр, вэб хуудас болон вэб сайтын байршлын (вэб/сервер хостинг) талаарх мэдээлэл, цахим хуудас эзэмшигч хувь хүн бол овог, нэр, харьяалал, хаяг, утасны дугаар, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, төлөөлөх эрх бүхий этгээд, харьяалал, албан ёсны хаяг, утасны дугаар;</p> <p>3.4.2. цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудасны бүртгэлийн хаяг, бүртгүүлсэн нэр, цахим</p>	<p>Дээрх заалтыг нэмсэнтэй холбоотойгоор интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч болон сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий этгээдийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор тухайн хэлбэрийн цахим хуудасны онцлогт нийцүүлэн шаардлагатай үед авах арга хэмжээг үр дүнтэй байлгах үүднээс бүртгэлийн хуудасны мэдээллийг тогтоосон. Мөн зөвхөн “Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч Монгол улсын иргэн, хуулийн этгээд” 47.1.3, 47.5-ыг үндэслэн зөвхөн сонгуулийн сурталчилгааг төлбөртэй нийтлэх эрх эдлэх хүрээнд харьяалалын талаарх мэдээлэлийг авахаар тусгаж өгсөн.</p>

	шуудан, цахим холбоос хаяг (URL хаяг), цахим хуудас эзэмшигч хувь хүн бол овог, нэр, харьяалал, хаяг, утасны дугаар, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, төлөөлөх эрх бүхий этгээд, эцсийн өмчлөгчийн харьяалал, албан ёсны хаяг, утасны дугаар.	
Шинээр нэмсэн.	3.5. Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан бүртгэлийн хуудсыг бүрэн гүйцэт, үнэн зөв бөглөж, ирүүлсэн тохиолдолд аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүртгэл хариуцсан ажилтан нэн даруй бүртгэх бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг бүртгүүлэгч этгээд хариуцна.	<ol style="list-style-type: none"> <li>1. Цахим хуудасны аль ч хэлбэрийг бүртгүүлсэн бүртгэл хийлгэсэн этгээд бөглөсөн мэдээллийнхээ үнэн зөвийг хариуцах үүрэгтэй. Учир нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.4-т зааснаар бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг тус тус хориглодог.</li> <li>2. Сонгууль зохион байгуулах төрийн байгууллага, түүний албан тушаалтан нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 7.4.1-д зааснаар үйл ажиллагаандаа хууль дээдлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд энэ зарчмын хүрээнд бүртгэл хариуцсан ажилтан нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан бүртгэлийн хуудсыг бүрэн гүйцэт, үнэн зөв бөглөж, ирүүлсэн тохиолдолд үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй юм.</li> </ol>
3.4. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн мэдээллийг бүртгэл хийснээс хойш нэг хоногийн дотор Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ <i>/Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</i>	3.6. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн мэдээллийг бүртгэл хийснээс хойш нэг хоногийн дотор Харилцаа холбооны зохицуулах хороо болон Сонгуулийн ерөний хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.	Өөрчлөөгүй.
3.5. Нам, эвсэл, нэр дэвшигчийн бүртгүүлсэн цахим хуудасны жагсаалтыг Сонгуулийн ерөнхий хороо болон Харилцаа холбооны зохицуулах хороо нь өөрийн албан ёсны цахим хуудсаар мэдээлнэ. <i>/Энэ</i>	3.7. Нэр дэвшигчийн бүртгүүлсэн цахим хуудасны жагсаалт болон интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгүүлсэн цахим	



<p>хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>хуудасны жагсаалтыг Сонгуулийн ерөнхий хороо болон Харилцаа холбооны зохицуулах хороо нь өөрийн албан ёсны цахим хуудаст сонгуулийн жил дуусах хүртэл хугацаанд байршуулна.</p>	
<p>3.6.Нам, эвсэл, нэр дэвшигч нь цахим хуудас болон цахим шуудангийн мэдээллээ аливаа халдлагаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.</p> <p>/Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>Журмын төслийн 5.4.2-т тусгасан.</p>	
<p>3.7.Цахим үйлчилгээ эрхлэгч нь сонгуулийн сурталчилгаа явуулах тохиолдолд сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлнэ. /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/ /Энэ хэсгийг СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмсэн/</p>	<p>Хассан.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Цахим үйлчилгээ эрхлэгч нэр томьёо хэт өргөн.</li> <li>2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1-д сонгуулийн сурталчилгаа явуулахдаа ашиглаж болох “цахим хуудас”-ны 3 хэлбэрийг хуульчилсан бөгөөд эдгээрийн бүртгэл хийх бүрэн эрх нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд байх тул хуулиар олгоогүй эрх хэмжээг Харилцаа холбооны зохицуулах хороонд олгож журмын зохицуулалт хийсэн байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 60.1.1-ийг зөрчсөн байна.</li> </ol>
<p>Дөрөв. Сонгуулийн сурталчилгааны хяналтын горим</p>	<p>Долоо. Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчид авах арга хэмжээ</p>	<p>Журмын төслийн хувьд Дөрөв дүгээр бүлэг нь “Цахим орчинд дахь сонгуулийн сурталчилгааны хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг”, тавдугаар бүлэг нь “Бусад холбогдох байгууллагын эрх, үүрэг”, зургаа дугаар бүлэг нь “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой маргааны харьяалал”-ын талаар зохицуулсан.</p>

<p>4.1.Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана. /Энэ хэсэгт СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>		<ol style="list-style-type: none"> <li>1. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа журмын 4.1 дэх заалт нь журмын төслийн 6.1 өөрчлөн найруулж тусгасан. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулсантай холбоотой маргааны харьяалуулсан зарим байгууллага нь татан буугдсан.</li> <li>2. Журмын төслийн 4.1 нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 5.1-ийг хэвээр тусгасан.</li> <li>3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 7.1-д “сонгуулийн зарчим нь Монгол улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад үндэслэнэ” гэж заасны дагуу сонгууль зохион байгуулахад хамтран оролцох байгууллагууд нь сонгууль зохион байгуулах богино хугацаанд хурдан шуурхай хамтран ажиллах шаардлага бий болдог.</li> </ol>
<p>4.2.Энэ журмын 4.1-д заасан эрх бүхий байгууллага нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан үзээд эрх бүхий албан тушаалтны шийдвэр бүхий албан бичиг дүгнэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ. /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>Журмын 4.5-д тусгасан.</p>	<p>Журмын зохицуулалттай уялдуулан дэлгэрүүлж тусгасан</p>
<p>4.3.Энэ журмын 4.2-т заасан албан бичиг дүгнэлгэд тухайн мэдээ, мэдээллийн цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг хавсаргана. /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>Журмын 4.7-д тусгасан.</p>	<p>Журмын зохицуулалттай уялдуулан дэлгэрүүлж тусгасан</p>
<p>4.4.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 4.2-д заасан албан бичиг дүгнэлтийн дагуу дараах мэдэгдлийг цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгчдэд даруй[1] хүргүүлнэ./Энэ хэсэгт СЕХ-ын 2020</p>	<p>7.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 4.5-д заасан санал, шийдвэрт үндэслэн зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийг нийтэлсэн цахим</p>	<p>Өөрчлөн найруулсан</p>

<p><u>оны 280-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/ /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</u>  4.4.1.мэдэгдэлд дурдсан мэдээ, мэдээллийг устгах эсвэл хандалтыг хаах, эсхүл түр хязгаарлах;/Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/</p> <p>4.4.2.мэдэгдэлд дурдсан цахим хаяг, цахим хуудсыг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуустал хандалтыг хаах, эсхүл түр хязгаарлах./Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/</p>	<p>хуудсыг хаах, хандах эрхийг түр хязгаарлах тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллагын санал, шийдвэрийн хамт интернэтэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчид нэн даруй мэдэгдэнэ</p>	
<p>4.5.Цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 4.4-т заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд даруй хэрэгжүүлж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ. /Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/, /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>7.2. Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь энэ журмын 7.1-т заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд даруй хэрэгжүүлж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр нэр даруй ирүүлнэ.</p>	<p>Өөрчлөн найруулсан.</p>

<p>4.6.Цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгчийг олж тогтоох боломжгүй эсхүл энэ журмын 4.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол Харилцаа холбооны зохицуулах хороо дараах мэдэгдлийг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгчид хүргүүлнэ:<u>Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн</u>,<u>Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан</u></p> <p>4.6.1.тухайн цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн сурталчилгааны дүн гарч дуусах хүртэлх хугацаанд хаах;<u>Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн</u>,<u>Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан</u></p> <p>4.6.2.хуульд заасан технологийн арга хэмжээ авах.</p>	<p>7.3. Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь хууль бус үйлдлээ таслан зогсоогоогүй эсхүл давтан үйлдсэн тохиолдолд түүний цахим хуудас болон олж тогтоох боломжгүй этгээдийн удирдаж, үйл ажиллагааг нь явуулж буй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуустал хаах, эсхүл тодорхой хугацаагаар түр хязгаарлах арга хэмжээ авах тухай мэдэгдлийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос операторын үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нарт нэн даруй цахим хэлбэрээр хүргүүлнэ.</p>	<p>Өөрчлөн найруулсан.</p>
<p>4.7.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 4.6-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд даруй хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.</p>	<p>7.4. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 7.3-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.</p>	<p>Өөрчлөөгүй. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.8-д заасны дагуу үүрэн холбооны болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаах үүрэг хүлээнэ.</p>

<p>4.8.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 4.4-т заасан мэдэгдлийг тухайн цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин дахь хаяг эсхүл Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгэлтэй цахим шуудангаар хүргүүлснээр мэдэгдсэнд тооцно. /Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/, /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>7.2-т оруулсан</p>	<p>Журмын ойлгомжтой байдлыг хангаж, байршлыг өөрчилсөн</p>
<p><b>Тав. Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа</b></p>	<p><b>Дөрөв. Цахим орчинд дахь сонгуулийн сурталчилгааны хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг</b></p>	
<p>5.1.Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг цахим орчинд түргэн шуурхай хангуулах ажлын хүрээнд холбогдох эрх бүхий байгууллагууд хамтран ажиллана. /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>4.1. Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг цахим орчинд шуурхай хангуулах ажлын хүрээнд холбогдох эрх бүхий байгууллагууд хамтран ажиллана.</p>	<p>Өөрчлөөгүй.</p>
<p>5.2.Энэ журмын 5.1-д заасан эрх бүхий байгууллага гэдэгт Сонгуулийн ерөнхий хороо, тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо хамаарна.</p>	<p>хассан</p>	<p>Журмын нэр томъёо хэсэгт “эрх бүхий байгууллага”-ыг тодорхойлсон.</p>

<p>5.3.Эрх бүхий байгууллагууд нь хамтран ажиллах эрх бүхий албан тушаалтны овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, факсын дугаар, цахим хаягийн жагсаалтыг гаргасан байна. /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>4.2. Эрх бүхий байгууллагууд нь хамтран ажиллах эрх бүхий албан тушаалтны овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, факсын дугаар, цахим хаягийн жагсаалтыг гаргаж, сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 7 хоногийн өмнө харилцан солилцоно.</p>	<p>Өөрчлөөгүй.</p>
<p>5.4.Эрх бүхий байгууллагууд нь цахим орчин дахь хууль бус сонгуулийн сурталчилгаатай холбоотой санал, дүгнэлтийг цахим хэлбэрээр даруй холбогдох газарт хүргүүлэх бөгөөд албан бичгийг шуудангаар хүргүүлнэ.</p> <p>/Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>4.3. Цахим хуудаст нийтлэгдсэн сонгуультай холбоотой мэдээ, мэдээллийг хянан шалгасан эрх бүхий байгууллага нь хууль бус үйлдлийг тогтоож, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.7-д заасан арга хэмжээг авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрх бүхий байгууллага нь Харилцаа холбооны зохицуулах хороонд дараах санал, шийдвэрийг хүргүүлнэ:</p> <p>4.3.1. Эрүүгийн хуулийн 14.8-д заасан гэмт хэрэгт холбогдуулан Тагнуулын байгууллагын санал;</p> <p>4.3.2. Зөрчлийн тухай хуулийн 17.1.13, 17.1.15-д заасныг зөрчсөн гомдолтой холбоотой Цагдаагийн байгууллагын санал;</p> <p>4.3.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.7 дахь заалтыг зөрчсөн гомдолтой холбоотой Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газрын шийдвэр;</p>	<p>Зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор өөрчлөн найруулсан.</p>

Шинээр нэмсэн.	<p>4.4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11 дэх хэсэгт заасны дагуу Сонгуулийн Ерөнхий хорооноос гаргасан шийдвэрийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо нь тус хуульд заасан арга хэмжээг зохион байгуулна.</p>	Сонгууль зохион байгуулахад оролцох эрх бүхий байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох зорилгоор тусгасан.
Шинээр нэмсэн.	<p>4.5. Эрх бүхий байгууллагууд нь цахим орчин дахь хууль бус сонгуулийн сурталчилгаатай холбоотой санал, шийдвэрийг цахим хэлбэрээр нэн даруй холбогдох газарт хүргүүлэх бөгөөд албан бичгийг шуудангаар хүргүүлнэ.</p>	-
Шинээр нэмсэн	<p>4.7 Эрх бүхий байгуулагаас гарах санал, шийдвэр нь хэлбэрийн болон агуулгын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <p>4.7.1. Санал, шийдвэрийг гаргасан эрх бүхий байгууллагын нэр, хаяг, тамга, гэмдэг дарагдсан, эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг зурагдсан, албан бичгийн он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх;</p> <p>4.7.2. Санал, шийдвэр гаргаж буй шалтгаан, нөхцөл байдал нь энэ</p>	Эрх бүхий байгууллагын гаргах санал, шийдвэрт тавигдах хэлбэрийн болон агуулгын шаардлагыг тусгасан.

	<p>журмын 4.3, 4.4-т заасан аль үндэслэлд хамаарч байгааг заах;</p> <p>4.7.3. Санал, шийдвэрийг гаргах болсон нөхцөл байдлыг тайбарлах;</p> <p>4.7.4 Санал, шийдвэрийн дагуу авах арга хэмжээг зохион байгуулах хугацааг заах;</p> <p>4.7.5 Хууль зөрчсөн зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийг байршуулсан цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг хавсаргах;</p>	
Шинээр нэмсэн	<p>4.8 Эрх бүхий байгууллагаас гаргасан санал, шийдвэр нь энэ журмын 4.7-д заасан шаардлагуудыг хангаагүй тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хороо нь санал, шийдвэр бүрэн бус байгаа талаар хариу мэдэгдэнэ. Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн санал, шийдвэр нь журмын шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд Харилцан холбооны зохицуулах хорооноос журмын 7-р бүлэгт заасан арга хэмжээг зохион байгуулна.</p>	<p>Санал, дүгнэлтэд заасан журмын шаардлагыг хангаагүй тохиолдолд үүсэх хууль зүйн үр дагаврыг тусгасан.</p>



<p>5.5.Эрх бүхий байгууллагууд нь энэ журмын 5.4-т заасан санал, дүгнэлт, шийдвэрийг цахим шуудангаар хүлээж авсан даруйд холбогдох арга хэмжээг авч, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг нэн даруй мэдэгдэнэ.</p> <p><i>/Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</i></p>	<p>4.6. Харилцаа холбооны зохицуулах хороо нь авсан арга хэмжээний талаарх мэдээллийг санал, шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>Шинээр оруулсан зохицуулалттай уялдулан өөрчилсөн</p>
<p><b>Зургаа. Бусад холбогдох байгууллагын эрх үүрэг</b></p>	<p><b>Тав. Бусад холбогдох байгууллагын эрх, үүрэг</b></p>	
<p>6.1. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй:</p>	<p>5.1. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй:</p>	<p>Өөрчлөөгүй.</p>
<p>6.1.1. сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс шийдвэр гаргах эрх бүхий болон техникийн ажилтан тус бүр нэг, нийт хоёр албан тушаалтныг сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамтран ажиллах төлөөлөгчөөр томилж, овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;</p>	<p>5.1.1. сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс гүйцэтгэх удирдлага болон сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамтран ажиллах техникийн багийн овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;</p>	<p>Өөрчлөн найруулсан.</p>

<p>6.1.2.сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөл бололцоогоор хангах;</p>	<p>5.1.2. сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөл бололцоогоор хангах;</p>	<p>Өөрчлөөгүй.</p>
<p>6.1.3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.8, 47.11 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.8, 46.11 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8, 42.11 дэх заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлэхээс өмнө туршилтыг хийх, техник технологийн бэлэн байдлыг хангасан байх;/Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>5.1.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.8, 47.11 дэх хэсэгт заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлэхээс өмнө туршилтыг хийх, техник технологийн бэлэн байдлыг хангасан байх;</p>	<p>Энэ журам нь зөвхөн Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахаар хүрээгээ хязгаарласан тул бусад сонгуультай холбоотой хэсэг хасагдсан.</p>
<p>6.1.4.интернетийн үйлчилгээ эрхлэгч нь зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт /black-list.mn/-ыг өөрийн сүлжээнд даруй хязгаарлах;</p>	<p>5.1.4. интернетийн үйлчилгээ эрхлэгч нь зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт /black-list.mn/-ыг өөрийн сүлжээнд даруй хязгаарлах;</p>	<p>Өөрчлөөгүй.</p>
<p>6.1.5.зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтыг сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах</p>	<p>5.1.5. зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтыг сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах</p>	<p>Өөрчилсөн.</p>

<p>өдрийн дараахь өдөр хүртэл хугацаанд 4 цаг тутамд шинэчлэх;</p>	<p>өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд 4 цаг тутамд шинэчлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэн даруй шинэчлэх;</p>	
<p>6.1.6.интернетийн үйлчилгээ эрхлэгч нь домэйн нэрийн сервер (Domain Name Server)-тээ болон сүлжээний хамгаалалтын төхөөрөмж (Firewall)-дөө“www.black-list.mn” домэйн нэрт харгалзах АйПи(IP) хаягаас ирэх домэйн нэрийн асуулга, хүсэлтийг зөвшөөрөх, хариулах боломжийг бүрдүүлсэн байх;</p>	<p>5.1.6. интернетийн үйлчилгээ эрхлэгч нь домэйн нэрийн сервер (Domain Name Server)-тээ болон сүлжээний хамгаалалтын төхөөрөмж (Firewall)-дөө “www.black-list.mn” домэйн нэрт харгалзах АйПи(IP) хаягаас ирэх домэйн нэрийн асуулга, хүсэлтийг зөвшөөрөх, хариулах боломжийг бүрдүүлсэн байх;</p>	<p>Өөрчлөөгүй.</p>
<p>6.1.7.интернетийн үйлчилгээ эрхлэгч нь интернетийн үйлчилгээнд ашиглаж буй домэйн нэрийн серверүүд (Domain Name Server)-ийн АйПи (IP) хаягууд болон хариуцан ажилладаг ажилтны овог, нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх.</p>	<p>5.1.7. интернетийн үйлчилгээ эрхлэгч нь интернетийн үйлчилгээнд ашиглаж буй домэйн нэрийн серверүүд (Domain Name Server)-ийн АйПи (IP) хаягууд болон хариуцан ажилладаг ажилтны овог, нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;</p>	<p>Өөрчлөөгүй.</p>
<p>Шинээр нэмсэн.</p>	<p>5.1.8. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 47.7-д заасан эрх бүхий байгууллагуудад шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх, технологийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцааг үзүүлэх;</p>	<p>Тагнуулын ерөнхий газраас санал ирүүлсний дагуу нэмсэн.</p>

Шинээр нэмсэн.	5.1.9. эцсийн хэрэглэгчийг тодорхойлох боломжтойгоор бүх төрлийн домэйн болон АйПи(IP) хаяг руу хандсан талаар лог бүртгэлийг 1 сарын хугацаатайгаар хадгалдаг байх.	Тагнуулын ерөнхий газраас санал ирүүлсний дагуу нэмсэн.
Шинээр нэмсэн.	<p>5.2.Бүртгэлгүй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүрэгтэй:</p> <p>5.2.1. сонгуультай холбоотой мэдээ, мэдээллийг дамжуулахдаа агуулгын хувьд аль нэг нам, нэр дэвшигчид давуу болон сул талыг бий болгохоос зайлсхийж, шударга байх үүрэгтэй;</p> <p>5.2.2. сонгуулийн мэдээ, мэдээллийг дамжуулахдаа агуулгын бүтэц болон харьцааны хувьд нам, нэр дэвшигч тус бүрд тэгш хандах/ тэнцвэртэй байлгах үүрэгтэй;</p> <p>5.2.3. сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг түгээхдээ бодит /объектив/ байдлаар хандах үүрэгтэй бөгөөд бодит байдал болон өөрийн үзэл бодол нь ялгагдаж байх ёстой;</p> <p>5.2.4. сонгуулийн сурталчилгаа нийтлэх эрхгүй этгээд болохынхоо хувьд</p>	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.12, 46.13, 46.19-д зааснаас үзвэл Монгол улс нь сонгуулийн хууль тогтоомжоор шударга, тэгш хандах, бодит тэнцвэртэй мэдээллийг түгээх зарчмыг тогтоосон бөгөөд энэхүү зарчим нь цахим орчинд ч мөн ижил үйлчлэх тул эдгээр зохицуулалтыг үндэслэн сонгуулийн сурталчилгаа нийтлэх эрхгүй буюу бүртгэлгүй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн үүргийг зохицуулсан.

	<p>өөрийн үйл ажиллагааг нь удирддаг цахим хуудаст хэрэглэгчийн зүгээс нийтэлж буй мэдээлэлд сонгуулийн хууль тогтоомжид нийцүүлж хяналт тавина.</p>	
	<p>5.3. Бүртгэлтэй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүрэгтэй:</p> <p>5.3.1. сонгуулийн сурталчилгаа явуулахдаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл /нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, ил</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1.3, 47.5-д зааснаар цахим орчин сонгуулийн сурталчилгааг төлбөртэй нийтлэх эрхтэй бөгөөд үүнийхээ хүрээнд хүлээх ёстой үүргүүдийг тодорхойлж өгсөн.</p> <p>Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.12, 46.13, 46.19-д зааснаас үзвэл Монгол улс нь сонгуулийн хууль тогтоомжоор шударга, тэгш хандах, бодит тэнцвэртэй мэдээллийг түгээх зарчмыг тогтоосон бөгөөд энэхүү зарчим нь цахим орчинд ч мөн ижил үйлчлэх тул эдгээр зохицуулалтыг үндэслэн сонгуулийн сурталчилгаа биш бөгөөд сонгуультай холбоотой мэдээ, мэдээлэл нийтлэхдээ бүртгэлгүй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн нэгэн адил үүргийг хүлээхээр зохицуулсан.</p>

	<p>тод харагдахуйц байдлаар нийтлэх;</p> <p>5.3.2. нам, эвсэл, нэр дэвшигчийн олон нийтийн сүлжээний цахим хуудасны сурталчилгаа саадгүй явуулах технологийн боломжоор хангах арга хэмжээ авах;</p> <p>5.3.3. нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд түр хязгаарлах буюу сонгогчдод харагдахгүй болгох технологийн арга хэмжээ авах;</p> <p>5.3.4. төлбөртэй сонгуулийн сурталчилгаа хийсэн тохиолдолд сонгуулийн сурталчилгааг захиалсан этгээд болон сонгуулийн сурталчилгааны төлбөрийн талаарх мэдээлэл агуулсан тайланг Сонгуулийн санал хураах өдрийн дараа өдрөөс хойш 5 хоногийн дотор бүртгэл хийлгэсэн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүднэ;</p> <p>5.3.5. аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь 5.3.1-д заасан тайланг хүлээж авснаас</p>	<p>Өөрөөр хэлбэл, сонгуулийн сурталчилгаа нийтлэх бол ил тод тэмдэглэлээ хийх ёстой, сонгуультай холбоотой мэдээ, мэдээлэл нийтлэх бол шударга, тэгш хандах зарчих болон бодит, тэнцвэртэй байх зарчмыг баримтлахыг шаардаж байна гэсэн үг.</p>
--	---	---

	<p>хойш нэг хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ;</p> <p>5.3.6. энэ журмын 7.4-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх техник технологийн боломжийг заавал хангасан байх;</p> <p>5.3.7. интернетэд суурилсан хэвлэл мэдээллийн чиглэлээр арилжааны үйл ажиллагаа эрхлэгч нь сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.</p> <p>5.3.8. сонгуулийн мэдээ, мэдээлэл нийлэхдээ энэ журмын 5.2-т заасан үүргийг бүртгэлгүй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн нэгэн адил хүлээнэ.</p>	
<p>6.2.Цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй:<u>Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн./Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.</u></p>	<p>Хассан.</p>	

<p>6.2.1.сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс шууд харилцах төлөөлөгчийг томилж, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлсэн байх;</p>	<p>Хассан.</p>	
<p>6.2.2.энэ журмын 4.4-т заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх техник технологийн боломжийг заавал хангасан байх;</p>		<p>Бүртгэлтэй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэгт өөрчлөн найруулж оруулсан.</p>
<p>6.2.3.Интернетийн домэйн нэр ашиглан мэдээ мэдээллийг хэрэглэгчид хүргэж буй бүх төрлийн веб сайт нь сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтлэх; <u>/Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/</u></p>		<p>Бүртгэлтэй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэгт өөрчлөн найруулж оруулсан.</p>
<p>6.2.4.сонгуулийн сурталчилгаа явуулахдаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл /нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, ил тод харагдахуйц байдлаар нийтлэх;</p>		<p>Бүртгэлтэй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэгт өөрчлөн найруулж оруулсан.</p>
<p>6.2.5.нам, эвсэл, нэр дэвшигчийн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг сурталчилгаа саадгүй явуулах технологийн боломжоор хангах арга хэмжээ авах.<u>/Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/</u></p>		<p>Бүртгэлтэй интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэгт өөрчлөн найруулж оруулсан.</p>



6.3. Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч нь дараах үүрэгтэй:	5.4. Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч нь дараах үүрэгтэй:	
6.3.1. сонгуулийн сурталчилгаанд цахим орчин дахь олон нийтийн сүлжээний нэг цахим хуудас ашиглах; /Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/	Хассан.	Хуульд зохицуулсан.
6.3.2. Улсын Их хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан бүртгэлийн хуудасны дагуу аймаг, нийслэлийн сонгуулийн тойргийн хороонд бүртгүүлэх; /Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/ , /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/	Хассан.	Журмын төсөлд нэгэнт зохицуулагдсан харилцаа.
6.3.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх; /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар өөрчлөн найруулсан/	Хассан.	Энэ журам нь зөвхөн Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулах, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахаар хүрээгээ хязгаарласан тул бусад сонгуультай холбоотой хэсэг хасагдсан.
<b>Долоо. Гомдол маргаан шийдвэрлэх</b>		
7.1. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернетийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч нь хүн, хуулийн этгээдийн гомдол маргааныг хүлээж авах шуудангийн хаяг, холбоо барих	Хассан.	Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулсантай холбоотой маргаан нь Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалагдан эрх бүхий этгээд шийдвэрлэгдэх бөгөөд энэ журам нь зөвхөн цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, хяналт тавихад баримтлах зарчим, журам, оролцогч

<p>утасны дугаар, цахим шуудангийн хаягийг олон нийтэд ил тод байршуулна./Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/, /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>		<p>этгээдүүдийн эрх, үүргийг зохицуулахад чиглэсэн тул журмын энэ хэсэг нь журмын зорилгодоо нийцэхгүй байна.</p>
<p>7.2.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернетийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч нь хүн, хуулийн этгээдийн гомдол, маргаантай холбоотой асуудлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад хандаж болно./Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/, /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>Хассан.</p>	
<p>7.3.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернетийн үйлчилгээ эрхлэгч, цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч нь хүн, хуулийн этгээдийн гомдол, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайланг сонгуулийн сурталчилгааны хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор гаргаж, олон нийтэд нээлтэй мэдээлнэ./Энэ хэсгийг СЕХ-ын 2020 оны 280-р тушаалаар өөрчилсөн/, /Энэ хэсэгт СЕХ-ын 2021 оны 33-р тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p>	<p>Хассан.</p>	

Шинээр нэмсэн.	Зургаа. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой маргааны харьяалал	
	6.1. Нам, эвсэл, нэр дэвшигчийн цахим орчинд явуулж байгаа сонгуулийн сурталчилгаа нь сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад өргөдөл, гомдлыг гаргаж болно.	Сонгуулийн сурталчилгааг цахим орчин ашиглан явуулах, түүнд хяналт тавих журам нь нэг талаас сонгууль эрхэлсэн байгууллага сурталчилгаа явуулахдаа баримтлах зарчим, журам боловч нөгөө талаас өөрийн эрх ашиг хөндөгдсөнтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд хаана, хэнд гаргах асуудал зохицуулах шаардлагатай. Учир нь цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулсантай холбоотой аливаа маргаан нь хэд хэдэн хуулиар өөр өөр үндэслэлээр үүсэхээр байгаа бөгөөд хууль, эрх зүйн мэдлэггүй этгээд гомдол, маргаан үүсгэхэд цаг алдах, нөгөө талаар хяналт тавих эрх бүхий этгээдэд харьяаллын бус маргаан их хэмжээгээр ирж ачаалал нэмэгдүүлэх гэх мэт сөрөг нөлөөллүүд бодит байдалд байна.  Иймд Захиргааны ерөнхий хуулийн 60.1.8-д заасантай нийцүүлэн эрх бүхий байгууллага бүрт харьяалан шийдвэрлэх маргааныг тодорхойлохдоо холбогдох хуулиас эшлэл авах байдлаар тусгалаа.
Шинээр нэмсэн.	6.2. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.7 болон 48.7-д заасан хориглосон хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой гомдлыг Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөрчил шалган шийдвэрлэнэ.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48.13 дугаар зүйлд заасны дагуу эрх олгогдсон.
Шинээр нэмсэн.	6.3. Зөрчлийн тухай хуулийн 17.1.13, 17.1.15-д заасан зөрчилтэй холбоотой гомдлыг цагдаагийн байгууллага шалган шийдвэрлэнэ.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дах хэсэгт зааснаар эрх олгогдсон.
Шинээр нэмсэн.	6.4. Эрүүгийн тухай хуулийн 14.8 дугаар зүйлд заасан гэмт хэрэгтэй	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрх олгогдсон.

	холбоотой гомдлыг Тагнуулын байгууллага эрүүгийн журмаар шалган шийдвэрлэнэ.	
Шинээр нэмсэн.	6.5. Нэр дэвшигч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.3, 48.1.6, 48.1.7, 48.5.1, 48.5.1, 48.5.2-т заасныг зөрчсөн тогтоогдсонтой холбоотой өргөдөл, гомдлыг тус хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо арга хэмжээ авна.	Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 75.2 дах хэсэгт зааснаар эрх олгогдсон.
	6.6. Зөрчлийн тухай хуулийн 17.1.14, 17.1.15, 17.1.17-д заасан зөрчилтэй холбоотой гомдлыг хяналтын улсын байцаагч хянан шийдвэрлэнэ.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.50 хэсэгт зааснаар эрх олгогдсон.
Шинээр нэмсэн.	6.7. Зөрчлийн тухай хуулийн 17.1.7, 17.1.16, 17.1.18-д заасан зөрчилтэй холбоотой гомдлыг цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлт явуулсны үндсэн дээр Эрүүгийн хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7 дах хэсэгт зааснаар эрх олгогдсон.
<b>Найм. Хариуцлага</b>	<b>Найм. Хариуцлага</b>	
8.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон	8.1. Энэ журмыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай	Өөрчлөн найруулсан.

холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.	хууль болон Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.	
[1] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.7.“даруй” гэж боломжит богино хугацааг;		“Нэн даруй” гэх хуулийн нэр томъёог ашигласан бөгөөд тодорхойлох шаардлагагүй гэж үзэв.

*Хавсралт 4. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журамд тагнуулын байгууллагаас ирүүлсэн саналыг тусгасан байдал.*

**Нэг. Зарчмын шинжтэй санал:**

Санал	Тусгасан эсэх
<p>1. Төслийн 1.3-д заасан “цахим орчны интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч”, 4.4-4.6, 4.8, 6.2, 7.1-7.3-д заасан “цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч” нь агуулгын хувьд адил ойлголт эсэх, тухайн тодорхойлолтод ямар үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээд хамаарах эсэхийг журамд нарийвчлан тодорхойлж тусгах; <i>Тайлбар: “Цахим орчны интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч”, “цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч” гэх тодорхойлолт нь нийтэд ойлгомжтой биш, холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд тайлбарлагдаж, тусгагдаагүй ойлголт байна.</i></p>	<p>“цахим орчны интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэгч”, “цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч” гэсэн нэр томъёонуудыг хасч <b>“Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч”</b> -ийг тодоройлох замаар тодорхой болгосон/журмын төслийн 1.4.1/.</p>
<p>2. Кибер орчинд социал платформ (“Meta”, “X”, “Instagram” г.м) ашиглаж байгаа нөлөөлөгч (инфлюенсер) нар орох эсэх. Хэрэв нөлөөлөгч нар орно гэвэл хэдэн мянган дагагчтай бол нөлөөлөгч гэж үзэхийг тодорхойлж тусгах;</p>	<p>Журмын төслийн 1.4.1-д <b>“Интернетэд суурилсан үйл ажиллагаа эрхлэгч”</b> -ийг тодоройлохдоо “интернет хэрэглэгчдийн хандалтыг татах зорилгоор тогтмол контент бүтээж, түүгээрээ дамжуулан цахим орчинд ашгийн төлөө, тогтвортой үйл ажиллагаа эрхлэгч”-ийг хамруулахаар тодорхойлсон. Энэ хүрээнд зарчмын хувьд инфлүүнсерүүд орох боломжтой. Гэхдээ дагагчийн тоог хатуу тогтоох нь олон улсын чиг хандлагад байхгүй бөгөөд Монгол улсын иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй зөрчилдөх магадлалтай. Иймд журмын төслийн 2.5-д зааснаар тухайн этгээдийн мэдээний агуулга болоод нөлөөлсөн байдлыг хянан шалгаж шийдвэрлэх эрх бүхий этгээд харгалзаж үзэн аливаа шийдвэр гаргахаар тусгасан.</p>
<p>3. Төслийн 1.4 дэх заалтыг “Энэ журмын 1.2-д заасан этгээд нь цахим шуудан, цахим хуудас болон кибер орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулж болно.” гэж өөрчлөн найруулах; <i>Тайлбар: Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.3-т “кибер орчин гэж мэдээлэлд хандах, нэвтрэх, цуглуулах, түүнийг боловсруулах, хадгалах, ашиглах боломж олгож байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний орчныг” гэж томъёолсон байдаг.</i></p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1-тэй давхардаж байна гэж үзсэн бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 60.1.8-д заасны дагуу бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх ёстой үндэслэлээр тус заалтыг бүхэлд устгасан.</p>

<p>4. Төслийн хоёр дугаар бүлэгт “2.3. Сонгогчдын хувийн мэдээллийг хууль бус(цахим шуудан, утасны дугаарын лист үүсгэх)-аар цуглуулан сонгуультай холбоотой зар сурталчилгаа явуулахгүй.” гэсэн заалт нэмэх;</p>	<p>Журмын төслийн 2.6-д тусгасан.</p>
<p>5. Төслийн гуравдугаар дугаар бүлэгт “3.1.4. Нэр дэвшигчийн цахим хаягийн хөгжүүлэлт, мэдээлэл түгээж буй этгээд (Админ)-ийн мэдээлэл, хамаарал бүхий бусад цахим хуудсыг бүртгүүлэх. Мөн хамаарал бүхий бусад цахим хуудсыг бүртгэх.” гэж нэмж тусгах;</p>	<p>Журмын 3 дугаар зүйлд туссан.</p>
<p>6. Төслийн 4.1, 5.2-д заасан “шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх эрхтэй эсэхийг нягтлах; <i>Тайлбар: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7-д “энэ хуулийн 35.3, 47.4-т заасныг зөрчсөн талаарх гомдлын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо, тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн дараах арга хэмжээг нэн даруй авна” гэж зааснаас үзэхэд “шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” өргөдөл, гомдол хүлээн авч, хянан шийдвэрлэх эрхгүй байна.</i></p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48.13 дугаар зүйлд заасны дагуу эрх олгогдсон бөгөөд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.7 болон 48.7-д заасан хориглосон хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой гомдлыг Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөрчил шалган шийдвэрлэнэ.</p>
<p>7. Төслийн 4.1 дэх заалтад байгууллага тус бүрийн хариуцах зөрчил, гомдлын төрөл, хамрах хүрээ зэргийг нарийн тодорхой заах буюу “харьяаллын дагуу” гэх агуулгыг тусгах; <i>Тайлбар: Уг хэсэгт ерөнхий байдлаар тусгагдсан нь иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлууд байгууллага болгон дээр давхцах, тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй, замбараагүй гомдлууд ирэх зэргээр гомдол шийдвэрлэх үйл ажиллагаа, хугацаа зэрэгт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.</i></p>	<p>Журмын төслийн зургаадугаар зүйлд бүхэлд нь тусгасан.</p>
<p>8. Төслийн 4.5, 6.2.6-д заасан “цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч” нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүргүүлсэн мэдэгдлийн дагуу цахим орчин дахь мэдээ, мэдээлэл устгах, хандалтыг хаах, түр хязгаарлах, цахим хаяг, цахим хуудсыг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуустал хандалтыг хаах, түр хязгаарлах үүрэгтэй байхаар тусгасан нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг нягтлах; <i>Тайлбар: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8-д зааснаар үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаах үүрэг хүлээж байна.</i></p>	<p>Өөрчлөн найруулж журмын төслийн 7.4-т заасан. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад баримтлах зарчим нь сонгуулийн зарчим болон сонгуулийн сурталчилгаа явуулах зарчимд үндэслэж байгаа бөгөөд ялангуяа Монгол улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.3-т заасны дагуу нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглосон зохицуулалтын нөгөө талд цахим орчинд үйл ажиллагаа явуулагчидад үүрэг бий болж байна.</p>

<p>9. Төслийн 4.6.2-д заасан “Хуульд заасан технологийн арга хэмжээ авах.” гэх заалтад ямар хуульд заасан ямар технологийн арга хэмжээ авах тухай тодорхой тусгах;</p>	<p>Журмын төслийн 7.5-д тусгасан.</p>
<p>10. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн үүрэгт дараах үүргүүдийг нэмж тусгах. Үүнд:</p>	
<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 47.7-д заасан эрх бүхий байгууллагуудад шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх, технологийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцааг үзүүлэх;</li> </ul>	<p>Журмын төслийн 5.1.8-д туссан.</p>
<ul style="list-style-type: none"> <li>• Эцсийн хэрэглэгчийг тодорхойлох боломжтойгоор бүх төрлийн домэйн болон АйПи(IP) хаяг руу хандсан талаар лог бүртгэлийг 1 сарын хугацаатайгаар хадгалдаг байх;</li> </ul>	<p>Журмын төслийн 5.1.9-д туссан.</p>
<ul style="list-style-type: none"> <li>• Дугаар нууцлах, дуу хоолой өөрчлөх, түр сим олгох зэрэг зөрчил гаргахад ашиглагдаж болохуйц үйлчилгээнүүдээ 6.1.2-т заасан хугацаанд түр хаах;</li> </ul>	<p>Тусаагүй.</p>
<p>11. Цахим орчин ашиглан төлбөртэй зар сурталчилгаа явуулах, түүний ил тод байдлыг хангах талаар тусгах;</p>	<p>Журмын төслийн 5.3.1 болон 5.3.4-т тусгасан.</p>
<p>12. Хуурамч, бот хаягууд ашиглахгүй байх талаар зохицуулалтыг тусгах;</p>	<p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.4-т заасны бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг тус тус хориглодог тул журмын төсөлд давхардуулж зохицуулаагүй.</p>
<p>13. Сонгуулийн сурталчилгаа явагдаж эхэлснээс хойш үр дүн гарах хүртэл хугацаанд сонгуульд нэр дэвшигчтэй холбоотой Deep fake болон бусад технологид суурилсан хуурамч видео, аудио бичлэг хийсэн нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд тухайн дүгнэлтийг “Сонгуулийн ерөнхий хороо”-нд албан бичгээр хүргүүлэх. Дүгнэлтэй холбоотой мэдэгдэл, мэдээллийг “Сонгуулийн ерөнхий хороо”-ноос нийтэд ил тод байдлаар шуурхай хүргэдэг байх талаарх зохицуулалтыг нэмж тусгах.</p>	<p>Уг асуудлаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47-д эрх бүхий байгууллагаас дүгнэлт гаргах, түүнд үндэслэн хязгаарлалтын арга .хэмжээг авах талаар зохицуулаагүй</p>

Хоёр. Техникийн шинжтэй санал:



<p>1. Төслийн 2.2 дахь заалтыг “Сонгуульд нэр дэвшигчийн бүртгэлтэй цахим хаяг, цахим хуудас нь аливаа мэдээ, мэдээллийг нийтлэхдээ албан бус цахим хаяг, цахим хуудас, хэвлэлд нийтлэгдсэн мэдээллийг эх сурвалжаа болгон ашиглахгүй.” гэж өөрчлөн найруулах; Тайлбар: Сэтгүүл зүйн үг хэллэгийн дагуу ерөнхий хүрээгээр “хэвлэл” гэж оруулах нь зүйтэй.</p>	<p>Цахим орчинд зөвхөн хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулдаггүй тул хэт явцуулах боломжтой гэж үзсэн. Тусгаагүй. Зохицуулалтын хувьд өөр байдлаар өөрчлөн найруулсан.</p>
<p>2. Төслийн 3.1.3 дахь заалтыг “Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудасны бүртгэлийн хаяг, бүртгүүлсэн нэр, цахим шуудан, хамаарал бүхий этгээдийн (гэр бүл) утасны дугаар, цахим холбоос хаяг (URL хаяг), цахим хаяг хөтлөх ажилтнуудын мэдээлэл.” гэж өөрчлөн найруулах;</p>	<p>Журмын төслийн 3.2.2-т тусгасан.</p>
<p>3. Төслийн 3.2 дахь заалтыг “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн мэдээллийг бүртгэл хийснээс хойш нэг хоногийн дотор Харилцаа холбооны зохицуулах хороо болон Сонгуулийн ерөнхий хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.” гэж өөрчлөн найруулах;</p>	<p>Журмын төслийн 3.6-д тусгасан.</p>
<p>4. Төслийн 5.4 дахь заалтыг “Эрх бүхий байгууллагууд нь цахим орчин дахь хууль бус сонгуулийн сурталчилгаатай холбоотой санал, дүгнэлтийг цахим хэлбэр(цахим шуудан, систем, чат гэх мэт)-ээр даруй холбогдох газарт хүргүүлэх бөгөөд албан бичгийг шуудангаар хүргүүлнэ.” гэж өөрчлөн найруулах;</p>	<p>Журмын төслийн 4.3-д тусгасан.</p>
<p>5. Төслийн 5.5 дахь заалтыг “Эрх бүхий байгууллагууд нь энэ журмын 5.4-д заасан санал, дүгнэлтийг цахим шуудангаар хүлээж авсан даруйд холбогдох арга хэмжээг авч, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг санал, дүгнэлт гаргасан эрх бүхий байгууллагад нэн даруй хүргүүлнэ.” гэж өөрчлөн найруулах;</p>	<p>Журмын төслийн 4.6-д тусгасан.</p>
<p>6. Төслийн 6.1.8, 6.2.6 дахь заалтын "энэ хуулийн" гэснийг "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн" гэж өөрчлөн найруулах;</p>	<p>Өөрчлөн найруулагдсан.</p>
<p>7. Төслийн 6.1.1 дэх хэсэгт ажилтан 1 гэж заасан нь хүрэлцэх эсэх. “техникийн баг гаргаж ажиллуулна.” гэж өөрчлөн найруулах;</p>	<p>Өөрчлөн найруулагдсан.</p>
<p>8. Төслийн 7.1 дэх заалтын “олон нийтэд” гэснийг “өөрийн цахим хуудсанд” гэж өөрчлөн найруулах.</p>	<p>Журмын зохицуулалтын зорилгод хамаарахгүй тул хасагдсан.</p>

*Хавсралт 5. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журамд цагдаагийн байгууллагаас ирүүлсэн саналыг тусгасан байдал.*

1	Төслийн 1.1 дэх хэсгийг "Энэхүү журмаар Монгол Улсын бүх шатны Сонгуулийн үед цахим орчин ашиглан сурталчилгаа явуулах болон түүнд хяналт тавихтай холбогдон гарах харилцааг зохицуулна." гэж өөрчлөх;	Тусгаагүй. Зөвхөн Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 39.2.7-д заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.
2	Төслийн 2.1 дэх хэсгийг "Сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулахдаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл (нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа)-ийг олон нийтэд ойлгомжтой, нээлттэй ил тод харагдахуйц байдлаар байршуулж, бусдын нэр төр, алдар хүндэд халдсан, гутаан доромжилсон үйл ажиллагаа явуулахгүй." гэж өөрчлөх;	Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 35.3-д нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглосон зохицуулалт тусгагдсан тул давтан зохицуулахгүй байх үүднээс тусгаагүй.
3	Төслийн 2.2 дахь хэсгийг "Сонгуульд нэр дэвшигчийн бүртгэлтэй цахим хаяг, цахим хуудас нь аливаа мэдээ, мэдээллийг нийтлэхдээ албан бус цахим хаяг, цахим хуудас сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээллийг эх сурвалжаа болгон ашиглахгүй." гэж өөрчлөх;	Өөрчлөн журмын төслийн 2.2-т тусгагдсан.
4	Төслийн 3.1 дэх хэсгийг "Нам, эвсэл, нэр дэвшигч нь хуульд заасны дагуу сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хаяг, цахим хуудсаа аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ." гэж өөрчлөх;	Ойлгомжтой, тодорхой байлгах үүднээс өөрчилж тусгагдсан.
5	Төслийн 4.3 дахь хэсгийг "Энэ журмын 4.1-т заасан өргөдөл, гомдол, 4.2-т заасан албан бичиг дүгнэлтэд тухайн мэдээ, мэдээллийн цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг цаасан болон цахим хэлбэрээр хавсаргана." гэж өөрчлөх;	Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааны хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг хэсэгт тусгасан.
6	Төслийн 4.7 дахь хэсгийн "хүргүүлнэ." гэснийг "ирүүлнэ." гэж өөрчлөх;	Тусгаагүй.

7	Төслийн 5.4 дэх хэсгийг "Эрх бүхий байгууллагууд нь цахим орчин дахь хууль бус сонгуулийн сурталчилгаатай холбоотой албан бичиг, санал, дүгнэлтийг цахим хэлбэрээр даруй холбогдох газарт хүргүүлнэ." гэж өөрчлөх;	Агуулга журмын төслийн 4.3-т туссан.
8	Төслийн 5.5 дахь хэсгийг "Эрх бүхий байгууллагууд энэ журмын 5.4-т заасан албан бичгээр ирүүлсэн санал, дүгнэлт, шийдвэрийг цахим шуудангаар хүлээн авсан даруйд холбогдох арга хэмжээг авч, авсан арга хэмжээний талаарх Мэдээллийг тухай бүр шууд мэдэгдэнэ." гэж өөрчлөх;	Агуулга журмын төслийн 4.6-д туссан.
9	Төслийн 6.1.3 заалтыг "Сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлэхээс өмнө туршилтыг хийх, техник технологийн бэлэн байдлыг хангасан байх;" гэж өөрчлөх;	Агуулга журмын төслийн 5.1.3-т туссан.
10	Төслийн 6.2.6 дахь заалтыг "цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг хаах, эсхүл түр хязгаарлах арга хэмжээ авах." гэж өөрчлөх;	Журмын төслийн 7.5-д туссан.
11	Төслийн 6.3.2 дахь хэсгийн "Монгол Улсын Их хурлын" гэснийг хасах;	Тус зохицуулалт хасагдсан.
12	Төслийн 7.4 дэх хэсэгт "Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг нийтэд ил тод байлгах зорилгоор цахим хуудас ажиллуулна. Цахим хуудасны үйл ажиллагааг Сонгуулийн өрөнхий ." гэж нэмэх.	Тусгагдаагүй.